ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

2017.№01 (21)

Улирал тутмын
Онол-арга зүйн сэтгүүл



Улаанбаатар хот 2017 он



Н.ГАНТУЛГА
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн захирал,
хууль зүйн доктор,
профессор, хурандаа

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН “ҮНДСЭН ХУУЛЬД[1]” ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

“Хүний эрх” гэсэн нэр томьёо манай орны төрийн бодлогын баримт бичиг [2], хууль зүйн практикт хэрэглэгдэн хэвшсээр цөөнгүй жил болж байна.

Хэдийгээр Монгол Улс хүний эрхийн олон улсын тулгуур баримт бичгүүдэд [3] бүр 1970-аад оноос нэгдэн орсон боловч нийгмийн тогтолцоо, хөгжил, хүний эрхийн асуудалд хандах үзэл суртлын ялгаатай байдлаас шалтгаалан олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тэр бүр бүрэн дүүрэн хэрэгжүүлэлгүй явж ирсэн. Тухайлбал: хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, өмчлөгчийн эрхийн адил тэгш байдлыг хангах, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн эсрэг чиглэсэн мэдүүлэг өгөхгүй байх, эх орноо орхин явах зэрэг эрх үүнд юуны өмнө хамаарна.

Олон улсын гэрээний актууд хамрах хүрээ, агуулга, олон улсын зан заншлын хэм хэмжээтэй уялдан гэрээ, хэлэлцээр, конвенц, пакт, протокол, дүрэм (журам), үр дүнгийн баримт бичиг (төгсгөлийн баримт бичиг), тунхаглал, санамж бичиг гэсэн янз бүрийн нэртэй байхын зэрэгцээ хууль зүйн үр дагаварын хувьд ч хэм хэмжээ тогтоосон эсвэл зөвлөмж-удирдамж өгсөн хэмээн хуваагддаг.

Мөн хүний эрхийн олон улсын гэрээний тогтолцоонд хорих ял, түүнийг эдлүүлэхтэй холбоотой олон улсын гэрээний актууд онцгой байр эзэлдэг. Учир нь эдгээр баримт бичигт хууль зүйн дагуу хүний ямар эрхийг, хэзээ, хэрхэн, хэн, ямар хэмжээнд хасч, хязгаарлаж болох, эсэх асуудал бэхжсэн байдаг.

Тэгвэл энэ салбарын “Хоригдлуудтой харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”[4] нь

---

[1] “Үндсэн хууль” гэсэн нэр томьёог хашилтад хэрэглэсэн ба хорих ял эдлүүлэх эрх зүйд “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”-ийг дэлхий дахинаа энэ салбарын суурь баримт бичиг хэмээн удирдлага болгон хэрэглэж байгаа олон улсын практикийг иш үндэс болгосон.

[2] Хууль тогтоомж, эрх зүйн дэд акт гэсэн агуулгаар хэрэглэсэн.

[3] Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт зэрэг бусад

[4] Энэ баримт бичгийг Монгол Улсад хүний эрхийн асуудлаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд НҮБ-ын Хүний эрхийн төв, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид орчуулж, П.Эрдэнэбаяр хянан

хэдийгээр хэлбэрийн хувьд хууль зүйн заавал биелүүлэх үүргийг хүлээлгээгүй боловч түүнийг улс гүрнүүд "дэлхий дахинаа заавал хангах ёстой ерөнхий стандарт" буюу энэ салбарын тулгуур баримт бичиг ("Үндсэн хууль") хэмээн үнэлж хэрэгжүүлэх практик нэгэнт тогтжээ.

Иймд эрх зүйн энэ баримт бичиг, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүд, тэдгээрийг мэдээлэх, хэрэгжүүлэх чиглэлд манай орны хувьд нэн тэргүүнд хийвэл зохих арга хэмжээтэй холбоотой судлаачийн зарим саналыг холбогдох эрх бүхий байгууллага, иргэний нийгэмд хүргэх зорилгоор эрдэм шинжилгээний нийтлэл (өгүүлэл)-ийг бичиж агуулгыг нь тодорхойлсон.

тохиолдуулан анх "Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх" /УБ.1996 он/ эмхэтгэлд, мөн Д.Баярсайхан /Ph.D/, Т.Золбоо /LL.M/ нар "Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл"-д /УБ.2012 он/, түүнчлэн Хүний эрхийн үндэсний комисс "Монголын хорих байгууллагуудад хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг дэмжих төсөл"-ийн хүрээнд Европын холбоо, Чехийн хөгжлийн агентлагын санхүүжилтээр "Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл /хорих байгууллагын ажилтнуудад зориулсан, УБ.2014 он/-д тус тус монгол хэлээр хөрвүүлэн нийтэлсэн.

Баримт бичгийн нэр англи хэлнээ "*Standard Minimum Rules for the Treatment of Prisoners*", орос хэлнээ *"Минимальные стандартные правила обращения с заключенными*" гэж бичигддэг. //www.un.org/ru

I

Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд[5] бүтцийн хувьд удиртгал, хавсралтын 1-р хэсэг "Нийтлэг хэрэглэх дүрмүүд", 2-р хэсэг "Онцлог бүлгийнхэнд хэрэглэх дүрмүүд" бүхий 95 зүйлээс бүрдэж байсан.

Харин НҮБ-ын жишиг дүрмүүдийг баталсан 1955 оноос хойш олон улсын эрх зүй, ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухаан, дэлхийн улс гүрнүүдийн хууль зүйн практикт гарсан ололт дэвшил, өөрчлөлттэй уялдуулан нэмэлт өөрчлөлтөөр баяжуулан засварлах асуудал хэлэлцэгдэх болж улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2011 онд асуудлыг судлан төсөл боловсруулах Засгийн газар хоорондын нээлттэй бүрэлдэхүүнтэй шинжээчтэй баг байгуулах шийдвэр гарган энэ үйл хэрэгт НҮБ-ын бусад байгууллага, иргэний нийгмийг анхаарал хандуулан хувь нэмэр оруулахыг уриалсан.

Шинжээчдийн баг 2012-2014 онуудад НҮБ-ын Мансууруулах

[5]Энэ баримт бичгийг НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд гэж товчлон хэрэглэх олон улсын практик бий ба түүнийг 1955 онд Женев хотноо хуралдсан НҮБ-ын "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгчдэд хандах асуудлаарх 1-р их хурлаар батлаж, НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн зөвлөлийн 1957 оны 663 C(XXIY), 1977 оны 2076 (LXII) тогтоолоор сайшаасан. //www.un.org/ru

бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны [6] идэвхитэй оролцоо, хамтын ажиллагааны дүнд 3 удаагийн зөвлөлдөх уулзалтын явцад дүрмийг хянаж өөрчлөхөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн удирдамж болгон зөвлөсөн:

-а/ үйлчилж буй жишиг дүрмийн шаардлагыг бууруулахгүй байх, хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдэнтэй харьцах хүмүүнлэг нөхцлийг нэмэгдүүлэх,

-б/ дүрмийг хэрэглэж байгаа практик түвшинг дэмжих чиглэлийг баримтлан ихээхэн амжилтад хүрч өөрчлөлт оруулах асуудлын хүрээг тодорхойлж чадсан.

Мөн 2015 оны 03-р сард Өмнөд Африкийн Кейнтаунд зохион байгуулсан шинжээчдийн 4 дэх зөвлөлдөх уулзалтын үр дүнд “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд”-д нэмэлт өөрчлөлт оруулах бүх асуудлаар нэгдсэн зөвшилд хүрсэний гадна хүний эрх, тэгш байдал, ардчилалын төлөө тэмцэгч, 27 жил шоронд хоригдож байсан, Өмнөд Африкийн Бүгд найрамдах Улсын ерөнхийлөгч асан Нельсон Ролилахлы Манделаг хүндэтгэж, илэрхийлэл нь болгон энэ дүрмийг “Манделагийн дүрмүүд” гэж нэрлэхийг уриалсан.

Тэрчлэн Нельсон Манделагийн олон улсын өдрийг[7] шоронд хорих нөхцлийг улам бүр хүмүүнлэг болгох, хоригдлууд нийгмийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг ба хорих байгууллагын алба хаагчдын ажил үүрэг онцгой ач холбогдол бүхий нийгмийн ажил болохыг нийтэд улам бүр түгээн мэдээлэхэд илүү үр дүн өгсөн өдөр болгон өргөжүүлэхийг зөвлөсөн.

НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн эрх зүйн асуудал эрхэлсэн комисс болон НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл 2015 оны 05-р сард шинжээчдийн багийн төслийг хэлэлцэн дэмжиж улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2015 оны 12-р сарын 17-ны өдрийн 70/175 тогтоолоор “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд [8] ”-ийн нэмэлт өөрчлөлтийг баталсан.

II

Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн өөрчлөлт нь эрх зүйн энэ баримт бичгийн 35 орчим хувийг хамарсан ба тэдгээрийг дараах 9 сэдэвчилсэн чиглэлд хувааж болно. Энэ нь:

[6] Орос хэлнээ “Управление ООН по наркотикам и преступности /УНП ООН/”, англи хэлнээ United Nations office on drugs and crime /UNODC/ /www.unodc.org/

[7] 07-р сарын 18-ны өдөр

[8] НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийг “Нельсон Манделагийн дүрмүүд” гэж нэрлэхээр тогтсон.

1/ Хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэх

2/ Эрх чөлөө нь хасагдсан эмзэг бүлгүүд

3/ Эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн хамгаалал

4/ Хязгаарлалт, сахилга дэг журам, шийтгэлийн арга хэмжээ

5/ Хорих газар дахь нас баралт, эрүү шүүлтийн мөрдөн шалгах ажиллагаа

6/ Хууль зүйн туслалцааны нээлттэй байдал

7/ Гомдол хүсэлт, хараат бус шалгалт

8/ Нэр томьео

9/ Алба хаагчдын сургалт тус тус болно.

Манделагийн дүрмүүд[9] одоо удиртгал болон хавсралт, түүний 4 урьдчилсан тэмдэглэх хэсэг ба нийт 122 дүрмээс бүрдэж байна. Тодруулбал:

Нэг. Хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэх

Энэ асуудал НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 1-5 дүрэмд тусгалаа олсон. Бүх хоригдолд хэрэглэх дүрмийн I-р хэсэг нийт жишиг дүрмүүдийг ойлгож хэрэглэх 5 "үндсэн зарчим" бүхий өргөтгөсөн стандартыг хамрах болсон.

Хуучин дүрмийн II А хэсгийн хорих ял эдлэгчидтэй холбоотой томьёололууд эдгээр 5 зарчимд нэгтгэгдсэний зэрэгцээ энэ зарчмын агуулгад олон улсын эрх зүйн салбарын амжилтууд ч туссан. Тухайлбал, энэ зарчмууд дараах үүргүүдийг хүлээлгэсэн. Энэ нь:

-Хоригдол бүр эрхэм чанар бүхий бие хүн болохын хувьд хүндэтгэлтэй харьцаанд байх ёстой.

-Хоригдлууд эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцаанаас ангид, хамгаалагдсан байна.

-Хоригдлууд, албан хаагчид, хорих газар байгаа бусад хүмүүсийн байнгын хамгаалал, аюулгүй байдал хангагдсан байх ёстой.

Хоёр. Эрх чөлөө нь хасагдсан эмзэг бүлгүүд

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 2, 5(2), 39(3), 55(2), 109, 110 дүрэмд энэ асуудал туссан.

Алагчлалгүй хэрэглэх, яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл, үндэсний ба нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, язгуур гарлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон "Наад захын жишиг дүрмүүд"-ийн хуучин заалт "бусад ямар ч үндэслэлээр" гэсэн

[9] Энэ баримт бичгийг мөн "НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд" нэрээр хэрэглэж болно.

нэмэлтээр өргөжсөний зэрэгцээ хоригдлын шашны болон ёс зүйн итгэл үнэмшлийг хүндэтгэхийг үүрэг болгосон.

Ер нь үл ялгаварлан гадуурхах зарчим дараах үүргийг агуулгадаа багтаан туссан. Энэ нь:

-Хоригдлын, тэр дотроо эмзэг бүлгийнхний хувь хүний онцлог хэрэгцээг харгалзах;

-Онцлог хэрэгцээ бүхий хоригдлын эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах;

-Бие махбодь, оюун санаа, бусад байдлаар бэрхшээлтэй хоригдлын эрүүл мэндийн байдлыг харгалзан хорих газраас үзүүлдэг үйлчилгээнд бусадтай адил байдлаар бүрэн, үр дүнтэй хамрагдах нөхцлийг хангах ёстой.

Гурав. Эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндийн хамгаалал

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 24-27, 29-35 дүрэмд хоригдолд эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээ үзүүлэх нь төрийн үүрэг ба хоригдлууд эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээнд жирийн иргэдийн адил нэг стандартын хүрээнд хамрагдахыг тодотгосны зэрэгцээ хорих газарт үзүүлэх эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээний хэмжээ, бүрэлдхүүн хэсгийг заасан нэмэлт өөрчлэлтөөр баяжсан.

Түүнчлэн эмнэлгийн ажилтны эрх, үүргийг тодорхойлсон заалт нь эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүд ба хоригдол хоорондын харилцаа иргэний нийгэмд өвчтнүүдэд хэрэглэгддэг ёс зүй, мэргэжилийн адил стандартаар зохицуулагдахаар тодотгогдон бэхжсэн. Тухайлбал: эдгээр заалт нь дараах үүргийг өөртөө агуулсан. Энэ нь:

-Нийгэмд үйлчилж байгаа эмнэлэг-эрүүл ахуйн үйлчилгээний адил стандарт, тэр дотроо төлбөргүй үйлчилгээ аливаа ялгаваргүйгээр хорих газарт хэрэгжих;

-Хоригдлын, ялангуяа онцлог хэрэгцээ бүхий хоригдлын бие махбод, сэтгэцийн байдлыг үнэлэх, дэмжих, хамгаалах, сайжруулахад онцгой анхаарал хандуулах;

-Эмнэлгийн хараат бус байдал, эмчийн нууц, зөвшөөрснөөр мэдээллэх “эмч-өвчтөний харьцааны” болон эмчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх (ДОХ, сүрьеэ, нийгмийн бусад халдварт өвчин, мансуурах донг хамруулан), сувилах зарчмуудыг чанд сахих;

-Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус хэлбэрээр харьцах идэвхитэй болон идэвхитэй бус бүх төрлийн үйл ажиллагаанд эмнэлгийн ажилтнууд оролцохыг бүрэн хориглож, харин тийм үйл ажиллагааг баримтжуулж, мэдээлэх үүргийг тэдэнд дүрмийн нэмэлт өөрчлөлтөөр хүлээлгэсэн.

Дөрөв. Хязгаарлалт, сахилга дэг журам, шийтгэлийн арга хэмжээ

Жишиг дүрмүүдийн 36-39, 42-53 дүрэмд хоригдлын эрхийг хязгаарлах болон эрүүдэн шүүх, хүнлэг бус шинжтэй сахилгын шийтгэлийн шалгуур, үнэлгээний асуудал туссан.

Түүнчлэн сахилгын шийтгэлийн журмаар хоригдлыг хорих нийтлэг нөхцөл, хоригдлын мэдээлэл авах, танилцах эрх болон хоригдлыг ганцаарчлан хорьж сахилгын шийтгэл хүлээлгэх, номхруулах хэрэгсэл хэрэглэх явдлыг хязгаарласан, мөн хорих өрөө, хоригдлыг нэгжих үйл ажиллагааг зохицуулсан, эмнэлгийн ажилтнуудын сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаан дах үүрэг, оролцоог нэмэлт өөрчлөлтөөр тодотгосон. Тухайлбал, Шинэ дүрмүүд нь дараах зохицуулалтыг бий болгосон. Энэ нь:

-Нэг өдөрт хүмүүстэй харьцуулахгүйгээр 22 цаг ба түүнээс дээш хугацаагаар ганцаарчлан хорих нь (мөн энэ үйл ажиллагаа тасралтгүй 15 хоногийн турш үргэлжилбэл удаан хугацаагаар ганцаарчлан хорьсон гэж үзнэ) хоригдлын эрх чөлөөг хязгаарласанд тооцох[10] ба түүнийг онцгой тохиолдолд “тусгай” арга хэмжээ болгон хэрэглэнэ.

-Тодорхой бус хугацаагаар эсвэл удаан хугацаагаар ганцаарчлан хорих, гэрэлгүй харанхуйд эсвэл байнгын гэрэлтүүлэг бүхий өрөөнд хорих, хоол хүнс, ундны усны хувь хэмжээг багасгах, тэрчлэн мөн чанарын хувьд хүний эрхэм чанарыг гутаан доромжилсон, тэдэнд өвдөлт шаналгаа учруулагч, жишээбэл, дөнгө, гинж зэрэг номхруулах хэрэгслийг хэрэглэхийг хориглоно[11].

-Хоригдол, тэдний өрөө тасалгаанд нэгжлэг хийх, хорих байгууллагад аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгай хэрэгслүүдийг ашиглахтай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний бусад актын шаардлагыг биелүүлэх нарийвчлан журамласан удирдамжийг боловсруулах, энэ бүх тохиолдолд хоригдлын хүний эрхэм чанарыг хүндэтгэнэ.

-Эмнэлгийн ажилтнууд аливаа хэлбэрээр албадан тусгаарлагдсан хоригдлын эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах үүрэгтэй ба тэдэнд сахилгын шийтгэл хүлээлгэхэд оролцох ёсгүй.

-Зөрчилдөөнт нөхцөл байдлыг урьдчилан сэргийлэх, түүнийг бий болсон тохиолдолд шийдвэрлэх, зуучлагч оролцуулах

[10] НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 44 дүрэм.

[11] НҮБ-ын наад захын жишиг дүрмийн 43, 47 дүрэм

болон зохицуулалтын бусад сонгох механизмыг өргөн ашиглах хорих байгууллагын захиргааны үйл ажиллагааг урамшуулан дэмжих заалт тус тус болно.

Тав. Хорих газар дахь нас баралт, эрүү шүүлтийн мөрдөн шалгах ажиллагаа

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 6-10, 68-72 дүрэмд туссан. Энэ асуудлаар орсон өөрчлөлтийн гол агуулга нь хорих газарт нас барсан болон бусад ноцтой нөхцөл байдлын тохиолдол бүрт хараат бус мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах зохицуулалт юм.

Мөн харилцааны нээлттэй /тодорхой/, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор хорих газарт бүртгэн хөтөлдөг ялтны мэдээллийн жагсаалт, түүнчлэн ноцтой үр дагавар бүхий нөхцөл байдлын талаар хорих газрын захиргаанаас хоригдлууд, хараат бус этгээдүүдэд өгөх мэдээллийн жагсаалт ч өргөжсөн. Тухайлбал:

Дүрмийн өөрчлөлтүүд нь дараах асуудлыг хамарсан. Энэ нь:

-Хоригдлын хорих газарт ирсэнээс эхлээд хоригдох бүх хугацааны мэдээлэл тэдний хувийн хэрэгт тусах ёстой ба мэдээллийн нууцлал задрахгүй байх явдлыг хорих газрын захиргаа бүрэн хангах ёстой.

-Хоригдол, бусад холбогдох хүмүүс (гэр бүлийн холбоотой хүмүүс) түүнийг хаана хорьж байгаа болон шилжин очсон хорих газар, хүндээр өвчилсөн тухайгаа, мөн биедээ гэмтэл авсан, хоригдогч нас барсан талаарх мэдээллийг нэн даруй хүргэх, авах эрхтэй.

-Хорих газрын захиргаа хоригдол нас барсан, алга болсон, хоригдох хугацаанд биедээ хүнд гэмтэл авсан тохиолдол бүрт зохих мэдээллийг нэн даруй хараат бусаар тухайн үйл явдал, түүний шалтгааныг шуурхай, алагчлалгүй, үр дүнтэй мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад хүргэх ёстой.

-Хоригдлыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүнлэг бусаар хатуу ширүүн харьцсан тохиолдол бүрт албан ёсоор гомдол хүсэлт гаргасанаас үл шалтгаалан мөрдөн шалгах ажиллагааг явуулах ёстой.

Зургаа. Хууль зүйн туслацааны нээлттэй байдал

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 41, 54-55, 58-61, 119-120 дүрэмд энэ асуудал туссан.

Өмгөөлөгчийн хорих газарт байгаа үйлчлүүлэгч-хоригдолтой уулзах, мөн хоригдлын зөвлөгөө авах эрх НҮБ-ын жишиг дүрмүүдийн өөрчлөлтөөс өмнө зөвхөн мөрдөн шалгагдаж байгаа хоригдогчийн эрхийг хамгаалах

хүрээнд хамаарч байсан бол одоо бүх хоригдолд үйлчлэх болсны зэрэгцээ сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх явцад ч хоригдол хууль зүйн зөвлөгөө авах эрхтэй болсон.

Мөн дүрмийн өөрчлөлт нь хорих газарт нэвтрэн орж байгаа хүмүүс нэгжлэг хийх, мэдээлэл авах боломж, процедурын талаархи мэдээллийг авахаар туссан. Тухайлбал: хорих газрын захиргаа дараах үүргийг хүлээнэ. Энэ нь:

-Хорих газарт хоригдол ирснээр түүнд хууль зүйн зөвлөгөө-тусламж авах асуудлаарх мэдээллийг бичгээр нэн даруй өгөх ёстой.

-Хоригдолд өөрийн сонголтоор өмгөөлөгчтэй болон хууль зүйн туслалцаа үзүүлэх бусад хүнтэй уулзах хугацаа, нөхцлийг аливаа хүнд сурталгүйгээр, мэдээлэлд нь цензур тавилгүй, нууцлалыг нь бүрэн хангасан нөхцөлд явуулах зохих боломжоор хангах ёстой.

-Хоригдол өөрийгөө өмгөөлөх, хууль эрх зүйн туслалцаа авах эрхийг ялангуяа мөрдөн шалгах үйл ажиллагааны, тэр дотроо сахилгын ноцтой зөрчилд буруутгаж байгаа тохиолдолд олгох ёстой.

-Хорих өрөө болон хоригдолд хийх процедуртай адил журмаар хийх үзлэг нь нэр хүндэд нь халдах, зохих хэмжээнд хамгаалагдаагүй гэж тооцон татгалзвал тухайн хүнд үзлэг хийх, хорих газарт нэвтрүүлэхээс татгалзана.

Долоо. Гомдол хүсэлт, хараат бус шалгалт

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 54-57, 83-85 дүрэмд туссан. Шинэчлэгдсэн дүрмүүд нь хоригдол, тэдгээрийн өмгөөлөгчид тэдэнтэй харьцсан асуудлаарх гомдол хүсэлтийг саадгүй гаргах эрх болон хорих газрын захиргаа гомдол хүсэлтийг даруй хэлэлцэн шалгаж, хариуг өгөх явдлыг бэхжүүлсэн.

Мониторинг болон хянан шалгах салбарт хүрсэн томоохон ололт нь хорих газар, хорих байгууллагыг тогтмол хянан шалгах дотоодын болон гадны хоёрдмол тогтолцоо бүхий механизмыг бий болгосон явдал мөн. Тухайлбал, шинэ дүрмүүд дараах журмыг тогтоосон. Энэ нь:

-Хоригдол, түүний өмгөөлөгч гомдол хүсэлт гаргах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд хоригдогчийн гэр бүлийн гишүүд, мөн нөхцөл байдлыг мэдсэн хэн ч тухайн асуудлаар гомдол хүсэлт гаргах эрхтэй.

-Хэрвээ гомдол хүсэлт гаргагч, түүний энэ үйл ажиллагаа ямар нэгэн өс хонзон, айлган сүрдүүлэлт, бусад сөрөг

нөлөөллөөс ангид, аюулгүй, нууцлалыг хангасан түвшинд явагдахыг хүсч хандвал хэрэгжих баталгааг хорих газрын захиргаа хангах ёстой.

-Хорих газар, хорих байгууллагын үйл ажиллагааг тогтмол хянан шалгах хоёрдмол тогтолцоог бүрдүүлэх ёстой ба энэ нь хорих газрыг удирдах төв байгууллагаас явуулах дотоодын, мөн хорих газрын захиргаанаас ангид, хараат бус байгууллагаас явуулах гадны хяналт шалгалт болно.

-Хянан шалгах эрх бүхий ажилтнуудад өөрийн үүргийг бүрэн дүүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь зориулан хорих газрын бүх мэдээлэлтэй танилцах, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг өөрийн санаачлагаар хийх, нууцлалыг хангасан түвшинд хоригдол, хорих газрын ажилтнуудтай уулзах эрхийг олгох ёстой.

Найм. Нэр томьёо

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд дэх нэр томьёоны шинэчлэл нь олон улсын эрх зүйн салбарт гарсан өөрчлөлттэй холбоотой ба эмнэлэг-эрүүл ахуй, жендерын болон уламжлалт бус эрхийн асуудалтай холбогдсон.

Ес. Алба хаагчдын сургалт

НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийн 76-76 дүрэмд тусгалаа олсон. Шинэ дүрмүүд нь иргэдийг ажилд авахад орон нутгийн нөхцөлд дасан зохицох сургалтад хамруулах, мөн алба хаагчдаас алба хаах явцад тэдэнд хүлээлгэсэн нарийн төвөгтэй үүргүүдийг бүрэн дүүрэн, хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломж, хэрэгслээр хангасан нөхцөлд зохион байгуулагдахыг бэхжүүлж өгсөн. Түүнчлэн сургалтын анхны /удиртгал/ хичээлүүд нь оролцогчдын онол, практикийн мэдлэгийг шалгасан дараах сэдвийг зайлшгүй хамрах ёстой. Энэ нь:

-Холбогдох улс гүрний дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний акт төрийн бодлого, тэрчлэн хорих байгууллагын алба хаагчийн үйл ажиллагаа, хоригдлуудтай харьцахдаа удирдлага болгон хэрэгжүүлэх олон улсын ба бүс нутгийн эрх зүйн баримт бичиг;

-Хоригдол бүрийн хүний эрхэм чанарыг хүндэтгэх, тэдэнтэй хүнлэг бус, хэрцгий догшин харьцахыг хориглох зэрэг хорих байгууллагын алба хаагчдын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах эрх, үүрэг;

-Хамгаалах ба аюулгүй байдлыг хангах сургалт, мөн

тусгай хэрэгслийг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хэрэглэх, хүч хэрэглэхийн өмнө боломжтой бүх тохиолдолд сануулга өгөх;

-Бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, сэтгэц-нийгэмшлийн шаардлагатай хоригдолд нийгмийн зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэдлэг, ур чадвар, практик дадал эзэмших явдал болно.

Энэ бүгдэд үндэслэн Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд нь өнөө цаг үеийн эрх зүйн шинжлэх ухааны ололт амжилт, дэлхийн улс гүрнүүдийн шилдэг туршлагыг тодорхой түвшинд нэгтгэсэн салбарын тулгуур баримт бичиг болохыг дахин нотлохыг хүслээ.

Иймд судлаач эрх зүйн энэ баримт бичгийн талаархи мэдээллийг нийгэмд бодитой, бүрэн дүүрэн хүргэх зорилгоор нэн даруй дараах арга хэмжээг авах ёстойг санал болгож байна. Энэ нь:

1. Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүдийг нэмэлт өөрчлөлтийн хамт захиалгын үндсэн дээр мэргэшсэн орчуулагч, хуульчдын хамтын багаар хөрвүүлүүлэн, ГХЯ, ХЗДХЯ хянаж, хөрвүүлгийг англи,

2. орос хэлний [12] бичвэрийн хамт хэвлэж[13] хууль тогтоох,

хэрэгжүүлэх болон сургалт, судалгааны бусад зорилгоор ашиглах практикийг тогтоох.

3. Шаардлагатай гэж үзвэл энэ жишиг дүрмүүдийг нийтэд хүргэхэд НҮБ-ын Мансуурах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанд (UNODC) хандан техникийн туслалцаа, бусад дэмжлэгийг авах.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад Хоригдлуудтай харьцах жишиг дүрмүүдийн холбогдох хэм хэмжээг /ялангуяа, хоригдлын эрхийн хязгаарлалт, тэдэнд шийтгэлийн арга хэмжээ ноогдуулах, гомдол хүсэлтийг нь хүлээн авах, хянан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа авах, хорих байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих зэрэг/ тусгах шаардлага байна.

[12] НҮБ-ын албан ёсны хэл учир тэдгээр хөрвүүлгийн хамт хэвлэвэл олон талын ач холбогдолтой гэж үзэж байна.

[13] Энэ цаг үе дэхь нийтийн хүрээнд байгаа мэдээлэл, судалгааны бусад эх сурвалжаас үзвэл “Хоригдлуудтай харьцах НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”-ийн нэмэлт өөрчлөлтийн талаархи мэдээлэл манай оронд бараг байхгүй байна.



Б.БАЯСГАЛАН
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн эрхлэгч, хурандаа

ХОРИХ БАЙГУУЛЛАГААС ОРГОСОН ЯЛТАН, ХОРИГДОГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Хорих байгууллагаас оргосон ялтан, хоригдогчийг ил хэлбэрээр эрэн сурвалжлах ажиллагааны дараалал, цаашид анхаарах асуудлын талаар судлаачийн байр, сууринаас өөрийн бодлыг энэхүү өгүүлэлээр илэрхийлэхийг оролдсон болно.

Түлхүүр үг: Оргох, эрэн сурвалжлах, хорих анги, хорих байгууллага, хамтын ажиллагаа, ялтан, хоригдогч, ил арга хэмжээ, ердийн ажиллагаа, эрэн сурвалжлах лавлагаа, интерпол.

Монгол Улсын эрүүгийн ялын оногдуулалтын илрэл нь шүүх эрх мэдлийн хүрээнд явагдаж, эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаагаар дамжин хэрэгждэг билээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн эрүүгийн ялын бодлогын хэрэгжилтийг хангаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг нийгмээс тусгаарлаж иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх явцад ялтан, хоригдогсдын зүгээс хорих анги, баривчлах, цагдан хорих байрны харуул хамгаалалтын ажилтны хариуцлаггүй байдал, ялтны ажлын байр, үйлдвэрлэлийн онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах, харуул хамгаалалтын албан хаагчийн амь бие, эрүүл мэндэд халдах арга замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдсээр байна.

Хэдийгээр нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагаад хорих байгууллагын харуул хамгаалалт нь үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг гаралтыг бууруулж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар Шүүхийн шийдвэрг гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд: 2012 онд-18, 2013 онд-10, 2014 онд-10, 2015 онд-3, 2016 онд-2 болж оргох гэмт хэрэг үйлдэгдэж буурсан [1] үзүүлэлт гарч байгаа нь сайшаалтай хэдий ч бүрэн таслан зогсоож чадахгүй байна.

[1] “Тогтоол гүйцэтгэх газрын 2016 оны тайлан”-аас

Академич С.Нарангэрэл Оргох /англ. *escare, flight*, ор. *побег*/-1. сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс хууль бусаар зайлсхийж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зогсооход чиглэгдсэн үйлдэл; 2. МУ-ын ЭХ-ийн 261 дүгээр зүйлд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан шүүх, цагдан хорих, хорих ангийг дур зоргоороо орхисон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг. [2] гэж тодорхойлсон байна. Харин судлаач миний өөрийн зүгээс **Хорих байгууллагаас оргох гэдэг нь** хорих анги, цагдан хорих болон баривчлах ял эдлүүлэх байрны амьдралын болон үйлдвэрийн бүсээс харуул хамгаалалтын албан хаагчдын сонор сэрэмжгүй байдлыг ашиглах, харуул хамгаалалтын техник тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, албан хаагчийн амь биед хүч хэрэглэн халдан довтлох зэрэг аргаар хорих ял эдлэхээс зайлсхийх санаа бодлоо гүйцэтгэж байгааг ойлгоно. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанаас санаатайгаар зайлсийх үйлдлийг оргох [3] гэж тодорхойлж болох юм.

Оргох гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын хувьд онц хүнд байдаг нь дараахь байдлаар илэрдэг.

Үүнд:

1. Оргосон этгээд дахин гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр

2. Хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг

3. Нийгмийг айдаст автуулдаг

4. Оргох явцдаа харуул хамгаалалтын техник тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэх, албан хаагчийн амь биед хүч хэрэглэн халдан хүнд хор уршиг учруулах зэрэг хор уршгийг учруулдаг байна. [4]

Иймээс нийгэм, иргэдийн аюулгүй байдлыг хангахын тулд хорих байгууллагаас оргосон этгээдийг эрэн сурвалжлан, цаг алдахгүй баривчлах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн үүрэг билээ.

Оргох гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь Хорих байгууллагаас сэжигтэн, яллагдагч, ялтан оргосон тохиолдолд хууль

[2] С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” 2011 он 349 дүгээр тал

[3] Б.Баясгалан “Хорих байгууллагаас оргосон этгээдийг гүйцэтгэх ажлын шугмаар эрэн сурвалжлах ажиллагааг боловсронгуй болгох нь” 2010 он 5 дахь тал

[4] С.Жанцан “Эрүүгийн эрх зүй” 2005 он 152 дахь тал

тогтоомжийн хүрээнд оргодлыг эрж олох, хайх, илрүүлэн баривчлах эрх бүхий байгууллагууд, ажилтнуудын бие даасан үйл ажиллагаа юм.

Эрэн сурвалжлах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх тангуулын ажлын нэг хэсэг болгон авч үзэх бүрэн үндэслэлтэй билээ. Гүйцэтгэх ажлын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад “...урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах...” [5], “...хуульд заасан үндэслэлээр гүйцэтгэх ажил явуулах;... [6] гэж хуульчилж өгсөн.

Эрэн сурвалжлах ажиллагаа нь өөрийн онол, арга барил, зүйн тогтолтой бөгөөд эрэн сурвалжлах ажиллагааны тодорхойлолт, түүний зорилго, зохицуулах зүйлийг эрдэмтэн судлаач нар судалгааны ажил, ном зохиолдоо тодорхойлжээ. Академич С.Нарангэрэл: Эрэн сурвалжлах гэдэг нь мөрдөлт ба шүүхээс оргосон этгээдийг илрүүлэх, байгаа газрыг нь тогтоох, ял эдлэхээс зайлсхийсэн шүүгдэгч буюу хорих газраас оргосон ялтныг олоход чиглэсэн төрийн эрх хэмжээ бүхий /хэрэг бүртгэх мөрдөн байцаах зэрэг/ байгууллагын үйл ажиллагаа юм. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой бус бол түүнийг тогтоох арга хэмжээ эрэн сурвалжлах ойлголтонд хамаарахгүй бөгөөд гэмт хэргийг мөрдөх ба илрүүлэх агуулгатай болно [7] гэжээ.

Хорих байгууллагаас оргосон оргодол этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг нь: Хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих төв /байр/-наас оргосон этгээдийг орогнож, нуугдах боломжийг илрүүлж, олж баривчлахад чиглэсэн Гүйцэтгэх ажлын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актад тулгуурласан гүйцэтгэх ажлын нууц далд болон ил арга хэмжээнүүдийн нэгдсэн тогтолцоо юм. Тиймээс судлаачийн зүгээс илээр эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад анхаарах зарим асуудлыг хөндөхийг зорисон билээ. Ил буюу ердийн арга хэмжээ ч гэсэн мэдээлэгчийг нууцлах шаардлагатай байдаг. Зарим судлаач энэ талаар дурдсан байна.Тухайлбал: Эрэн сурвалжлах ердийн ажиллагаа. Үүнд гүйцэтгэх тагнуулын хүч, арга хэрэгслийг ашиглахгүйгээр гүйцэтгэж буй арга

[5] “Гүйцэтгэх ажлын тухай хууль” 9.1.4 дүгээр зүйл

[6] “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” 134.1.1 дүгээр зүйл

[7] С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” 2008 он 623 дэх тал

хэмжээнүүдийг ойлгоно. Гэвч ердийн ажиллагаа нь обьектоос нууцлах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл ердийн эрэн сурвалжлах ажиллагаа ч тодорхой хэмжээгээр нууцлалыг шаарддаг байна. [8]

Ил арга хэмжээнд хорих анги, байгууллагаас орголт гарсан анхны мэдээг хүлээж авмагц доорхи арга хэмжээг авна. Үүнд:

- Оргодол этгээдийн ул мөрийг илрүүлэх, бэхжүүлж авч, хэргийн газрыг хамгаалалтанд авна.
- Оргосон, цаг хугацааг тодорхойлно.
- Оргодлын тоог тогтооно.
- Зэвсэглэсэн эсэхийг тодорхойлно.
- Унаажсан эсэхийг тодорхойлон тухайн газар орон, үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан төв зам, шалган нэвтрүүлэх цэг, тээврийн хэрэгслийн зогсоолуудад отолт, боолт, хийх, олон нийтийн газруудыг шалгах, **орогнож нуугдаж болох газруудыг самнах** зэргээр ил арга хэмжээг шуурхай зохион байгуулна. **Удирлага зохион байгуулалтын хүрээнд**:
- Оргодол этгээдийн талаархи эрэн сурвалжлах лавлагаа гаргана.

Эрэн сурвалжлах лавлагаанд доорхи мэдээллүүд багтана. 3 талаас харуулсан фото зураг, биеийн байцаалт, гадна төрх байдал, содон шинж тэмдэг, оршин сууж байсан гэрийн хаяг, оргох үедээ өмсөж явсан хувцас, мэргэжил, авьяас чадвар, гэр бүл, садан төрөл, найз нөхөд, гэмт хэрэг хамтран үйлдэгсдийн оршин суух хаяг, урьд өмнө нь ажиллаж байсан албан газар, бусад орогнож болох газрууд гэх мэтийг тодорхойлно.

- Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах төлөвлөгөө боловсруулна.

Төлөвлөгөөнд эрэн сурвалжлах ажиллагаа явуулах маршрут, хүрээ, тойрог, оролцох хүн хүчний тооцоо, зэвсэг, тусгай хэрэгсэл, ямар тээврийн хэрэгсэл, уналага, хэдий хугацаанд заагдсан газар оргодол этгээгээдээс түрүүлж хүрч отолт хаалт хийх, эрэн сурвалжлах ажлын шатахуун хүнсэнд зарцуулах зардал, мөрдөн мөшгөх, самналт хийх газар зэргийг тодорхой тусгаж өгнө.

- Эрэн сурвалжлах бүлгүүдийг томилж дэвшүүлсэн таамаглалын дагуу орогнож нуугдаж болох газар, орон байрыг шалгана.
- Орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэж олшруулсан эрэн сурвалжлах лавлагааг хүргүүлэх.

[8] “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүл 2015 он УБ, 02, 03 дугаар 27 дахь тал

- Эрүүлжүүлэх байр болон албадан саатуулах газруудыг шалгах.

- Оргодол этгээдийн талаар иргэд, байгууллагад зарлаж анхааруулах. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэж оргодлын талаархи мэдээллийг худалдан авах ажиллагаануудыг шуурхай зохион байгуулна.

Эрэн сурвалжлах лавлагааг үнэн зөв гаргахад хорих анги, байгууллагын тоо бүртгэлийн алба, нийгэм, сэтгэл зүйн алба чухал үүргийг гүйцэтгэнэ. Тухайн оргодол хорих анги, цагдан хорих байр /төв/-анд хувиарлагдан ирэхэд тоо бүртгэлийн алба уг ялтны талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, биеийн байцаалт, содон шинж тэмдэгийг бүртгэн хувийн хэрэг нээдэг, энэхүү хувийн хэрэг материал нь тухайн этгээд ял эдэлж, албадан саатуулагдаж байх хугацаандаа оргосон тохиолдолд эрэн сурвалжлах лавлагаанд орох мэдээллийн эх сурвалж нь болж өгдөг. Иймээс ялтны хувийн хэрэгт байвал зохих материалыг баяжуулж байх нь эрэн сурвалжлах ажиллагаанд чухал ач холбогдолтой. Цагдан хоригдож, ял эдэлж байгаа хүмүүст нийгэм, сэтгэл зүйн алба үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээ үзүүлэх явцдаа тухайн хүний хувийн байдал, сэтгэл зүйн байдлыг тодорхойлсон байдаг тул зарим хувь хүний шинжтэй мэдээллүүд авагдсан байдаг.

Эрэн сурвалжлах ажиллагааг цар хүрээгээр нь:

- Орон нутагт зохион явуулах ажиллагаа

- Улсын хэмжээнд зохион явуулах ажиллагаа

- Олон улсын хэмжээнд зохион явуулах ажиллагаа гэж ангилна.

Оргодол этгээдийг орон нутгийн хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Аймаг, орон нутгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон цагдан хорих байрнаас оргодол оргосон тохиолдолд хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны даргын тушаалаар батлагдсан шуурхай бүлэг, эрэн сурвалжлах бүлэг эрэн сурвалжлах ажлыг тухайн нутаг дэвсгэрт бүсчлэн шуурхай зохион байгуулна. Энэ төрлийн эрэн сурвалжлах ажиллагаанд оролцож байгаа ажилтан тухайн газар орноо сайн мэддэг, нутгийн иргэдийг таньдаг байх нь эрэн сурвалжлах ажлын үр дүнд нөлөөлдөг. Орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хууль хяналтын байгууллагатай урьдчилан төлөвлөсний дагуу ажиллаж, дэмжлэг авахын зэрэгцээ

оршин суугаа иргэдийн мэдээ, мэдээллийг өргөнөөр ашигладаг байна. Харин тухайн оргодол этгээдийн оршин сууж, ажиллаж, амьдарч байсан орон нутагт эрэн сурвалжлах ажиллагааг явуулахад нутгийн иргэд оргодол этгээдийг нууж хайцайлах, худал мэдээлэх, эрэн сурвалжлах ажиллагааг төөрөгдүүлэх гэх мэт хүндрэл бэрхшээлүүд гардаг онцлогтойг анхаарах хэрэгтэй.

Оргодол этгээдийг улс орны хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулагдах ба орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагаа үндсэн зорилгодоо хүрээгүй, тухайн этгээд нийгэм иргэдэд аюул учруулж болзошгүй, эрэн сурвалжлах арга хэмжээг цаашид өргөтгөн улс орон даяар зохион байгуулах шаардлагатай болсон үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар өөрийн хүч, хэрэгслээр эрэн сурвалжлах ажиллагааг улс орны хэмжээнд зохион байгуулна. Өөрөөр хэлбэл системын хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаанд хамрагдаж оролцоно гэсэн үг юм. Оргодол этгээдийг улсын хэмжээнд эрэн сурвалжлаж байгаа тохиолдолд Эрүүгийн цагдаагийн газрын 6 дугаар хэлтсээр дамжуулан улсын хэмжээний эрэн сурвалжлалт зарладаг.

Улс орны хэмжээгээр зохион байгуулж буй эрэн сурвалжлах ажиллагаанд хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал юм.

Оргодол этгээдийг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагаа:

Улс төр, цэргийн, шашин шүтлэг ба арьсны өнгөөр ялгаварлах шинжтэй гэмт хэргийн учир ялтан дээр Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын эрэн сурвалжлалтыг зарлахгүй. Хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллагдаж байгаа яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан бол Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын эрэн сурвалжлалтыг зарлана.

Хорих ялаар шийтгэгдсэн нөхцөлд эрүүгийн ял шийтгэл эдлэхээс зайлсхийгчид ба оргосон ялтныг Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын хэмжээний эрэн сурвалжлалтаар зарлана. Хэрэв аль нэг улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу нийгэмд аюултай үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй хэрэгт яллагдаж байгаа буюу яллагдсан хүн дээр тэр улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлалтын арга хэмжээ

зохиох шаардлага гарсан тохиолдолд Интерполын шугамаар олон улсын хэмжээний эрэн сурвалжлалт зохион байгуулахыг татгалзаж болно.

Яллагдагч ба ялтан дээр Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын хэмжээний эрэн сурвалжлалт зарлахад заавал байх нөхцөл бол эрэн сурвалжлагдаж байгаа хүн цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байх ёстой.

Оргож нуугдсан яллагдагч ба ялтнуудыг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлахын хамт эрэн сурвалжлалтыг санаачлагч байгууллагаас тогтсон журмын дагуу Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газарт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг хилийн байцаан өнгөрүүлэх газруудаар улсын хил нэвтрэх эсэхэд хяналт тогтоож, уг этгээдийг хил дээр саатуулах, баривчлах ажиллагаа зохион байгуулах тухай хүсэлтийг явуулна.

Интерполын Үндэсний төв товчоогоор дамжуулан ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлах нь ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах үндэслэл бүхий тогтоолын үндсэн дээр хийгдэнэ.

Ялтныг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлахаар зарлах тухай тогтоол нь эрэн сурвалжлагдаж байгаа ялтны оршин байгаа газрыг тогтоох зорилгоор Интерполын шугамаар олон улсын эрэн сурвалжлалтыг зарлан явуулах үндэс болно.

Ялтныг баривчлах ба шилжүүлэн өгөх зорилготой олон улсын эрэн сурвалжлалтыг Интерлолын үндэсиий тев товчоогоор дамжуулан зарлана.

Ялтныг шилжүүлэн өгөх тухай албан ёсны хүсэлтийг явуулахын өмнө тэднийг баривчлах, эрэлт шаардлагын хамт Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас Интерполын шугамаар гадаад улсуудын эрх мэдэл бүхий байгууллагад хандаж өгөх даалгавар нь яллагдагч, ялтныг баривчлах ба шилжүүлэн өгөх зорилго бүхий олон улсын эрэн сурвалжлалт зарлах үндэслэл болно. [9]

Дүгнэлт:

Монгол Улс нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хэрээр гэмт үйлдлийн арга нарийсч илүү хор аюултайгаар өөрчлөгдөн, улам зохион байгуулалттай, нийгэм эдийн засаг, улс төр, бизнесийн салбар түүнчлэн эрүүгийн гэмт

[9] М.Цогтоо ТЕГ-ын сөрөх тагнуулын үйл ажиллагааны үндэс

хэрэгтнүүдийг хамарсан шинэ өнгө аяс бүхий бүлэглэлүүд үүсч эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсээр байна. Тиймээс хорих байгууллагаас ялтан, хоригдогсдыг зохион байгуулалттай оргуулах гэмт хэрэг гарах магадлал өндөр байгааг анхаарч үзэн хорих байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх сөрөг арга хэмжээнүүдийг авах бэтгэлтэй байх.

Даяаршиж өнөө үед эрэн сурвалжлах ажиллагаа нь зөвхөн нэг улсын асуудал бус олон улсын хэмжээнд хууль хяналтын байгууллагуудын анхаарлыг татсан асуудал бөгөөд эрэн сурвалжлах ажиллагаанд олон улсын байгууллага Интерпол тэдгээрийн салбар байгууллагууд оролцдог болоод байна. Хууль хяналтын байгууллагаас оргодол этгээд нуугдахын тулд хилийн чанадад янз бүрийн арга хэрэглэн гарах, гадаад улс оронд оргонох явдал түгээмэл болсныг анхааралдаа авч цаашдын ажиллагаандаа тусган ажиллах хэрэгтэй болжээ судлаачийн байр сууринаас үзлээ.



Л.АЛТАНСҮХ
ХСИС-ийн ХСУА
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
удирдлага, стратегийн
профессорын багийн
профессор, хурандаа

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ СИСТЕМЧЛЭХ ТУХАЙ

Хураангуй: Манай орны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд үндэсний эрх зүйн шинэ тогтолцоо бүрэлдэн тогтож байгаа энэ үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа актуудын нийт актуудын дотор нэг, эсвэл хэд хэдэн зүйл заалт, хэсэг хүчин төгөлдөр хэвээр байгаа нэг харилцааг зохицуулж байгаа олон тооны актууд өөрөөр хэлбэл: "актын хэсгүүд" хэвээр хадгалагдсаар байна. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа актуудыг консолидацлах, нэг төрлийн харилцааг зохицуулж байгаа актуудыг нэгтгэн нэг том актад нэгтгэх асуудал нь хууль тогтоомжийг журамлах ажиллагааны үндсэн чиглэлийн нэг болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулахад нэгдүгээрт хууль тогтоомжоор хүлээлгэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан нийтээр дагаж мөрдөх журмыг боловсронгуй болгох, хоёрдугаарт байгууллагын дотоод журмыг хөгжүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д: "Агентлагийн хэмжээнд агентлагын даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө"[1] гэж заажээ. Энэ зохицуулалт нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны журмыг баталж мөрдүүлэх эрх зүйн үндэс болохын зэрэгцээ аливаа байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нэгэн хүчин зүйл гэдгийг судлаачид, Монгол Улсын тэргүүлэх зэргийн эрдэмтэд илэрхийлдэг.

Дэлхийн улс орнуудын хууль сахиулах байгууллагууд нь үйл ажиллагаагаа зохион байгуулах, хяналт тавих, алба хаагч үүргээ гүйцэтгэх явцад урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдалтай тулгарсан үед түүнийг хяналтандаа авах, шийдвэр гаргах зааварчилгаагаар хангах, алба хаагч зайлшгүй хийж гүйцэтгэх, эсхүл хийж болохгүй үйлдэл, тохиромжтой шийдвэр гаргах чадвартай болгох

[1] http://www.legalinfo.mn/

асуудалд онцгой анхаарч тухайн байгууллагын үйл ажиллагааны стандарт журмыг /дээр дурьдсанчлан манай улсын хуулиар хөдөлмөрийн дотоод журам/ гаргадаг байна.

Цагдаагийн байгууллага нь энэхүү үйл ажиллагааны стандарт журмаа 2011 онд боловсруулан гаргасан байна.

Цагдаагийн байгууллага үйл ажиллагааны дүрэм журмаа боловсруулан системчлэхдээ Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад судалгаа хийж, цагдаагийн байгууллагад 90 гаруй хуулиар хүлээлгэсэн 160 гаруй хэм хэмжээг хэрэгжүүлэх болон урьд цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагааг зохицуулж байсан дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, бичиг баримтыг нэгдсэн стандартад оруулах замаар 9 бүлэг 256 журмыг системчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам 2017 оныг "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээний жил" болгох зорилт дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилттой уялдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2017 онд “Эрх зүйн орчинг боловсронгуй болгох” зорилт дэвшүүлсэн байна.

Монгол Улсад одоогоор 590 гаруй хууль батлагдан хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үйл ажиллагаандаа 13 орчим хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлиг, Засгийн газрын 13 тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 4, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан 31, ШШГЕГ-ын даргын тушаалаар баталсан 74 орчим заавар, журмыг мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-д: “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.”, 5.2.11-д: “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ.”, 5.4.1-д: “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.”[2] гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын

[2] http://www.zasag.mn/news/khotolbor

төслийг боловсруулан, УИХ-аар батлуулахаар өргөн барьсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Хууль зүйн сайдын 2016 оны А/121 дүгээр тушаалаар “ШШГБ-ын хөгжлийн стратеги хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлаж, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилгодоо “Эрх зүйн орчныг боловсронгуй болгох,...” гэж тодорхойлоод, эдгээр зорилтуудыг 2016-2026 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн, төсөв, арга хэмжээний зардлыг төлөвлөсөн байна. Ингэж хэрэгжүүлснээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар хүлээсэн үүргээ чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, “шийдвэр гүйцэтгэх ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй болж, иргэдэд түргэн шуурхай үйлчилж, шүүхийн шийдвэр нэг мөр хэрэгжинэ.[3]” гэж заажээ.

Аливаа байгууллага төрийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн стратеги хөтөлбөр зөв тодорхойлон түүнд хүрэх дунд болон урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлснээр хүссэн үр дүндээ хүрч тухайн байгууллагын үндсэн үүрэг биелэгдэнэ. Хөтөлбөрөө хоосон уриа шинжтэй байлгахгүйн тулд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, бодлогын, эдийн засгын гэх мэт дэмжлэгийг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг.

Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ ШШГЕГ нь улсын төсөв болон зарим стратегийн зорилтыг өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар дотоод эх үүсвэр бүрдүүлж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р зорилтод “ШШГЕГ-т эрх зүйн актуудын нэгдсэн сан бий болгох[4]” арга хэмжээг авч хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, тус байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан эрх зүйн актуудын өөрчлөлт, шинэчлэлт, ном, сурах бичиг болгон бусад шаардлагатай мэдээллээр алба хаагчдыг цаг тухайд нь хангахаар тусгасан байна.

Төрийн албан хаагчийн хариуцлагыг сайжруулах хэрэгтэй байна, төрийн албаны үйл

[3] ШШГБ-ын хөгжлийн стратеги хөтөлбөр. УБ., 2016.

[4] Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох хэрэгтэй байна гэх шүүмжлэл, яриа өгүүлэл бүрийн цаана төрийн албан хаагчийн албан тушаалын хариуцлага бүдгэрч, ёс зүй доройтож, мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил дутагдал ихсэж, гэмт хэрэг, зөрчил ч үйлдэгдэж байгаа хэрэг.[5]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2016 оны жилийн эцсийн байдлаар гаргасан тайланд “Хорих анги, алба, салбар нэгжийн алба хаагчдын гаргасан зөрчил, оногдуулсан сахилгын шийтгэлийн судалгаа” [6] -гаар ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил гаргасан тайланд хамрагдсан алба хаагчдын 8.5 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулсан байна. Сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын гаргасан зөрчлийг төрөлжүүлэн үзвэл:

- Ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй -51 %;
- Цэргийн сахилгын дүрэм зөрчсөн -2 %;
- Ёс зүйн зөрчил гаргасан-1%;
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан-20%;
- Хоногийн жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгж байх хугацаандаа унтсан-3 %;
- Согтууруулах ундаа хэрэглэсэн-19 %;
- Ялтан, хоригдогчтой хувийн харьцаа тогтоосон-3,3 %;
- Ялтан, хоригдогчтой зүй бус харьцсан-0,3 %;
- Захиргааны зөрчил гаргасан-0,3% байна.

Зөрчлийн 51 хувийг “Ажлын байрны тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй” гэсэн зөрчил эзэлж байна. Үүнээс дүгнэлт хийхэд алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэхдээ өөр өөрийн үзэмжээр асуудалд хандах, эрх зүйн мэдлэг дутах, хууль тогтоомжоор олгосон эрх, үүргээ мэдэхгүй, хэрэгжүүлэхгүй байх, хэтрүүлэн хэрэглэж байна гэж ойлгож байна.

Эрх зүйн бичиг баримтыг системчлэх /кодлох/, эрх зүйн мэдээллийн сан бүрдүүлэх гэж юуг хэлэх вэ?

Хууль зүйн техникийн асуудалд хууль цаазын олон эрдэмтэд анхаарлаа хандуулж, түүний ойлголт, зарчим, хэрэгцээ шаардлагын талаар анхаарлаа хандуулж хандуулж байна. Аливаа акт, баримт бичгийг гаргахдаа санаандаа орсныг зүгээр нэг бичээд гаргачихгүй, тэрэнд нь бас тодорхой дүрэм, заавар, стандарт байдаг.

[5] Ж.Ганбаатар. “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” онол практикийн хуралд тавьсан илтгэл. 2015.

[6] ШШГЕГ. Мониторинг, статистик мэдээлэл” УБ., 2017.29-32-р тал

Үүнийг мэргэжлийн хэллэгээр техник гэдэг.

Харин хууль зүйн техник нь эрх зүйн хэм хэмжээний болон эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актуудыг бэлтгэх, хэлбэршүүлэх, эмхлэн цэгцлэх болон түүнийг хэрэглэхэд ашиглагдаж байгаа журам, арга, хэрэгслүүдийн цогц мөн гэж тодорхойлж болно.[7] Хууль зүйн техникийн зорилго нь хууль зүйн үйл ажиллагааг оновчтой болгох, хууль зүйн актуудыг тодорхой стандартаар ижилтгэх, товч, тодорхой, энгийн болгох явдал юм.

Эрх зүйн техникийн зорилтоос улбаалаад хууль зүйн техникийг гурав ангилан үзэж болох юм.

1. Эрх зүйг бүтээх техник /эрх зүйн хэм хэмжээний актыг бэлтгэх, албан ёсны болгох, эмхэлж, төрөлжүүлэхэд ашиглаж байгаа журам, арга хэрэгслийн цогц/

2. Эрх зүйг хэрэглэх техник /эрх зүйг хэрэглэсэн акт буюу тодорхой гэрээ, хэлцэл гэх зэрэг эрх зүйн нэг бүрчилсэн зохицуулалтын актыг бэлтгэх, хэлбзршүүлэхэд хэрэглэгдэж буй журам, арга хэрэгслүүдийн цогц/

3. Эрх зүйг системчилэх техник.

Эрх зүйн хэм хэмжээний актыг системчлэх техник.

Эрх зүйн хэм хэмжээний актуудыг эмхлэх, цэгцлэх нь шаардлагатай актыг эрэх, танилцах, хэрэглэх ажлыг хөнгөвчлөх, хэм хэмжээнүүдийн дотоод зөрчил, эрх зүйн хийдлийг арилгах улмаар хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох зорилго агуулна.

Эрх зүйн хэм хэмжээний актын системчлэх ажиллагааг ихэвчлэн хууль тогтоомжийн системчлэл гэж нэрлэж заншжээ. Хууль тогтоомжийн системчлэл нь эрх зүйн үйл ажиллагааны бие даасан дөрвөн хэлбэрээс бүтнэ:

- Эрх зүйн хэм хэмжээний актын янз бүрийн төрлийн эмхэтгэл, товхимол бэлтгэх, хэвлэх /хууль тогтоомжийн инкорпораци/

- Нэг асуудлыг зохицуулахаар гаргасан олон саланги актуудыг нэгтгэх үндсэн дээр нэг томоохон актыг бэлтгэх, батлах /хууль тогтоомжийн консолидаци/

- Зохицуулалтын шаардлага хангаж байгаа хуучин актын хэм хэмжээг хадгалах, мөн шинэ хэм хэмжээг батлах замаа шинэ актуудыг бэлтгэх, батлах /хууль тогтоомжийн кодификаци/

- Төрийн байгууллага, албан газар, фирм, бусад байгууллагуудаас хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээний актуудыг цуглуулж, тодорхой эмх цэгцтэй байрлуулж, боловсруулалт хийх, хадгалах, мөн зарим сонирхогч этгээд, байгууллага, албан газрын

[7] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол.

захиалга, эрэлт хүсэлтийн лавлагаа өгөх үйлчилгээ явуулахаар цуглуулах ажиллагаа /хэм хэмжээний актын тоо бүртгэл/[8].

Хууль тогтоомжийн кодификаци [9] (codification-эмхлэх цэгцлэх гэсэн латин үг) нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн актуудыг агуулгын хувьд боловсруулах үндсэн дээр байнга тогтвортой үйлчлэх шинжтэй, эмхэтгэн нэгтгэсэн шинэ актыг (кодекс, дүрэм журам гэх зэрэг) **бүтээн төгөлжүүлэх ажиллагаа** юм.

Кодификаци эрх зүйн хэм хэмжээний актуудын агуулгад нэмэлт өөрчлөлт оруулах, хуучирсан хэм хэмжээ, зарчмыг халах, эрх зүйн хийдлийг арилгах болон шинэ хэм хэмжээг тогтоох ажиллагаа зэрэг явагддаг учраас эрх зүйг бүтээх ажиллагааны нэг төрөл болно.

Хууль тогтоомжийг журамлах, нөхөн сэргээх ажиллагааг нягт хосолдог шинж чанараараа кодификаци нь эрх зүйг бүтээх хамгийн дээд боловсронгуй хэлбэр болно.

МУИС-ийн зөвлөх профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Хууль зүйн ухааны доктор Ш.Цогтоо "Багш нь 35 дахь жилдээ хууль эргүүлж явна, МУИС-д багшилж судалгаа шинжилгээний ажил хөөснөөс хойшхи 20 гаруй жил нь шинэ Үндсэн хуулийнхаа мөн чанарыг нээн харуурлахад чиглэгдсэн 70 гаруй эрдэм шинжилгээний ажил, түүний дотор их дээд сургуулийн сурах бичиг, нэг сэдэвт бүтээл 11-ийг тууриваад байна. "Та энэ хугацаанд хамгийн хэцүү, хамгийн чухал ямар ажил хийж бүтээв?" гэж өөрөө өөртөө асуулт тавьж үзэхэд ямар ч эргэлзээгүйгээр "Сүхбаатар аймгийн гүйцэтгэх захиргаанд кодификаторчноор ажиллаж байхдаа улсын архивд идэвхигүй байдлаар хадгалагдаж байсан төр засгийн удирдах дээд байгууллагын 1942-1985 он хүртэлх 43 жилийн эрх зүйн актад системчилсэн кодфикаци хийсэн явдал байлаа" гэсэн хариулт гардаг юм. Аливаа байгууллагын өөрчлөлт, шинэчлэл эцсийн дүндээ эрх зүйн шинэчлэл байдаг.[10] гэж дүгнэсэн байна.

Академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн С.Нарангэрэл "2010 онд болсон эрдэм шинжилгээний хуралдаанд би оролцож, цагдаагийн байгууллагын эрх зүйн актуудын системчилсэн эмхэтгэлийггаргах үйл ажиллагаа хийгдэх явдал бол цагдаагийн байгууллагаас хууль тогтоомжийг

УБ.,2010. 227-р тал

[8] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2010. 236-р тал

[9] Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ.,2010. 239-р тал

[10] Хуулийн хэлтэс сэтгүүл. Ш.Цогтоо, Аливаа байгууллагын өөрчлөлт, шинэчлэл эцсийн дүндээ эрх зүйн шинэтгэл байдаг. 40-41-р тал

сахин хангах, нийгмийн дэг журмыг хангах, ялангуяа зарим зайлшгүй шаардлагатай үед хүч хэрэглэх үйл ажиллагаанд хууль ёсыг сахиулахад онцгой ач холбогдолтой гэж эрдэмтэн бид үзэж байсан. Энэ үйл ажиллагаа түүнээс хойш хийгдээд, өнгөрч байгаа зургаан жилд цагдаагийн байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын бүрэн эмхэтгэл системчлэгдэж гарсан байна.

Энэ хугацаанд зөрчилтэй актуудын зөрчлийг арилгах, хууль тогтоомжид нийцүүлэх, төрөлжүүлэн ангилж, системчлэх нөр их хөдөлмөр, үйл ажиллагаа хийгджээ. Энэ нь цаашдаа цагдаагийн байгууллага хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг хууль ёсны үндэслэлтэй болгох, цагдаагийн байгууллагын алба хаагчид тэр дагуу үйл ажиллагаагаа нарийн чанд явуулах, шаардлагатай иргэд, байгууллага, аж ахуйн нэгж тодорхой мэдээлэл авах боломж бүрдсэн, нэг үгээр бол шинжлэх ухааны үндэстэй үйл ажиллагаа хийгдсэн байна.[11] хэмээн дүгнэсэн байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн актыг системчилсэн байдал:

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай ханган, цагдаагийн ажил, үйлчилгээг эрх зүйн хүрээнд иргэд олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэж, алба хаагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалах зэрэг нөхцөл, шаардлагуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилладаг билээ.

Засгын газраас өндөр хөгжилтэй гадаад улс орны стандартыг нутагшуулах тухай бодлого барьж ажиллаж байгаа боловч техникийн стандарт талаас нь хараад нийгмийни харилцааг зохицуулах талаас, мөн төрийн албыг зохицуулах талаас нь олж хараагүй байсан гэж үзэж болно. /*Монгол Улсын Засгийн газраас европын стандартыг нутагшуулах талаар бодлого баримталж стандартын талаарх ойлголт нийгмийн шинжлэх ухааны салбарт төдийлөн ойлголт багатай байгаа болов уу. Энэ талаар тодорхой судалгаа, шийдвэр, нотлох баримт хомс байдаг*/

Харин хууль сахиулах салбарын хувьд 2009 онд цагдаагийн байгууллага хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргүүдээ хэрхэн хэрэгжүүлэхийг заасан стандартын эхлэлийг тавьж анх удаа “цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” гэж стандарт журмыг

[11] Хуулийн хэлтэс сэтгүүл. 2016 он. С.Нарангэрэл, Цагдаагийн байгууллагын хуульд нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд бүрэн системчлэгдсэн, 47 дах тал

баталсан юм.[12] Дээр өгүүлсэнчлэн нэр томъёоны хувьд үйл ажиллагааны стандарт журам эсвэл стандарт үйл ажиллагааны журам аль нь ч байж болох юм. Жишээ нь төрийн албаны стандарт, бүр үгүй бол аливаа салбарын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны журам гэж нэрлэх боломжтой. Хэдийгээр нэр чухал биш байж болох ч манай нийгмийн харилцаанд үнэт зүйл болсон нэгэн элемент болж ирээдүйд уламжлагдахад бас агуулга зорилго нь өөр өөр ойлгогдохгүй, гажихгүй байх үүднээс анхаарвал зохих зүйл гарцаагүй мөн.[13]

Дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагууд үйл ажиллагаагаа зохион байгуулах, хяналт тавих, алба хаагч үүргээ гүйцэтгэх явцад эрсдэлтэй тулгарсан үед нөхцөл байдлыг хяналтандаа авч, шийдвэр гаргах зааварчилгаагаар хангах, цагдаагийн алба хаагчийн зайлшгүй хийж гүйцэтгэвэл зохих буюу хориглосон үйлдэл, оновчтой шийдвэр гаргаж, шуурхай ажиллах чадавхийг бий болгоход онцгой анхаарч байгууллагын дотоод журмыг гаргаж мөрдүүлдэг нийтлэг жишиг бий.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, олон улсын эрх зүйн актууд, эрдэмтэн судлаачдын судалгаа, дүгнэлт зөвлөгөө, гадны орны шилдэг туршлага, стандарт, журмуудыг судалсны үндсэн дээр, Засгын газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дах хэсэгт “агентлагын хэмжээнд агентлагын даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө.” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг үр дүнтэй, жигд зохион байгуулах, хяналт тавих арга замыг тодорхойлж, үйл ажиллагааны аргачлал, дэс дараа, горим журмыг тогтоож, системчлэн, кодчилсон “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” хэмээх эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн гаргадаг.[14]

Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль цаазын тэргүүн зөвлөх М.Энх-Амгалан: “Аливаа төрийн байгууллага, алба хаагчдын

[12] Цагдаагийн Ерөнхий газар анх удаа цагдаагийн байгууллага, алба хаагчид хуулиар хүлээлгэсэн 90 гаруй хуулийг хэрхэн хэрэгжүүлэхийг зохицуулсан 9 бүлэг нийт 230 журам баталсан, 2015 оны 11 сарын байдлаар 256 стандарт журам үйлчилж байна.

[13] Ж.Ганбаатар “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” онол, практикийн хуалд тавьсан илтгэл. 2015

[14] Б.Билэгт. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ., 2013

үйл ажиллагаанд мөрдөгддөг эрх зүйн баримт бичгүүдийн нэг хэсэг нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр батлагдсан дотоод журам зааврууд байдаг.

Эдгээр заавар, журмууд нь хоорондоо уялдаа холбоотой, хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцид нийцсэн байхын зэрэгцээ хэрэглэгч нь ашиглахад хялбар, ойлгомжтой байх шаардлагыг хангаж байх нь чухал юм.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөөг хангах, цагдаагийн ажлыг эрх зүйн хүрээнд ард иргэддээ шуурхай хүртээмжтэй хүргэх, алба хаагчдынхаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг зарчим, шаардлагыг чанд сахин хэрэгжүүлж байх ёстой.

Дээр дурьдсан шаардлага, үйл ажиллагааны онцлог, дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагын туршлага, жишиг зэргийг харгалзан 2010 онд ЦЕГ-ын дарга, хошууч генерал Д.Сандаг-Очир тушаал гаргаж цагдаагийн байгууллага, алба хаагчын үйл ажиллагааг үр дүнтэй, жигд, шуурхай зохион байгуулах, алба хаагч, ажилтнудыг мэргэжлийн арга зүй, зааварчилгаагаар хангасан, үйл ажиллагаанд нь хяналт тавих арга зам, түүнчлэн цагдаагийн төрөл мэргэжлийн албад, алба хаагч бүрт чиг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарвал зохих харилцааг оновчтой тодорхойлсон, үйл ажиллагааны аргачлал, дэс дараа, горим журмыг нь тогтоосон “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны багц журам”-ыг бэлтгэж батлуулах ажлын хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга надаар ахлуулан ажиллуулсан.”[15] гэжээ.

Хууль сахиулахын их сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Хууль зүйн ухааны доктор, (Ph.d) дэд комиссар Б.Бат-Эрдэнэ: “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн журмыг боловсруулж мөрдүүлж эхэлсэн нь Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гарсан ихээхэн дэвшил хэмээн би боддог. Энэ журам цагдаагийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагааг цогц байдлаар, нарийвчилсан зохицуулсан анхны тохиолдол мөн бөгөөд байнга боловсронгуй болгох механизмыг өөртөө агуулж буйн хувьд амьд эрх зүйн акт болж чадсан хэмээн судлаачид үздэг”.[16]

---

[15] Хуулийн хэлтэс сэтгүүл. Ц.Энх-Амгалан. Хөдөлмөрийн дотоод журам, зааврууд нь хоорондоо уялдаа холбоотой, хууль тогтоомжид нийцсэн, хэрэглэгч нь ашиглахад хялбар байх шаардлагг хангаж байх нь чухал

[16] Б.Бат-Эрдэнэ. Хуулийн хэлтэс, түүний хамт олон цагдаагийн хууль тогтоомжийн “манаач”, “эх баригч” –ийн үүргээ ёсчлон биелүүлж байна. Хуулийн хэлтэс сэтгүүл. 2016., 50 дах тал

Хууль тогтоомжийн хэрэгжилт төрийн албадлагаар баталгааждаг гэдгийг хэрхэвч мартаж болохгүй. Хууль хэрэгжихгүй байгаагийн гол шалтгаан нь энэхүү ажил учир дутагдалтай байгаатай шууд холбоотой. Засгын газар, түүний бүрэлдэхүүнд багтаж буй албан байгууллага, албан тушаалтнууд хуулийг хэрэгжүүлэхэд хүсэх, шаардах, албадах, бүхий л аргыг хослуулан чадмаг хэрэгжүүлснээр жинхэнэ эрх зүйт төрийн үлгэр загварыг бүрдүүлж чадна. Юуны өмнө төрийн албанд хуулийг дээдлэн биелүүлдэг сахилга, ухамсрыг хэвшүүлэн тогтоох ажлыг цаг алдалгүй үр нөлөөтэй хийх хэрэгтэй.

Хуулийг сурталчлах гэхээсээ илүү батлагдсан хууль, тогтоомжийг шуурхай мэдээлэх, хэрэглэгчидэд нэн даруй хүргэх чиглэлээр холбогдох байгууллагууд ажлын арга барилаа шинэчлэх шаардлагатай. Хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөг судалж, зөрчил, хийдлийг нь арилган уялдаа холбоог нь сайжруулан төгөлдөржүүлэх ажлыг хийх нь нэн чухал. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 25 жилийн хугацаанд түүнд нийцүүлэн 400 орчим бие даасан хуулийг боловсруулан баталсан байна. Эдгээр хуулийг боловсруулан батлах ажлыг амжуулсан нь томоохон ололт амжилт мөн боловч ний нуугүй хэлэхэд зарим хуулиудын зүйл, заалтууд хоорондоо зөрчилтэй байдаг, энэ нь хуулиудын хэрэгжилтэнд муугаар нөлөөлдөгийг ч та бид сайн мэднэ. Тийм учраас эдгээр хуулиудын хоорондын зөрчлийг арилгах, кодчилох ажлыг цогцоор нь хийх нь тулгамдсан зорилт болж байна. Энэ талаар сүүлийн жилүүдэд нилээд ярьж байгаа боловч, нүдэнд харагдаж, гарт баригдахуйц ажил хийгдээгүй байна. Энэ чухал ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран Хууль сахиулахын удирдлагын академи, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хүч бололцоог түшиглэн хийвэл хамгийн зохимжтой гэж үзэж байна.

Зарим хуулиар олгогдсон хэм хэмжээ практикт хэрэгжихгүй байх тохиолдол нилээдгүй байна. Учир нь эдгээрийн биелэлтийг хэрхэн зохион байгуулах талаар гарсан гарсан заавар, журам учир дутагдалтай байна. Тухайлбал:

1. ШШГТХуулийн 137 дугаар зүйлийн 137.10-т: “Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдана.” гэсэн заалт;

2. ШШГТХуулийн 134 дүгээр зүйлийн 134.2.6-д: “хуурамчаар болон санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулж эмчлүүлсэн, дур мэдэн ажилд гараагүй, чөлөөнөөс хоцорсон,

оргосон хугацааг ял эдэлсэн хугацаанаас хасаж тооцох гэсэн заалт;

Эрх зүйн актыг боловсруулах, бүртгэх, хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд олон жилийн туршид мөрдөгдөж ирсэн зарим дүрэм, журам, заавар шинэ тутам бий болсон эрх зүйн харилцааг зохицуулж чадахгүй болсон, зарим тохиолдолд эрх зүйн акт нь ч олдохгүй болсон, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил ихэссэн зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих олон асуудалтай тулгарсан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мөрдөж буй эрх зүйн актын бүртгэлийг хийснээр нэн даруй хүчингүй болгох, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах дүрэм, журам, зааврын судалгааг хийхээс ажлаа эхлүүлэх шаардлагатай байна.

ШШГБ мөрдөгдөж байгаа хуулийн заалтыг алба хаагчид хэрхэн хэрэгжүүлэх процедур нь тодорхой бус, эрх зүйн зөрчил агуулсан зэрэг нь хуулийг хэрэгжүүлэх, ёсчлон сахиулах үйл ажиллагаанд ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Эрх зүйн орчны боловсронгуй бус байдал нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, ялангуяа алба хаагчид хуулийг буруу хэрэглэх, үүний улмаас иргэд хохирох, алба хаагчийн өөрийнх нь эрх ашиг хөндөгдөх явдал олонтоо гарч байв.

Иймд эдгээр эрх зүйн болон бодлогын бичиг баримтын хэрэгжилтийг хангах, ШШГБ-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үүднээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдлийг арилгах, шинээр дүрэм, журам боловсруулан тэдгээрийг Монгол Улсын хууль, олон улсын стандартад нийцүүлэн системчлэх нь байгууллага, алба хаагчын үйл ажиллагааг улам төгөлдөршүүлнэ гэдэгт итгэл төгс байна.



Р.УУГАНБАЯР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн багш, ахмад

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хураангуй: Эрдэм шинжилгээний энэ илтгэлд хорих байгууллагын албан хаагчийн Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, олон улсын эрх зүйн актуудаар зохицуулагдаж буй хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрхийн талаар судалгаа хийж албан хаагчийн аюулгүй байдлыг хангаж буй өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид шийдвэрлэх арга замын талаар судлаачийн байр суурийг илэрхийлсэн.

Түлхүүр үг: Хүний эрх, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, амьд явах эрх, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх, хорих байгууллагын албан хаагчийн аюулгүй байдал, парадигма, реформ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлаж, тодорхой хугацаагаар хязгаарлагдмал орчинд албадлагаар тогтоон барьдаг өөрөөр хэлбэл гэмт хэрэгтнүүдийн оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог[1]. Энэхүү ажиллагааны явцад ялтан, хоригдогчийн зүгээс албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг санаатайгаар эсэргүүцэх, доромжлох, гүтгэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах зэргээр Монгол улсын Үндсэн хууль бусад хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдсан “хүн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах” эрх зөрчигдөх явдал байнгын болон тогтмол шинжтэйгээр гарсаар байна.

Иймд судлаачийн зүгээс уг асуудлыг шинжлэх ухаанчаар шинжлэн судалж, оношлох, учир шалтгаан, зүй тогтолыг илрүүлэхийг эрмэлзсэн болно.

Хорих байгууллагын албан хаагчид ямар нэг аюул, заналхийлэл, эрсдэлээс ангид, сэтгэл зүйн хувьд дарамт, шахалт, айдасгүй ажиллах нь хөдөлмөрийн бүтээмж өндөр байх, үр дүнтэй, тогтвортой ажиллах нэг нөхцөл болдог.

Иймд албан хаагчдын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нь ихээхэн чухал ач холбогдолтой.

[1] Г.Тамир “Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, онцлог” илтгэл УБ.2014 он

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Үндсэн хуулийн дараа орохуйц чухал ач холбогдолтой эрх зүйн баримт бичиг бөгөөд УИХ-аас 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн баталсан байна. Энэхүү үзэл баримтлалд "***Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нохцолийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нохцолийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн***[2]" гэж маш оновчтой томъёолжээ.

Албан хаагчдын аюулгүй байдал нь дараах элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Хөдөлмөрийн орчны аюулгүй байдал. /Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал, хамт ажиллагсдын зүгээс үзүүлэх сөрөг нөлөөлөл зэрэг/

2. Хоригдогсдоос үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалагдсан байдал. /Хорих ял эдлэж байгаа болон цагдан хоригдож буй хоригдогсод нь ямар нэг гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх эсхүл нуун далдлах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох гэх мэт үйлдлийнхээ явцад ажилтан, албан хаагчид сөрөг нөлөө үзүүлдэг. Энэхүү нөлөөллөөөрөө шууд эсхүл бусдаар дамжуулан илэрхийлэх хандлагатай байдаг. Энэхүү нөлөөлөл нь албан хаагчдын алдаа, зүй бус үйлдэл, үйл ажиллагааг ашиглан эрхэндээ оруулах, айлган сүрдүүлэх, заналхийлэх, дарамтлах мөн амь нас, эрүүл мэндэд нь халдах гэх мэт хэлбэрээр илэрдэг/

3. Хувийн аюулгүй байдал. /Энэ нь хорих байгууллагын албан хаагч бол жирийн иргэн гэдэг утгаараа хангагдвал зохих аюулгүй байдлын тухай асуудал хамаарна/

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас өөрийн гишүүн улс орон бүрд хэрэгжүүлбэл зохих, нийтлэг олон улсын хэм хэмжээ, стандартыг тогтоосоор байна. Эдгээр олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэснийхээ хууль, тогтоомжинд тусган хэрэгжүүлэх нь НҮБ-ын гишүүн улс орнуудын чухал үүрэг бөгөөд энэ талаар манай улс Үндсэн хуулийнхаа 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" [3] гэж зааснаар илэрхийлэгдэж байгаа юм.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, тухайлбал Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий ассамблейн Хүний эрхийн түгээмэл

[2] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010. 4 дүгээр бүлэг, 28 дугаар зүйл

тунхаглалд “Хүн бүр, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” [4] гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална”[5], “энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах”[6] үүрэг хүлээх тухай ч зааж өгчээ. Эдгээр хууль, эрх зүйн баталгаа нь ШШГБ-ын албан хаагчдад ч хамаарна.

Эрх зүйн шинжлэх ухаан нь нийтийн нийгмийн эрх ашгийг дээдэлж, хувь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах хандлага давамгайлсан зарчмыг удирдамж болгож байсан бол өнөө үед хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн байдлаар хандах боллоо.

Хүн нийгмээс ангид амьдарч байгаасан бол түүнд ёс суртахууны хэм хэмжээ гэж байх шаардлагагүй, өөрийн хүссэн, санаснаа хийгээд явж байж болохсон. Гэтэл нийгмээс ангид амьдардаг хүн гэж хорвоод нэгээхэн ч үгүй.

Тиймээс хүн хийж байгаа үйлдэл, түүнийг хэрэгжүүлэх бодол, харилцаа энэ бүхнээ зөвхөн өөрийн байр суурь эрх ашгийн үүднээс бус, бас нийгмийн эрх ашигт тус хүргэх, хор учруулахгүй байх талаас нь бодолцох ёс суртахуунтай байхыг нийгэм шаарддаг. Гэтэл коммунист нийгмийн дэглэм, ёс суртахуун задармагц, манай ард түмний нилээд хэсэг хүний эрх, эрх чөлөө, эрх зүйн талаар ардчилсан ойлголтоор маруухан мэдлэгтэй байсан нь ёстой дурааараа байхыг эрх чөлөө хэмээн үзэж, хүний нийгмийн хэм хэмжээнээс ангид, хэтэрсэн үйлдэл, ажиллагаа явуулж ирсэн юм.

Эрх зүйн сонгодог онол арга зүйгүйгээс хууль тогтоомжууд нь “цоорхой” ихтэй, гаргасан хуулиудын эрх зүйн судалгаа хомсдолд орсон нь энэхүү шинжлэх ухааны парадигм [7] өөрчлөгдөж байсныг харуулдаг.

Үүний тод жишээ нь: Хүний эрхийг хангах дэд бүтцийг бүрдүүлэхгүйгээр /ял эдлүүлэх ажиллагааны реформ [8] хийх/ ялтны эрх ашгийг хэт дээгүүрт тавьснаас ялтны дураар авирлах байдал, албан хаагчдыг үл тоох, офицер ахлагчийн

[3] Монгол Улсын Үндсэн хууль.10.2 дугаар зүйл

[4] НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946, 3 дугаар зүйл

[5] НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966, 6 дугаар зүйл

[6] НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966, 3 дугаар зүйл

[7] Америкийн Харвардын их сургуулийн багш Томс Кун онолын физикч, шинжлэх ухааны түүхч, филсофич гаргасан онол парадигма гэдэг нь аливаа шинжлэх ухааны хувьсан өөрчлөгдөж буй хэлбэр, загвар юм гэж тодорхойлсон байдаг

ялгаа гаргах, тэдэн рүү дайрч давшлах, доромжлох, хууль ёсны шаардлагыг нь эсэргүүцэх асуудал газар авч улмаар тэднийг хорих байгууллагад тогтвортой ажиллах эсэхэд нөлөөлөх хэмжээнд хүрч албан хаагчийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрх зөрчигдсөөр байна.

Албан хаагчийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь гүйцэтгэж байгаа албан үүрэгтэй нь холбогдуулан бусад албан хаагч болон сэжигтэн, яллагдагч, ялтан, түүний ар гэр, найз нөхөд, төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр дарамтлах, хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчийг хуульд зааснаар урьдчилан сэргийлэх, хамгаалахыг ойлгоно гэж тодорхойлжээ. Сүүлийн 5 жилийн байдлаар хорих байгууллагаас өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон ажлаас халагдсан албан хаагчдын тоо улам өссөөр байгаа нь үүний нэг тод жишээ болж байна. Үндсэн хуулиндаа хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх гэж зааж өгсөн боловч 24 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй ээлжийн дарга, харуул, сувилагч нарын аюулгүй байдал болоод ажлын ачаалал зэрэг нь төдийлөн хангалтгүй хангагдан тодорхой үнэлэгдэхгүй байна.

Хорих байгууллагын албан хаагч нь гэдэгт бүх хорих анги, түүнтэй адил дэглэм бүхий байгууллага болон цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэдэг, хоригдогч, ялтантай шууд нүүр тулж ажиллаж буй албан хаагчдыг ойлгож болох бөгөөд эдгээр нь бүх төрлийн аюул заналд өртөж болзошгүй, хамгийн их эрсдэл бүхий хүмүүс юм. Иймээс аюулгүй байдлыг хангах гадаад, дотоод хүчин зүйлийг тодорхойлох нь чухал юм.

1990 оны 8-р сарын 27-ноос 9-р сарын 7-нд Кубын Гавана хотноо хуралдсан НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 8-р их хурлаас баталсан "Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын" 16-р зүйлд нь Өөрийн мэргэжлийн бүх үүргийг заналхийлэл, саад бэрхшээл, айлган сүрдүүлэлт буюу хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр нөхцөл байдалд гүйцэтгэх гэж заасан байна.

Хорих байгууллагын албан хаагчид албан үүргээ хэвийн гүйцэтгэж, аюулгүй байдал нь найдвартай хамгаалагдаж чадсан уу? 2014 онд нийт 41 албан хаагч ямар нэгэн байдлаар халдлагад өртсөн

[8] Г.Тамир "Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, онцлог" илтгэл.УБ.2014 он

судалгаа[9] байна. Хэдийгээр энэ нь системийн нийт албан хаагчдын 1,33% буюу бага тоо мэт харагдаж байгаа боловч энэ нь төдийлөн хангалтгүй байгааг харуулж байна. Мөн дээрх 41 албан хаагч нэг бүр нь их бага ямар нэгэн байдлаар хохирч үлдсэн байдаг ба тэдгээрийн ард гэр бүл нь байдгыг ч мартаж болохгүй билээ. Иймд дээрх судалгааг графикаар харуулахад:



Герман улсын **ВУППЕРТАЛ ДАХЬ ХОРИХ АНГИ-**г жишээ болгон авч үзэхэд энэ хорих анги нь 250 орчим албан хаагчтай, үүнээс 200 нь харуул хамгаалалтын ажилтан, 12 техникийн мэргэжилтэн, 3 сэтгэл зүйч, 5 нийгмийн ажилтан, 3 сурган хүмүүжүүлэгч багш, 4 сүмийн пастор, 1 эмч болон захиргааны албанд 15-20 хүн ажилладаг байна. Нийт албан хаагчдын 80% нь харуул хамгаалалтын албан хаагч байна. Одоогоор 545 ялтан хоригдож байгаа бөгөөд 1 албан хаагчид 2-3 ялтан оногдож байна. Харуул хамгаалалтын албан хаагч бүр 14 хоногт хийн буу болоод шаардлагатай зэвсэг хэрэгслээр сургуулилт хийдэг, ажилд гарахад нь хүн нэг бүрийн тусгай хэрэгслээр ханган гаргадаг байна[10].



Манай улсын хорих ангиудад 1 харуул хамгаалалтын албан хаагчдад 10-15 ялтан оногдож байгаа нь харьцангуй өөр байна. Зэвсэг хэрэгслээр бэлтгэл сургуулилт хийх боломжгүй, ажилд гарахад олгох хүн нэг бүрийн тусгай хэрэгсэл хангалтгүй байна.

2013 он хүртэл ШШГБ-ын хэмжээнд аюулгүй байдлыг хангах тусгай бие даасан нэгж байсангүй. Харин Монгол улсын Хууль зүйн сайдын 2013 оны 02 дугаар сарын 06–ны өдрийн А/18 тоот “ШШГЕГ-т бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” тушаалаар бүтцийн өөрчлөлт хийгдэж **/хавсралт/** ШШГЕГ-т Аюулгүй байдлын хэлтэс байгуулагдсанаар

[9] Ч.Цэнгэлбаяр. ШШГБ-ын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудал илтгэл. УБ 2014

системийн түүхэнд нэгэн дэвшилтэт түүх[11] болсон юм. Дараа нь Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/180 тоот “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалаар **/хавсралт/** бүтцийн өөрчлөлт хийгдэж Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс болж өргөжсөн юм.

Дүгнэлт

Монгол улсад өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж мөрдөгдөж буй дээр дурьдсан эрх зүйн баримт бичгүүдээс дүгнэж үзэхэд Хорих байгууллагын албан хаагч нь Монгол Улсын иргэн тул мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу иргэний эрхээ эдлэж /хуулиар хязгаарлуулсанаас бусад[12]/, аюулгүй байдлаа хамгаалуулах эрх зүйн орчин нь манай улсад нээлттэй байна.

Хорих байгууллагын албан хаагч гэдэгт бүх хорих анги, түүнтэй адил дэглэм бүхий байгууллага болон цагдан хорих байранд үүрэг гүйцэтгэдэг, хоригдогч, ялтантай шууд нүүр тулж ажиллаж буй албан хаагчдыг ойлгож болох бөгөөд эдгээр нь бүх төрлийн аюул заналд өртөж болзошгүй, хамгийн их эрсдэл бүхий хүмүүс юм гэж заасан байдаг ба бие эрхтэнд нь хүч хэрэглэн халдсан тохиолдолд тусгай хэрэгсэл, галт зэвсгээр өөрийгөө хамгаалах, ам хэлээр доромжлох, гүтгэх гэх мэтээр халдсан тохиолдолд холбогдох байгууллагаар нь шалгуулж Эрүүгийн болон захиргааны хариуцлагын хуулийн [13] дагуу шийдвэрлүүлэх боломж нь нээлттэй байна гэсэн үг юм. Гэвч өнөөдрийн эрх зүйн орчны хүрээнд нэмж хууль болон журамд тусгаж өгч зохицуулах шаардлагатай харилцаанууд байна.

Хорих ангиудад ажиллаж байгаа харуул хамгаалалтын албан хаагчдад эрх зүйн орчны талаар сургалт тогтмол явуулж байх шаардлагатай байна.

ШШГЕГазрын Хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэс нь системийн хэмжээнд ажлаа тайлагнан сурталчилж баймаар байна. Учир нь тус хэлтэсийн 2014 онд хийсэн ажлын тайлан /хавсралт №9/-тай танилцахад хэлтсийн үйл ажиллагаа нь хяналт шалгалтын чиглэл рүү түлхүү анхаардаг, өөрөөр хэлбэл аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарахаасаа илүү ямар нэгэн зарчил, дутагдал гарч, асуудал үүссэний дараа түүний мөрөөр

[10] О.Пүрэвсүрэн “Герман улсын хорих ял эдлүүлэх ажиллагаа” УБ.2014 он. 97 дах тал

[11] ШШГБ-ын бүхий л түүхэнд албан хаагчдынхаа аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан чиг үүрэг бүхий анхны хэлтэс /нэгж/ юм.

[12] Төрийн албаны тухай хууль. УБ. 2002. 15 дугаар зүйл

шалгалт явуулж, хариуцлага тооцох байдал нь давамгайлсан байдал хэвээр байгаа нь харагдаж байна.

Хорих байгууллагын албан хаагчдаа ажиллах эрүүл, аюулгүй орчин нөхцлийг баталгаажуулах, бусдын нөлөөнд автагдах, албан үүргээ хийж гүйцэтгэсэнийхээ төлөө өөрөө болон түүний гэр бүл нь гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь ШШГБ-ын үндсэн үүрэг бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах нь тус байгууллагын үндсэн зорилтын нэг билээ.

Хорих байгууллагад ял эдлэж байгаа болон цагдан хоригдож буй хоригдогсод нь ямар нэг гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх эсхүл нуун далдлах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох гэх мэт сөрөг үйлдлийнхээ явцад ажилтан, албан хаагчийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдаж болзошгүй байдаг. Тухайлбал: эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, айлган сүрдүүлэх, дарамтлах мөн амь нас, эрүүл мэндэд халдах гэх мэт.

Судлаачийн байр сууринаас хууль эрх зүйн актуудыг судалж албан хаагчийн аюулгүй байдлыг хангах талаар шийдвэрлэвэл зохих саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Аюулгүй байдлыг хангахад нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлсийг тогтоох:

- Хорих ангийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй анхаарвал зохих нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ШШГБ-ын боловсон хүчний хангамж, ажилтан, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, анхан шатны болон давтан сургалт:

- Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хамгаалалтын тоног төхөөрөмж хэрэгслүүд:

Ашигласан ном зүй

1) Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он
2) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он
3) Монгол улсын Үндсэн хууль1992 он
4) Төрийн албаны тухай хууль 2002 он
5) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он
6) Төрийн мэдээлэл” эмхтгэл. УБ. 1992 он
7) С.Нарангэрэл “ Эрх зүйн эх толь бичиг” 2011 он Гуравдахь хэвлэл
8) Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл 2014 он
9) Хүний эрхийн үндэсний комисс “ хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл 2014 он

[13] “Төрийн мэдээлэл” эмхтгэл. УБ. 1992, №4-5

10) Г.Тамир “Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, онцлог” илтгэл.УБ.2014 он
11) Ч.Цэнгэлбаяр. ШШГБ-ын албан хаагчдын аюулгүй байдлыг хангах асуудал илтгэл. УБ 2014 он
12) Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он



О.БАЯРЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ХЭЛБЭР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдон хорих ял эдэлж байгаа хүмүүсийн дунд нийгэмшүүлэх ажлыг эрх зүйн орчинд тусгасан хэлбэрээр явуулахад онолын үндэслэлэл, шинжлэх ухааны хандлага зайлшгүй шаардлагатай болох нь улам бүр нотлогдсоор байна.[1]

Ерөнхий нийгмийн ажлын практикт нийгмийн ажлын үйлчилгээг дараах үе шатуудаар үзүүлдэг. Эдгээр үе шатууд нь нийгмийн ажлын үйлчлүүлэгч болох хувь хүн, бүлэг, гэр бүлтэй ажиллахад хэрэглэгдэнэ. Харин байгууллага, олон нийттэй ажиллахад дээрх үе шатуудыг ашиглах хэдий ч зарим нэгэн үе шат өөрчлөгддөг болохыг анхаарах хэрэгтэй.

1. **Үйлчлүүлэгчтэй анхны уулзалт хийж, харилцаа холбоо тогтоох үе шат:**

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн тулд үйлчлүүлэгчтэй уулзаж, харилцаа холбоо тогтооно. Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны хувьд үйлчлүүлэгч нь тухайн байгууллагад хоригдогч хувь хүн, бүлэг юм. Ял эдэлж буй эдгээр хувь хүн нь дараах байдлаар нийгмийн ажилтны үйлчлүүлэгч болно. Үүнд: а) хоригдогч өөрийн хүсэлтээр нийгмийн ажилтанд хандаж үйлчлүүлэгч болох, б) бусад мэргэжилтэн, албан хаагч болон байгууллагын санал хүсэлтийн дагуу нийгмийн ажилтан нь хоригдогчтой уулзаж, үйлчлүүлэгчээ болгох. Эхний тохиолдолд хоригдогч сайн дурын үндсэн дээр өөрөө нийгмийн ажилтанд хандаж байгаа тул уулзаж, харилцаа тогтоох нь тийм ч хүндрэлтэй биш байна. Харин хоёр дахь тохиолдолд бусдын санал хүсэлтийн дагуу нийгмийн ажилтан тухайн хоригдогчтой уулзаж, холбоо тогтоох шаардлагатай болдог. Ийм нөхцөлд зарим хоригдогч нь нийгмийн ажилтантай уулзаж, өөрт нь нийгмийн ажлын үйлчилгээ үнэхээр шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг бол, зарим нь түүнийг огт хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс бусдын шахалтаар нийгмийн ажлын үйлчлүүлэгч болж буй хоригдогчтой харилцаа холбоо тогтоох нь амаргүй

[1] А.Лхагва, М.Ганхүү “Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” УБ 2015 он

байх болно. Нийгмийн ажилтан шүүмжилсэн, буруутгасан өнгө аясаар хэзээ ч хандаж болохгүй. Ойлгож, хүндэтгэн, хэрэгцээг нь мэдэрч харилцсанаар тухайн хоригдогч өөрийн асуудал, санаа бодлоо хуваалцах болно.

Энэ үе шатанд үйлчлүүлэгч болон нийгмийн ажилтны хооронд харилцан итгэлцэл бүхий харилцаа холбоо бий болсон байх ёстой. Өөрөөр хэлбэл, нэг талаас үйлчлүүлэгч болох хоригдогч нь нийгмийн ажилтанд итгэх, нөгөө талаас нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ шаардлагатайг бодитойгоор ойлгуулна гэсэн үг.

Нийгмийн ажлын үйлчилгээний эхний үе шат амжилттай бус болох тохиолдолд дараагийн үе шатууд хэрэгжихэд хүндрэлтэй байх болно. Тиймээс үйлчлүүлэгчтэй харилцаа холбоог үр дүнтэй, амжилттай тогтоох хэрэгтэй. Хорих ангийн нийгмийн ажилтан нь хоригдогчдод нэн түрүүнд шийдвэрлэвэл зохих ямар асуудал тулгараад байгааг, мөн нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эсэхийг анхны уулзалтаар тодорхойлно.

Анхны уулзалтыг зохион байгуулахын тулд тодорхой бэлтгэл шаардлагатай байдаг. Тухайн үйлчлүүлэгч болон түүнд тулгамдсан асуудалтай холбоотой мэдээллийг тоо бүртгэлээс болон бусад хүмүүс, албан хаагчдаас боломжийн хэрээр авч судалсан байх (асуудлыг улам хурцатгаж, дэвэргэж болохгүйг анхаарах, нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах), уулзалтын хөтөлбөрийг боловсруулсан байх, ярилцах зүйлстэй холбоотой асуултуудыг урьдчилан бэлтгэх, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нь тогтоогдвол дараагийн уулзалтыг хэзээ хийж болохыг урьдчилан тодорхойлсон байх гэх мэтчилэн зүйлсийг анхаарна.

2. **Мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх:**

Нийгмийн ажлын үйлчилгээний эхний үе шатанд үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудлыг илрүүлж, нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлсны дараа тухайн асуудалтай холбоотой бүхий л мэдээллийг цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Туршлагагүй зарим нийгмийн ажилтны хувьд нөхцөл байдлын үнэлгээг зөвхөн мэдээлэл цуглуулахаар хязгаарлан ойлгодог. Гэтэл үнэн хэрэгтээ дараах зүйлсийг хийх шаардлагатай байдаг. Үүнд: а) шаардлагатай мэдээллийг, б) холбогдох хүмүүс болон эх сурвалжаас, в) тодорхой аргыг ашиглан цуглуулж, г) түүндээ анализ дүгнэлт хийснээр нөхцөл байдлын үнэлгээ төгс утгаараа хийгдэнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхийн тулд хоригдогчийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй

холбоотойгоор ямар мэдээлэл цуглуулах шаардлагатайг тодорхойлох нь чухал. Тулгамдаад байгаа асуудлын мөн чанар, түүнд үзүүлэх үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, орчны нөлөө, асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой хувь хүний чадвар, боломж, нөөц эх сурвалжууд зэрэг мэдээллийг цуглуулна.

Шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гаргахад тухайн нийгмийн ажилтны ашиглах онолын үзэл баримтлал, хорих ангийн дэглэмийн ялгаатай байдлаас хамааран үзүүлдэг үйлчилгээний төрөл, чиглэл гэх мэт зүйлс нөлөөлж болно. Тухайлбал, нийгмийн ажилтан давуу талд тулгуурлах онолын үзэл баримтлалыг практик үйл ажиллагаандаа ашиглах бол хоригдогч, түүний хүрээлэн буй орчин дахь давуу тал, нөөц боломжийн (хувь хүний авьяас чадвар, давуу талууд, гэр бүл, найз нөхдийн дэмжлэг туслалцаа гэх мэт) талаар мэдээллийг голлон цуглуулж, дүн шинжилгээ хийнэ. Харин асуудалд тулгуурлах онолын үзэл баримтлалыг үндэс болговол тухайн хоригдогчийн сул талууд, нөлөөлж буй сөрөг хүчин зүйлс, саад бэрхшээл зэргийг голлон судлах жишээтэй.

Хорих ангийн дэглэмийн ялгаатай байдлаас хамааран хоригдогчид үзүүлэх үйлчилгээний төрөл хэлбэр өөр өөр байж болох талтай. Тухайлбал, жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдогчийн хувьд нийгмийн ур чадваруудад суралцах сургалт нээлттэй байх бол онцгой болон чанга дэглэмтэй хорих ангийн хоригдогчид ийм боломж хаалттай байна гэсэн үг. Тиймээс хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх мэдээлэл цуглуулахдаа эдгээр байдлыг тооцох шаардлагатай.

Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхийн тулд бодит нөхцөл байдлыг сайтар судлах нь чухал бөгөөд үүнд шаардлагатай мэдээллүүд нь үнэн зөв бодитой байх асуудал ч хамаарагдана. Мэдээллийн эх сурвалж нь үйлчлүүлэгч өөрөө байхаас гадна түүний гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсад, эмчлэгч эмч, сэтгэл зүйч, харуул хамгаалалтын ажилтнууд, сургуулийн багш, хорооны нийгмийн ажилтан гэх мэтчилэн байж болно.

Эдгээрийн зэрэгцээ албан байгууллагын тодорхойлолт, эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд анх ирэхэд нь хүлээн авах үеийн бүртгэл мэдээлэл, тухайн хоригдогчийн үйлдсэн хэргийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл, хэрвээ дэглэм өөрчлөгдөж, шилжиж ирсэн тохиолдолд өмнө нь ял эдэлж байсан хорих ангийн нийгмийн ажилтны тодорхойлолт зэрэг бичиг

баримтууд нь мэдээллийн эх сурвалж болно.

Гадаадын зарим орны туршлагаас авч үзвэл хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албань хоригдогчийг анх хүлээж авахдаа хувийн намтар түүх, ерөнхий анкетийг бүртгэхийн зэрэгцээ эрүүл мэндийн үзлэгт хамруулж карт нээх, боловсролын түвшин, чадварыг үнэлэх тест бөглүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, дасан зохицох чадварыг үнэлэх зэргээр тодорхой мэдээллүүдийг бүрдүүлдэг бөгөөд нийгмийн ажилтан тухайн хоригдогчид үйлчилгээ үзүүлэх шаардлагатай тохиолдолд тэдгээрийг ашиглах боломжтой байдаг.

Мэдээллийг дээр өгүүлсэн эх сурвалжуудаас дараах аргуудаар цуглуулах боломжтой. Үүнд:

- Ганцаарчилсан ярилцлага хийх
- Янз бүрийн сорил, тест ашиглах
- Бодит болон хийсвэр нөхцөлд ажиглах
- Асуулга бөглүүлэх
- Холбогдох бичиг баримтуудыг уншиж, судлах
- Эко зураглал, геноргам, амьдралын түүхийн тор, нийгмийн дэмжлэгийн сүлжээний тор, нэгдмэл загвар гэх зэрэг тодорхой зорилго бүхий мэдээлэл цуглуулах техникүүдийг ашиглаж болно.

Мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатанд үйлчлүүлэгчид тулгамдаад байгаа асуудлын мөн чанар, түүнд үзүүлж буй үйлчлүүлэгчийн хариу үйлдэл, тухайн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой үйлчлүүлэгчийн чадвар, боломж, нөөц, дэмжлэг туслалцаа зэрэг бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, чухам ямар үйлчилгээ тухайн үйлчлүүлэгчид тохиромжтой болох нь тодорхой болсон байдаг. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний ерөнхий зорилго, чиглэл тодорхойлогдсон байна.

3. **Үйлчилгээний төлөвлөгөө боловсруулж, гэрээ байгуулах:**

Нөхцөл байдлын үнэлгээ хийх үе шатанд тухайн үйлчлүүлэгч, түүний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл, үйлчлүүлэгчийн хэрэгцээ, үзүүлэх үйлчилгээний чиглэл тодорхой болсон байх тул тэдгээрийг ашиглан цаашид хэрэгжүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна. Нийгмийн ажлын зарим ном, сурах бичигт үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах үйл явцыг нөхцөл байдлын үнэлгээний нэг хэсэг буюу хамт нэг үе шатанд авч үзсэн байдаг. Гэвч ихэнх тохиолдолд төлөвлөгөө боловсруулах үе шатыг тусад нь авч үзсэн байдаг бөгөөд энэ нь практикийн хувьд илүү ач холбогдолтой юм.

Үйлчилгээний төлөвлөгөө боловсруулахад тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд тухайн үйлчлүүлэгчийн онцлогт тохируулан, түүнд байгаа нөөц боломжуудыг ашиглан, үйлчлүүлэгчийн хүсч буй зүйл буюу тавьсан зорилгодоо хүрэх хамгийн оновчтой, үр дүнтэй арга замыг сонгох нь чухал. Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанаас хүлээж буй тодорхой үр дүнгээс гадна өөр гарч болох бусад үр дүнг тооцоолж, төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй. Төлөвлөгөө боловсруулах үе шатанд нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчтэй хамтран дараах зүйлсийг хийнэ. Үүнд:

- Үйлчилгээний зорилгыг оновчтой, тодорхой байдлаар томъёолох
- Зорилгодоо хүрэх арга замуудыг тодорхойлох
- Хэн, юу хийхийг тодорхой болгох
- Тэдгээр зүйлсийг ямар хугацаанд хийж гүйцэтгэхийг тодорхойлох
- Хэзээ хувилбарт төлөвлөгөө шаардлагатай болохыг тодорхойлох
- Шаардлагатай нөөц, эх сурвалжуудыг тодорхойлох
- Үйлчилгээг хэзээ дуусгавар болгохыг тодорхойлох

Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын үйлчилгээний хувьд дэглэмийн онцлог, ялгаатай байдлаас хамааран хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга, ашиглах нөөц боломж, хугацаа зэргийг тохиромжтой байдлаар тодорхойлох хэрэгтэй. Ерөнхий нийгмийн ажлын практикт нийгмийн ажилтан, үйлчлүүлэгчийн хамтын ажиллагаа чухал байдаг. Тухайлбал, үйлчлүүлэгчийн хүсэл, хэрэгцээ, үйлчилгээний зорилгыг нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоёр хамтран зөвшилцөж, тодорхойлдог. Харин хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажлын үйлчилгээний хувьд тодорхой тохиолдолд нийгмийн ажилтан байгууллагын зорилго, чиглэл, үйл ажиллагаа болон нийгмийн хэрэгцээ шаардлагын улмаас үйлчлүүлэгчийн өмнөөс үйлчилгээний хэрэгцээ, зорилго, үйл ажиллагааг бие даан, эсвэл мэргэжил нэгт нөхдийн хамт тодорхойлж болно. Хэдийгээр сайн дурын бус үйлчлүүлэгч байж болох ч шаардлагатай тохиолдолд хоригдогчдыг нийгэмшүүлэхэд чиглэсэн албадан сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг интервенцийг төлөвлөгөөндөө тусгана гэсэн үг.

Нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөхийн тулд ял эдлэх нийт хугацаа, тухайн хорих ангид байх хугацаа, үйлдсэн гэмт хэргийн төрөл хэлбэр, нас, хүйс зэргийг харгалзан үзнэ. Эхний 1-3 дах уулзалтууд ихэвчлэн судлах, нөхцөл байдлыг

үнэлэхэд чиглэгдэнэ. Харин асуудлыг шийдвэрлэх буюу үйлчилгээ үзүүлэх уулзалтын тоо нь тухайн хоригдогчийн асуудал, орчны нөхцөл байдлаас хамааран янз бүр байна.

Гэрээ байгуулах нь сайн дурын үйлчлүүлэгчийн хувьд өөрийн хүсч буй зорилгодоо хүрэхийн тулд, харин сайн дурын бус үйлчлүүлэгчийн хувьд хэдийгээр нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, улмаар эцсийн дүнд өөрт нь үр ашигтай байх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хариуцлага хүлээж, түүндээ эзэн болоход тустай байх болно. Үйлчилгээний төлөвлөгөөний нэлээдгүй зүйлсийг гэрээний маягтад тусган оруулдаг. Тухайлбал, үйлчилгээний зорилго; хэн, юуг, ямар хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай; үйлчилгээний үр дүнг хэрхэн тооцох гэх мэтчилэн. Үйлчлүүлэгчтэй хийх гэрээний маягтын олон янзын загвар байдаг бөгөөд хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь дэглэмийн ялгаатай байдлаа харгалзан өөрийн гэсэн нэгдсэн загварыг ашиглах хэрэгтэй.

4. **Төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх (интервенци) ба мониторинг хийх**:

Интервенци гэдэг нь нийгмийн ажлын үйлчилгээний хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Тэдгээр үйл ажиллагаа нь үйлчилгээний зорилгоос хамааран янз бүр буюу маш өргөн хүрээтэй байна. Тухайлбал, хоригдогчийн зан үйлийг өөрчлөх буюу сөрөг зан үйлийг бууруулах эсвэл өөрийнх нь эерэг зан үйлийг улам батжуулж, хөгжүүлэх, шинэ зан үйлийг хэвшүүлэх; амьдрах арга ухаанд сургах; тодорхой үйлчилгээ авахад гэр бүлд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх; уур бухимдлаа зохицуулж сурах сургалтад хамруулах; өрхийн төсөв, тооцоо хийж сургах; асуудлыг даван туулах чадварт сургах; мэргэжлийн чиг баримжаа олгох; тодорхой түвшний боловсрол эзэмшүүлэх гэх мэтчилэн. Эдгээрээс гадна интервенци нь үйлчлүүлэгчтэй зөвхөн ярилцаж, түүнийг сонсож, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх хэлбэрээр ч байж болно. Ингэснээр тухайн үйлчлүүлэгч аливаа зүйлийг өөрөөр бодож, олж харахад тусалсанаар түүний амьдралын шинэ хуудсыг ч нээж өгч чадна.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтнууд болон холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран тодорхой интервенцүүдийг хөтөлбөр байдлаар боловсруулан хэрэгжүүлэх боломжтой. Жишээ нь, Нийгмийн харилцаанд ороход шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, Хорт зуршлаас татгалзуулах хөтөлбөр, Суурь боловсрол олгох хөтөлбөр, Мэргэжлийн боловсрол олгох

хөтөлбөр гэх мэтчилэн. Гэхдээ эдгээр инвервенцийн хөтөлбөрүүд нь хорих ангийн дэглэм тус бүрт өвөрмөц онцлогтойгоор хэрэгжих шаардлагатай байж болно. Тиймээс дэглэм тус бүрт ялгаатай байдлаар ашиглах боломжтой хувилбаруудыг боловсруулах нь чухал.

5. **Үйлчилгээний үр дүнг үнэлж, үйлчилгээг төгсгөх:**

Үйлчилгээг үзүүлж дуусах үед үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт, үйлчилгээний үр дүнг үнэлнэ. Эцсийн үнэлгээг хийх нь үйлчилгээний үр дүнг тооцохоос гадна дараагийн удаа ижил төстэй асуудалтай өөр үйлчлүүлэгчид тус үйлчилгээг үзүүлэхэд юуг анхаарах, цаашид хэрхэн сайжруулах зэргийг тодорхойлох ач холбогдолтой. Үйлчилгээг үнэлэхэд тоон, чанарын, объектив, субьектив үнэлгээний аргууд, стандартчилагдсан сорил, тест, өөрийн үнэлгээ, эргэцүүлэл гэх мэтчилэн олон төрлийн аргыг ашиглаж болно.

Үйлчилгээний үр дүнг тодорхойлсоны дараа үйлчилгээг төгсгөнө. Зарим байгууллагын хувьд үйлчилгээг төгсгөх сүүлийн уулзалтын үеэр үйлчилгээний үр дүнг тодорхойлж, үйлчлүүлэгчид гарсан өөрчлөлт ахиц дэвшлийн талаар болон цаашид үйлчлүүлэгч хэрхэн бие даан асуудлаа шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нийгмийн ажилтанд дахин хандаж болох тухай ярилцдаг. Үйлчилгээг төгсгөх талаар эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний явцад үйлчилгээ тодорхой хугацаатайгаар үргэлжлэх бөгөөд үйлчилгээ дуусахад хэр хугацаа үлдэж байгааг сануулж байх нь зүйтэй. Үйлчилгээг төгсгөх уулзалтын хөтөлбөртөө нийгмийн ажилтан, үйлчлүүлэгч хоёр үйлчилгээний үр дүн, үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшлийн талаар ярилцахын зэрэгцээ харилцан бие биедээ талархлын үг хэлэх, дурсгалын зүйл өгөх зэрэг зүйлсийг оруулж болно.

Дүгнэлт:

Дээрх зүйлээс та бүхэн тодорхой нэг салбарын нийгмийн ажлын үйлчилгээнд ашиглах интервенцийн бэлэн жор гэж байдаггүйг ойлгосон бизээ. Хэдийгээр ерөнхий нийтлэг хэрэглэгддэг интервенци байж болох ч үйлчлүүлэгчийн онцлог, өвөрмөц байдал, түүний ялгаатай орчин болон нөхцөл байдал, мэргэжилтний ур чадвар, үйлчилгээг үзүүлэх орчин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан шууд таарч тохирох интервенци гэж бараг л үгүй. Тиймээс ямар ч салбарын нийгмийн ажилтан өөрийн үйлчлүүлэгчид тохирох өвөрмөц интервенцийг оновчтой сонгож, тохиргоо хийн, хэрэгжүүлэх хэрэгтэй. Хэрвээ та мэргэжлээрээ төдийлөн туршлагажаагүй байгаа бол үүнийг туршлагатай нийгмийн

ажилтнууд, ахлах нийгмийн ажилтнууд эсвэл мэргэжлийн зөвлөлөөр хамтран хэлэлцэж хийх нь тохиромжтой байх болно.

Интервенцийг хэрэгжүүлэх явцдаа түүний тохиромжтой байдал, үйлчлүүлэгчид гарч буй ахиц өөрчлөлт, үр дүнтэй байдлыг үнэлэх нь нийгмийн ажлын үйлчилгээний нэгэн чухал үйл явц юм. Явцын үнэлгээ буюу мониторингийг хэзээ, ямар аргаар хийхийг үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан байдаг. Нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх явцад мониторингийг хэд хэдэн удаа хийж болох бөгөөд энэ нь үйлчилгээг өөрчлөх шаардлагатай эсэх, эсвэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтойг тодорхойлж өгнө. Ихэнх тохиолдолд үйлчилгээний ерөнхий хугацаанаас хамааран, үйлчилгээг тогтвортой үзүүлж эхэлснээс хойш 1-2 долоо хоногийн дараа эхний мониторинг хийх боломжтой. Мониторинг хийхэд хэрэглэдэг ерөнхий аргуудын зэрэгцээ үзүүлж буй үйлчилгээтэй уялдуулан өвөрмөц аргуудыг ашиглаж болно. Тухайлбал, үйлчлүүлэгчийн харилцааны ур чадварыг сайжруулах интервенцийг хэрэгжүүлсэн бол тухайн үйлчлүүлэгч бусадтай хэрхэн харилцаж байгааг бодит нөхцөлд ажиглаж, тэмдэглэл хөтлөх; харилцааны ур чадвараа хэрхэн ашиглаж, дадал хэвшил болгож байгаа талаар асуулга бөглүүлж, өөрийн үнэлгээ хийлгэх гэх мэт аргуудыг хэрэглэж болно.



Г.ХОСБАЯР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, ахмад

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДАД ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хураангуй: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан хаагчдын дотор хуульд заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг субъект бөгөөд албан хаагчийн эрхийг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн зохицуулалт нь нийгмийн болон хувь хүний хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх, шийдвэрлэгдвэл зохих тулгамдсан асуудлуудыг хөндөн гаргаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, эрх зүйн байдал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн баталгаа, тусламж, дэмжлэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаа, эрх зүйн баталгааг Монгол Улсын “Төрийн албаны тухай”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, холбогдох хууль, эрхийн актаар зохицуулдаг.

Байгууллагын үйл ажиллагааны үр дүн нь албан хаагчдын идэвх санаачилга, ажлын ур чадвар, бүтээлтэй салшгүй холбоотой бөгөөд алба хаагчдын ажлын үр дүн нь тэдний ажиллах баталгааг хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн тусгаж өгснөөс хамаарна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах болзол шалгуур холбогдох шаардлагыг хангасан иргэнийг төрийн тусгай албанд авч ажиллуулсаны үндсэн дээр төрийн албан хаагчийн эрх зүйн харилцаа үүсч, албан хаагч нь бүрэн эрхийнхээ дагуу төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, энэхүү харилцааны явцад төрийн захиргааны байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, тэдэнд үзүүлэх тусламж, дэмжлэгээр хангах үүргийг хуулиар хүлээдэг.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг

иргэнийхээ өмнө хариуцна” [1] гэж заасан байдаг.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүмүүнлэг, ардчилсан нийгмийн[2] үед нийгмийн гишүүн бүр улс орныхоо аль нэг салбарт ажиллаж, хөдөлмөр эрхэлж, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчноор хангуулж, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлж, түүнд тохирсон, амжиргаандаа хүрэлцэхүйц цалин хөлс авч байх нөхцлийг бүрдүүлэх нь төрийн өөрийнх нь үүрэг гэж ойлгож болно. “Эрх зүйт” төр нь хуулийг дээдэлдэг, иргэний нийгмийн хяналтад байдаг, хүний эрх, эрх чөлөөг хангадаг, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлдэг мөн бодитой хамгаалдаг байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч нь Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдана ажиллана”, мөн зүйлийн 3-т “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”[3] хэмээн төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг хэрхэн тогтоох, хангах арга зам, үүргийг зааж эх сурвалжыг тогтоож өгсөн.

Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1-д “Иргэдэд адил, тэгш, хүртээмжтэй үйлчилдэг, ил тод хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүмүүсээр бүрдүүлэх бодлого баримтлана”, 3.3.2.6-д “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, мэдлэг, чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, цалин хангамжийг нэмэгдүүлж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”[4] гэж заасан.

Төрийн албан хаагчид тусламж дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалт нь хүний хэрэгцээ шаардлага, эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хангахтай холбоотой төр – төрийн албан хаагчдын хоорондын харилцааг илэрхийлсэн нийгмийн өргөн хүрээтэй асуудал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан хаагчдын дотор хуульд заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг субъект бөгөөд алба хаагчийн эрхийг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, боловсронгуй болгох шаардлага, хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна.

[1] Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1
[2] Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1
[3] Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот, 1992 он, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, №1

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаас төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөн... төрийн албаны янз бүрийн төрөл-тусгай шинжээр тодорхойлогдоно [5] гэж онолын хүрээнд тодорхойлсон байна.

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь эрх, үүргийн нийлбэр цогц, хариуцлага болон тэдэнд үзүүлэх тусламж, дэмжлэг бусад бүрэлдэхүүн хэсэг, шинжийг өөртөө багтаасан хэд хэдэн элементүүдийн нарийн төвөгтэй, иж бүрэн төрөл-хэсэг юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч нь төрийн тусгай албан хаагч[6] тул бусад төрийн тусгай албан хаагчдын адил нийгмийн хамгаалалд хамрагдаж, нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх эрхээ хангах баталгааг төрөөс шаардах эрхтэй.

Төрийн албан хаагчид үзүүлэх дэмжлэг, тусламжийн товч утгаар тодорхойлон авч үзвэл “хуульчлан тодорхойлсон эрхийг бодитойгоор эдлүүлэх, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, хууль зүйн цогц ойлголт” гэж тодорхойлж болох юм.

Төрийн албан хаагчид үзүүлэх дэмжлэг, тусламж нь төрийн албан тушаал эрхэлж байгаа бүх хүнд нэгэн адил хамааралтай. Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуульд баталгааг зориулалт, шинж байдал, эх үүсвэр, онцлог зэргийг харгалзан цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж гэж төрөлжүүлсэн.

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 27 дугаар зүйлд төрийн албан хаагчийн баталгааг, 28 дугаар зүйлд төрийн албан хаагчийн цалин хөлсийг, 29 дүгээр зүйлд төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөрийг, 30 дугаар зүйлд төрийн албан хаагчид олгох тусламж, 31 дүгээр зүйлд төрийн албан хаагчид олгох шагнал урамшил, 32 дугаар зүйлд төрийн

---

[4] Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УБ хот, 2010 он.

[5] Старилов.Ю.Н. Курс общего административного права. 2002, С 35.

[6] Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Монгол банкны ерөнхийлөгч, тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний байгууллагын дарга, дипломат албан тушаал, зэвсэг хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, хууль заасан бусад албан тушаал хамааран.

албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг тусган хуульчилсан юм.

Төрийн албан хаагийн эрх зүйн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, 25, 27.2.1, 27.2.2, 27.2.3 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-д “хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах”-аар тусгасан.

Мөн Иргэний хуулийн 498.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэл/-ийн улмаас бусад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана”, мөн хуулийн 498.4-т “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж заасан.

Мөн эдгээр хуулиудаас гадна төрийн тусгай албан хаагчийн хувьд салбар байгууллагын тухай хуулиар давхар эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг заасан. Тухайлбал, Шүүхийн тухай хуулийн 76-87 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 33-38 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд нийгэм, эдийн засаг, эрх зүйн нэмэгдэл баталгааг заажээ.

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч /энэ хуульд цаашид "цэргийн албан хаагч" гэх/ нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” [7] гэж хуулийн зорилтыг тодорхойлсон бөгөөд “цэргийн албан хаагч”-д хамаарч, нийгмийн хамгааллын тусгай арга хэмжээнд хамрагдах субъект нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч” байхаар хуульчлан тогтоосон байна. Энэхүү хуулиар цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллын арга хэмжээний тогтолцоог:

1. Цэргийн тэтгэвэр:
2. Цэргийн тэтгэмж:

[7] Төрийн мэдээлэл, 2014, дугаар 9

• хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

• нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж

• нэг удаагийн тэтгэмж

• жирэмсний болон амаржсаны тэтгэмж гэсэн төрөлтэй байдаг.

“Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн эдийн засаг, нийгмийн эрхийг хангах эрх зүйн зохицуулалтын тогтолцоонд голлох байр суурийг эзэлдэг эрх зүйн эх сурвалжийн нэг билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй албан хаагч нь Төрийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан нас, ажилласан жилийн шалгуур үзүүлэлтийг хангасны дагуу цэргийн алба хаасны болон цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэвэрт тогтоолгож, хуульд заасны дагуу 18 – 36 сарын нэг удаагийн тэтгэмжийг авдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас сүүлийн 6 жилийн байдлаар нийт 465 албан хаагч тэтгэвэрт гарсан бөгөөд тоон үзүүлэлтээр авч үзвэл 2011 онд 45, 2012 онд 72, 2013 онд 114, 2014 онд 119, 2015 онд 63, 2016 онд 52 албан хаагч тус тус цэргийн алба хаасны болон цэргийн алба хаасны хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 405 дугаар тогтоолоор батлсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг батлсан нь Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгосон төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэ журмыг мөрдөхөөр заасан байна.

Дэмжлэг, туслалцаа гэдэг ойлголт нь хүн өтлөх, осол гэмтэлд орох, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах, өвчлөх, сурч боловсрох, гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртөх зэргээр хэвийн байдлаар амьдрах нөхцөл алдагдахад төрийн зүгээс тусламж, дэмжлэг үзүүлж буй үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцаа бөгөөд нийгмийн хүрээнд эдлэх эрхийг хангахад чиглэгдсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн шинжтэй арга хэмжээний цогц ойлголт юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх тухай ойлголт нь өргөн утгаараа хүний эрхийг хангах, явцуу утгаараа төрийн тусгай албан хаагчийн нарийвчилбал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан

хаагчийн үйл ажиллагаатай уялдаатай яригдах асуудал юм.

Төрийн жинхэнэ албан хаагчид үзүүлэх дэмжлэг тусламж нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид мөн нэгэн адил хамаарах нийтлэг баталгаанаас гадна зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид хамаарах тусгай баталгааг хуулиар тогтоосон байдаг.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуулиар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь шийдвэр гүйцэтгэгч болон хорих байгууллагын албан хаагчаас бүрдэнэ”[8] гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан нь дараах эрх зүйн баталгаа, дэмжлэг, туслалцаагаар хангагддаг.

• Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авах;

• Албан үүргээ биелүүлж яваад амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгох;

• Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэмж авч байсан нийт хугацаанд олгох ба хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс авах;

• Жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар байгууллагын зардлаар хооллох;

• Шилжин томилогдох үед гэр бүлийн гишүүд болон ачаа тээшийг байгууллагын тээврийн хэрэгслээр хүргэх боломжгүй бол шаардагдах зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож олгох;

• Офицер, ахлагч ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт очиж, ирэх бол замын зардлыг автомашин, төмөр замын тээвэрт тухайн үед мөрдөж байгаа үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох.

• Хорих байгууллагын албан хаагчид үндсэн цалингаас гадна, хоригдолтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцлийн [9] болон тусгай албаны, цэргийн цол, зэрэг дэвийн нэмэгдэл

[8] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он. 132 дугаар зүйлийн 132.1 дэх заалт.

[9] Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 189 дүгээр тогтоол.

олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

• Хорих байгууллагад ажилласан хугацааг тооцоход цагдан хорих байр, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндан болон сүрьеэг эмчлэх ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, насанд хүрэгсдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагч, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, эрүүл мэндээр халагдах болон амины сууц барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно гэж хуульчилсан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчид үзүүлэх дэмжлэг тусламжийн нэгэн чухал үзүүлэлт болсон юм.

• Мөн Шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, албан хаагч тэтгэвэрт гарахаас өмнө 1 жилийн дотор төрийн зардлаар тодорхой сургалтанд хамрагдах эрхийг эдэлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтын тогтолцоо нь:

• Монгол Улсын Үндсэн хууль;

• Монгол Улсын хуулиуд; (Төрийн албан тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль гэх мэт)

• Хууль эрхийн бусад актууд; (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад тусламж дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулсан, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан эрхийн актууд)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад тусламж, дэмжлэг үзүүлэх тогтолцоог:

1. Цалин хөлс
2. Тэтгэвэр
3. Тэтгэмж
4. Тусламж
5. Нөхөн олговор
6. Хөнгөлөлт, үйлчилгээ
7. Бусад арга хэмжээ гэж бүлэглэн авч үзэж болно.

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 218 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам, 2004 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 112 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад тусламж олгох нөхцөл, журмыг тус тус баталсан.

Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг тогтоосон уг тогтоолд төрийн албанд эргэж орох эрхтэйгээр халагдсан,

хуульд заасан тодорхой үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн захиргааны алба хаагчид, тухайн албан хаагчийн ажиллаж байсан албан тушаалын нэг сарын цалингаас хэтрэхгүй хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байсан байгууллага нь олгохоор заасан байна.

Орон сууцны дэмжлэгийн мөнгөн дүн нь Засгийн газрын 2009 оны 368 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журам”-д заасан төрийн албан хаагчид олгох орон сууцны зээлийн хэмжээтэй адил байхаар тусгажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад үзүүлж буй тусламж дэмжлэг, эрх зүйн баталгааг бусад хууль сахиулах байгууллагуудтай харьцуулан судлахад тухайн байгууллагын чиг үүрэг, онцлогоос шалтгаалан өөр өөр байдлаар тусгагдсан байна.

Эндээс тодорхойлон авч үзвэл эрх зүйн баталгаа гэдэг нь хэм хэмжээг төрөөс тогтоон хуульчилсан, хэрэгжих нөхцөл боломжоор төрийн албадлагаар хамгаалагдсан, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн, зөрчигдсөн тохиолдолд хөндөгдсөн эрх, эрх чөлөөг сэргээн эдлүүлэх боломжийг бүрдүүлсэн заавал биелэгдэх шинжтэй эрх, үүргийн нийлбэр гэж тодорхойлон хэлж болохоор байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдаж нийгмийн олон талт харилцаа, үзэгдлүүд даяарчлагдаж, улам зохион байгуулалттай болж байгаа өнөө үед албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, материаллаг хангамж бэхжээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдийн эрх зүйн баталгаа, түүний дотор тэдэнд тусламж дэмжлэг үзүүлэх зарим эрх зүйн зохицуулалт хангагдаагүй нь тулгамдаж буй асуудлын нэг билээ.

Монгол Улсын Их хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах”, “ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох” зорилтыг дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193 дугаар тогтоолоор “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”-ийг баталсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх тухай шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх зүйн байдлыг хэвээр хадгалж дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг нэмж тусгаж өгсөн байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна энэ хуульд заасан улс төрийн, хууль зүйн, эдийн засгийн, нийгмийн болон бусад баталгааг нарийвчлан тусгасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдад үзүүлж буй тусламж, дэмжлэгийг боловсронгуй болгоход гарч ирсэн нэгэн том чухал үзүүлэлт болсон гэдэгт судлаачийн зүгээс үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн улс төрийн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглох, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцохыг шаардсан бол татгалзах эрхтэй байхаар заасан. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглах, алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглохоор тусгасан.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль зүйн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгсөн мэдэгдэл, шаардлагыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, заавал биелүүлэх ба биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зааж, иргэн, албан тушаалтан хэн боловч шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглохоор заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь албан үүргээ хууль ёсоор гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй бөгөөд алба хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг Засгийн газар хариуцахаар тогтоосон.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч ажлын бус цагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил

тооцож, мөн албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг шийдвэр гүйцэтгэх байгууллага хариуцахаар болжээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгаанд дараах баталгаануудыг шинээр оруулж өгчээ. Үүнд, Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан мөн Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол тохиолдолд тухайн алба хаагчийн гэр бүлийн нэг гишүүнд түүний сүүлд авч байсан үндсэн цалинг баримтлан 10 жилийн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгохоор тусгасан байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмжээс гадна Засгийн газрын нөөц сангаас дараах нөхөх олговор, тусламж олгохоор тусгасан байна. Үүнд: хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор, хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүүг олгохоор заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагад офицер, ахлагч болон энгийн орон тоонд ажилласан хугацааг тооцоход цагдан хорих байр, хаалттай хорих анги болон сүрьеэг эмчлэх хорих ангид нэг жил ажилласан хугацааг нэг жил гурван сар, нээлттэй хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг, бусад нэгж, сургалт-хүмүүжлийн тусгай болон шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад нэг жил ажилласан хугацааг нэг жил хоёр сар ажилласанд тооцохоор тус тус заасан нь ихээхэн чухал заалт болсон.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эдийн засгийн баталгаанд Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл ***түүний гэр бүлийг тэргүүн ээлжинд түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах, ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд*** ажилгүй байсан хугацааны эрүүл

мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгохоор тусгажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжинд, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно. Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгохоор тус тус заажээ.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн бусад баталгаанд аймгийн төвөөс бусад суманд томилогдсон шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээх, аймгийн төвөөс бусад сум, суурин дахь хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт тасралтгүй таван жил ажилласан алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгохоор заасан нь хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах, тэдний ахуй хангамжинд тодорхой хэмжээнд тусламж, дэмжлэг үзүүлж байгаа томоохон илэрэл гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт ажилласан таван жил тутамд Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдлэхээр тогтоосон байна.

Мөн ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид түүний зөвшөөрснөөр эдлээгүй хоног тутамд үндсэн цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгож болохоор заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид үндсэн цалингаас гадна, ялтан, хоригдогчтой ажилласны, төрийн алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн болон тусгай албаны, цол, зэрэг дэвийн нэмэгдэл олгох ба нэмэгдлийн

хэмжээг Засгийн газар тогтоохоор тусгасан байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа энэхүү үйл явц нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг биелүүлэх үүднээс Үндсэн хуульд тунхагласан зарчим, үзэл санаaны дагуу төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг хангах, албан хаагчдын ажиллах таатай орчинг бүрдүүлэх, тэдэнд тусламж, дэмжлэг үзүүлэх эрх зүйн үндэс, таатай орчинг бүрдүүлэхэд оршиж байна гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад эрхийн актаар хуульчилсан эрх зүйн баталгаа, албан хаагчид үзүүлэх тусламж, дэмжлэгийг баталгаатай эдлүүлэх эрх зүйн иж бүрэн шинэтгэл хийх шаардлагыг өнөөгийн нийгмийн олон талт харилцаа нөхцөлдүүлж байна. Энэ хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байгаа нь цаг үеэ олсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн хэм хэмжээг тусган өгсөн нь шинэлэг, ололттой тал болжээ.



УРУСОВ А.А.
Кандидат
юридических наук,
доцент,
Омская академия
МВД России

К ВОПРОСУ О НЕОБХОДИМОСТИ ИНСТИТУТА ПРОБАЦИИ В РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

Статья посвящена проблемам организации контроля за лицами освободившимися из исправительных учреждений и оказание им помощи в социальной адаптации.

Ключевые слова:

Исправительные учреждения	Correctional institutions
Пробация	Probatio
Постпенитенциарный контроль	Pre-prison control
Ресоциализация	Resocialisation
Условно-досрочное освобождение	Pre-time libertation

В условиях реформирования уголовно-исполнительной системы России (далее УИС) особое внимание уделяется развитию учреждений, исполняющих уголовные наказания без изоляции от общества. Депенелизация уголовных наказаний является одним из направлением уголовной политики государства по разрешению проблемы по ограничению применения лишения свободы в практике борьбы с преступностью. [1]

В настоящее время в научной литературе при обсуждении проблем применения наказаний, альтернативных лишению свободы, достаточно часто обсуждается необходимость создания в России службы пробации. О необходимости создания службы пробации говорится в «Концепции развития уголовно-исполнительной системы Российской Федерации до 2020 года», утвержденной распоряжением Правительства Российской Федерации от 14 октября 2010 г. № 1772-р (далее Концепция), как отмечается в Концепции, государство нацелено на преобразование УИС в современную, соответствующую требованиям международных стандартов службу социальной реабилитации для обеспечения мер по положительной социальной ориентации осужденных, их постпенитенциарной адаптации и предотвращение рецидива преступлений.

Институт пробации активно используется в большинстве зарубежных стран. Пробация (от лат. probatio–испытание) – юридический

термин, который используется в международной практике для определения названия и деятельности службы, которая исторически создалась для организации работы с лицами, осуждёнными к наказаниям без изоляции их от общества или освобождёнными из-под заключения. [2]

В большинстве стран такие службы уже созданы. Как правило, это государственные внеполицейские, внепенитенциарное, а часто гражданское ведомство, основными направлениями деятельности которого являются развитие и организация политики исполняемых в обществе уголовных наказаний и оказание помощи лицам после освобождения из мест лишения свободы. Так, например, в Англии институт пробации (условная отсрочка исполнения наказания с помещением на это время преступника под индивидуальный надзор и с обеспечением над ним руководства или проведения исправительного курса) существует на протяжении многих десятилетий. Этот институт появился в Англии в 1887 г. в связи с принятием Закона «Об испытании впервые осужденных». В 1907 г. с принятием Закона «Об испытании преступников» этот институт окончательно сформировался в английском уголовном праве. В настоящее время нормы о пробации консолидированы в законах 1948 г. и 1967 г. об уголовной юстиции. Помимо этого в 1965 г. были изданы и Правила о пробации. [3]

В Финляндии в 1975 г. была основана Ассоциация по делам испытания и последующего ухода для помощи в решении социальных проблем условно освобожденных и освобожденных заключенных. Деятельность и финансы этой организации находятся под контролем и руководством Министерства юстиции. Цель её деятельности состоит в разносторонней помощи (психологическая поддержка, юридические консультации, решение проблем с жильем, трудоустройство) лицам, освобожденным или условно освобожденным. Руководство Ассоциации работает в тесном контакте с администрацией и социальными работниками тюрем с целью изменения условий отбывания наказания для скорейшей реадаптации желающих исправиться. [4]

Исходя из зарубежного опыта, институт «пробации» – это условное неисполнение назначенного наказания либо условное неназначение наказания с помещением осужденного на определенный срок под индивидуальный надзор специального должностного лица

(агента, помощника, уполномоченного по пробации). Пробация предполагает соблюдение следующих условий: несовершение новых преступлений и выполнение установленных приговором суда специальных обязанностей. Таковыми являются:

– прохождение курса соответствующего лечения;

– продолжение профессионального обучения;

– выполнение запрета суда на посещение определенных мест (увеселительных заведений, казино и других), а также на общение с потерпевшими, на приобретение и владение огнестрельным и (или) другим оружием;

– возмещение причиненного ущерба;

– сообщение суду о любом изменении места жительства и работы;

– явка в суд по вызову агента по пробации и т.д. В случае соблюдения этих условий правовыми последствиями пробации являются полное освобождение от какого бы то ни было наказания за совершенное преступление и отсутствие судимости как определенных правоограничений, являющихся следствием осуждения за преступление. [5]

Зарубежные службы пробации, как правило, выполняют следующие функции:

– оказание помощи лицам, освобождённым из мест лишения свободы;

– разработка и осуществление программ коррекции социального поведение поднадзорных лиц;

– контроль за поведением лиц, условно осуждённых или условно-досрочно освобождённых от наказания, оказывает им необходимую помощь.

Тема возможного заимствования в России зарубежного опыта постпенитенциарной адаптации осуждённых затрагивалась и раньше, и именно эти процессы актуализировали создание службы пробации и сделали очевидной неизбежность и неотлагательность этой задачи. Не создав институционные формы работы с правонарушителями, правоохранительные органы всегда будут заниматься профанацией в профилактической деятельности.

Есть целый ряд оснований для того, чтобы оптимистически смотреть на перспективы развития службы пробации в России. К такому убеждению приводят, прежде всего, прогнозы позитивных преобразований уголовно-исполнительной системы страны, особые надежды на которые внушают принятая Концепция.

В специальной литературе обсуждается вопроса о создании Федеральной службы пробации,

подведомственной Министерству юстиции РФ со следующими основными функциями:

1. Социально-реабилитационная и контролирующая деятельность в отношении:

– условно осуждённых;

– условно-досрочно освобождённых;

– осуждённых беременных женщин и женщин, имеющих малолетних детей, которым судом отсрочено отбывание наказание.

2. Независимый от следственных органов доклад суду о социальной опасности гражданина в процессе судебного следствия. Данная функция может быть использована при решении вопроса об избрании меры пресечения, вида наказания, а также при рассмотрении заявлений осуждённых об условно-досрочном освобождении.

3. Организация процедур примирения сторон и восстановления социальной справедливости, т.е. на определенной стадии уголовного процесса дело направляется медиатору, на которого возложена обязанность достичь соглашения между потерпевшим и преступником, от которого зависит, либо снятие обвинения, либо соглашение повлияет на вид и размер наказания.

4. Организация разработки программ коррекции социального поведения правонарушителей.

5. Оказание лицам, освобождённым из исправительных учреждений, постпенитенциарной помощи. [6]

Создание службы пробации позволит снизить нагрузку на уголовно-исполнительные инспекции и повысит эффективность применения иных мер уголовно-правового характера.

Следующим направлением по ресоциализации лиц, освобождённых из мест лишения свободы, является принятие Федерального закона о социальной адаптации осуждённых. В отличие от России, где законопроект находится в Государственной думе с 1995 года, в странах СНГ он уже принят и оказывает эффективное значение в вопросах предупреждения рецидивной преступности.[7] В данном законе в первую очередь должны быть определены министерства и ведомства, осуществляющие его исполнение. В первую очередь это Министерство внутренних дел, Федеральная служба исполнения наказания, Министерство юстиции и Министерство труда и социальной защиты.

В компетенцию указанных органов должны войти вопросы социального патронажа

освобожденных, деятельности специальных реабилитационных заведений для лиц не имеющих социально полезные связи на свободе, осуществления временного контроля за поведением освобожденных, профилактики совершения ими противоправных деяний.

Для реализации принятой Концепции, прежде всего, необходимо переработать законопроект о социальной адаптации осуждённых и принять его. Возможно, именно в этом законе определить задачи и функции службы пробации.

Кроме этого, целесообразно рассмотреть вопрос об установлении постпенитенциарного контроля за лицами, освобождёнными из исправительных учреждений, и определения их правового статуса в период социальной адаптации.

Нацеленность на создание цивилизованного института пробации, развитие у осужденных социально полезных связей, профессиональных и трудовых навыков, реализация программ социальной реабилитации в совокупности с изменением общественного правосознания позволяют надеяться, что обсуждаемая в статье проблема получит в перспективе адекватное, в интересах российского общества решение.

Список используемых источников

1. Подробнее об этом см.: Российская газета. – № 163(4987). – 2 сент. 2009 г.; Российская газета. – № 171(4995). – 11 сент. 2009 г.

2. См.: *Совершенствование* законодательства, практики назначения и исполнения наказаний, мер постпенитенциарного воздействия. – Рязань: Академия ФСИН России, 2009. – С. 58 – 59.

3. См.: *Гуценко К.Ф.* Уголовный процесс основных капиталистических государств. Вып. 1. – М., 1969. – С. 135.

4. См.: *Багреева Е.Г.* Субкультура осужденных и их ресоциализация: Монография. – М., 2001. – С. 100.

5. См.: *Курс* уголовного права. Общая часть / Под ред. Н.Ф. Кузнецовой, И.М. Тяжковой. Т. 2. Учение о наказании. – М., 2002. – С. 412; *Правовые* системы стран мира: Энциклопедический справочник.
3-е изд., перераб. и доп. / Отв. ред. А.Я. Сухарев. – М., 2003. – С. 417.

6. См.: *Совершенствование* законодательства, практики назначения и исполнения наказаний, мер постпенитенциарного воздействия. – Рязань: Академия ФСИН России, 2009. – С. 63 – 64; *Тексты* докладов участников научно-практической конференции по вопросам реформирования

уголовно-исполнительной системы // Ведомости уголовно-исполнительной системы. – 2009. – № 10. – С. 3 – 17.

7. См.: *Калашник Н.Г., Янчук О.Б.* Ресоциализация осужденных несовершеннолетних, отбывающих наказание в местах лишения свободы на Украине // Вестник института. – Вологда: Вологодский института права и экономики ФСИН России. – 2010. – № 1. – С. 56.



Д.НЯМТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, дэслэгч



О.ОДБАЯР
ШШГЕГ-ын харъяа Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлөөлөгч, дэслэгч

ХОРИХ АНГИЙН ЭКОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Экологи гэх асуудал нь байгалийн тэнцэл, амьд болон амьгүй организм[1] гэзд маш олон янзаар ойлгох нь бий. Гэхдээ нөгөө талаас уг ойлголтыг шууд хүний эрүүл мэндтэй холбон тайлбарладаг. Хорих байгууллага, экологи хэмээх ойлголтуудыг хооронд нь хоршуулж “Хорих байгууллагын экологи”-ийн асуудлыг судлахын ач холбогдол, цаашлаад хүний эрхийг дээдлэгч Монгол Улсын өнөөгийн байдалд хорих ангид ял эдлэгсдийн эрхийг хангахад дээрх асуудал хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох.

Түлхүүр үгс: Үндэсний аюулгүй байдал, хорих байгууллага, экологийн тэнцвэрт хөгжил, хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, ялтан, алба хаагч, ногоон орчин, ялтны амьдралын бүс.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2: “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, *экологийн тэнцвэрт хөгжил багтана* [2] хэмээн тусгаж өгсөн байна.Хорих ангид тодорхой эрхээ хязгаарлуулсан “хүн” хоригддог. Мөн “хүн” ажилладаг. Аль нэг хилийн дээс, барилга байгууламжаас үл хамаарах агаар гэх зүйлээр хүн бүр амьсгалж, хөрсөн дээр гишгэж экологи гэх ойлголттой салшгүй хамааралтай явдаг.Хүний эрх, эрх чөлөөний төлөөх тэмцэлд анхаарал татсаар ирсэн нэгэн зүйл бол хорих байгууллага дахь ял эдлэгсдийн эрхийн асуудал, тэдгээрийн орчин нөхцөл, ахуй гэж тодорхойлж болох юм.

Ялтан бол иргэн. Зарим эрхээ хязгаарлуулсан ч “Монгол Улсын

[1]Э.Батбаяр “Экологийн эрх зүй”.,1998 он.,УБ хот.,18 дахь тал.

Үндсэн Хууль”[3]-ийн 16-р зүйлийн 16.1.2 дахь заалтад: Монгол улсын “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах” эрхтэйг тусгасан байна.Ялтны амьдралын бүс нь жирийн иргэдийн амьдрах орчныг бодвол аливаа төрлийн агаар дуслын замаар дамжин халдварлах өвчин үүсэх магадлал тун өндөр. Тиймээс хорих ангид эко орчныг бүрдүүлэх асуудал шаардлагатай байгааг дурьдагдах судалгаанаас харж болно.

Хорих байгууллага ба экологи

Экологи гэдэг нь эко буюу орон зай, логи буюу орчноо судлах гэсэн үгнүүдээс гаралтай. Энэхүү нэр томъёог анх 1886 онд Германы эрдэмтэн А.Гекель гаргаж иржээ. Тэр “Экологи бол байгалийн тэнцвэрийн тухай ойлголт бөгөөд амьд бие ба түүний хүрээлэн буй орчны органик, органик бус бүрэлдэхүүн хэсгийн хоорондын харилцан хамаарлын тухай шинжлэх ухаан[4] ” юм гэж тодорхойлжээ. Гэхдээ өнөөдөр экологи гэдэг ойлголт нь зөвхөн байгаль орчны асуудал биш хүний амьдрах орчны бүхий л асуудлыг судалдаг өргөн хүрээний ойлголт болжээ.

Эрүүл байх нь хүний амьдралын хамгийн үнэ цэнэтэй зүйл, нийтийн нөөц баялаг мөн бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлсноор “Эрүүл мэнд” бол амьдралын чанарын тусгал бөгөөд зөвхөн өвчингүй байхаас хамаагүй өргөн хүрээний ойлголт юм[5] гэж тодорхойлсон байдаг.

Иймээс хүний амьдрах орчинд гарч байгаа өөрчлөлтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн ашигтай талыг давуу байлгах, орчны сөрөг нөлөөллийг тодорхой хэмжээнд багасгах хэрэгцээ шаардлагатай бөгөөд өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Экологи өнөөдөр зөвхөн биологийн шинжлэх ухааны нэг салбар төдийгүй байгаль, нийгмийн асуудлыг хамарсан нэгдмэл шинжлэх ухаан болсон байна. Нийгмийн үнэт зүйл, нийгмийг бүрдүүлэгч эд, эс бол хүн. Иймээс энэ салбар шинжлэх ухаан нь хүнтэй холбоотой нь харагдаж байна. Хүн байгаль хоёр хүйн холбоотой гэдэг, хорих байгууллага /хорих анги/-д хүн хоригдоно. Иймээс тухайн хорих байгууллага нь хүнийг хүрээлэн буй орчин нөхцөлтэй нь харьцах харьцааг бий болгох шаардлага гардаг.

Экологи нь дараах салбаруудтай:

1. Ургамлын экологи
2. Амьтны экологи
3. Бичил биетний экологи

[2] Монгол Улсын Их Хурлын тогтоол., 2010 оны 07 сарын 15 өдөр.,..УБ хот., дугаар 48

[3] Төрийн мэдээлэл сэтгүүл., 1992 он., №1.

[4] Ж.Нямхүрэл., Экологи., УБ хот., 2005 он., 5 дахь тал.

4. ХАА-н экологи
5. Үйлдвэрийн экологи
6. Хүний экологи

Үүнээс судалгааны салбар нь “Хүний экологи” юм. Хорих ангид ял эдэлж байгаа ялтны орчин буюу байгалийн нар, салхи, чийг, цэвэр агаар гэх мэт асуудлуудыг ойлгож болно. Нөгөө талаас хорих ял эдэлж байгаа ялтнууд нь нийгэмд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй хийснээр шийтгэгдэж хууль ёсны хүрээнд зарим нэг эрхээ хязгаарлуулсан боловч тэдэнд Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй юм.Үндсэн хуулийн 16-р зүйл:16.2 “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115-р зүйл:115.1.10 “Ялтан хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй”... гэсэн хэм хэмжээг хангуулахад хорих байгууллагын экологи гэсэн ойлголтын хүрээнд ямар нэгэн арга хэмжээг Монголын төрийг төлөөлж ял эдлүүлэх ажиллагааг явуулдаг, ялтны эрхийг хангах үүрэг бүхий байгууллагын хувьд энэ тал дээр тодорхой үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Хорих байгууллагын экологийн тухай ойлголтыг цаашид нарийвчлан авч үзвэл ялтны амьдралын бүс болон хориотой бүс дахь хүрээлэн байгаа орчныг бохирдлоос хамгаалах, улмаар хүн төрөлхтний байгальтайгаа шүтэлцэн амьдрах онолын үндсийг тодорхойлоход агуулга оршино.Мөн хорих ангийн хориотой бүс болон ялтны амьдралын бүсээс гадна байгалийн нөөц баялагтай холбогдон гарах олон төрлийн харилцаа байдаг.

Жишээлбэл:Аж ахуй, үйлчилгээнд ажиллаж буй ялтнууд, тэдгээрийг хянах алба хаагчдаар илэрч болох юм.Мөн хорих ангийн үйлдвэрлэлтэй холбоотой байгалийн баялгийг ашиглах харилцаа ч байдаг. Байгалийн баялгийг ашиглах талаар Монголын хорих байгууллага арвин их туршлага түүхтэй бөгөөд түүхэн эх сурвалжаас харахад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хорих ангийн үйлдвэрлэл мод, зүсмэл материал үйлдвэрлэж байгалийн баялгийг ашиглаж байсан. Энэ үед нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг эрчимтэй явуулж байсан.[6]

Модны үйлдвэрлэл явуулдаг хорих ангид ойн инженер, үржүүлгийн хэсэг салбар ч ажиллаж байсан. Тэд дан ганц байгалийн баялгийг ашиглаж байгаагүй бөгөөд

[5] www.monkey.mn/Дэлхийн эрүүл мэндийн чиг хандлага

[6] А.Лхагваа.,Гяндан салаанаас ШШГЕГ болж өргөжсөн түүхэн замнал., 2011 он.УБ хот.,120 дахь тал

байгаль хамгаалах үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж байсан нь түүхэн эх сурвалжаас харагдаж байна.

Жишээлбэл: Ард иргэдийн тавьсан ойн түймрийг унтрааж улс орны аюулгүй байдалд үнэтэй хувь нэмэр оруулж байв.

Хорих байгууллагын экологийн өнөөгийн байдал

Монгол Улсын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын байдлаар 25 хорих ангид 5400 гаруй ялтан хорих ял эдэлж байна[7]. Дээрхи 25 хорих ангиас сонгож 2 хорих ангид экологийн талаарх судалгааг явуулсан. Үүнд: Судалгааны явцад ШШГЕГ-аас хорих ангиудад эрсдлийн үнэлгээ хийгдсэн байгаа боловч “Хорих байгууллагын экологи”-ийн орчинд хийсэн судалгаа байхгүй, энэ талын судалгаа хийгдээгүй байсан. Тухайн төсөөллийг бататгахын тулд ШШГЕГ-ын харьяа Хорих 405, 415 дугаар ангийг сонгон авч ялтны амьдралын бүсийн зургийг судлан ажиглах аргаар ялтны амьдралын бүс дэх экологийн орчинг тогтоохыг оролдсон.

Хорих 415 дугаар ангид 400 орчим ялтан хоригдож байна.Тус хорих анги нь тал хээрийн бүсэд байдаг бөгөөд хөрсний хувьд элсэрхэг, ундны ус нь шохой, давс илэрдэг зэрэг байгалийн онцлог харагдаж байлаа. Хорих 415 дугаар ангийн ялтны амьдралын бүс дэх зургаас харахад зуны улиралд хүний харагдах ил хэсэгт цэцэг тарьж экологийн тогтцыг бүрдүүлдэг байна. Энэ нь улирлын чанартай үйл ажиллагаа юм.



Тус хорих ангид хоригдож буй нийт ялтны 50 гаруй нь шохой боловсруулах үйлдвэрт ажилладаг /Улирлын чанартай/.Ялтнуудын дийлэнх нь төдийгүй тэднийг хянаж буй алба хаагч нар амьсгалын замын өвчин /астам/ туссан байдаг. Гэтэл ногоон байгууламж нь хуурай бохир агаарыг өөртөө шингээн авч цэвэр агаар үүсгэдэг онцлогтой. Иймээс эко орчныг хорих ангид бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгардаг.

Хорих 405 дугаар ангид 80 гаруй ялтан хоригдож байна. Тус хорих анги нь Таширын аманд байрладаг бөгөөд газар нутгийн хувьд уулархаг, хар хөрстэй, байгалийн ногоон орчин бүрэлдсэн, дээр дурьдсан хорих ангиудыг

[7] ШШГЕГ-н нэгдсэн тоо бүртгэл, судалгаа, дүн шинжилгээний тасгийн судалгаанаас

бодвол эко орчин хэвийн хэмжээтэй байдаг. Харин гянданд ял эдлүүлэх үйл ажиллагааг гяндангийн байранд ялтны хөдөлгөөнийг хязгаарлан явуулдгаараа онцлогтой.

Иймд эко орчинг гяндангийн байранд харуул хамгаалалтын аюулгүй байдлыг ханган бүрдүүлэх боломжтой. Тасалгааны цэцэг, ургамал тарих г.м.



Дээрхи зурган дээрээс Хорих 405, 415 дугаар ангийн гадна орчныг харуулсан. Тус хорих ангиуд нь харагдах байдлын хувьд зүлэг ногоо ургасан ногоон орчин бий болсон боловч эко орчныг улам боловсронгуй болгон олон улсын болон стандартад нийцсэн орчинг бүрдүүлэх шаардлагатай юм. Энэ мэтчилэн тодорхой стандартын дагуу ногоон байгууламж бий болгох нь үндсэн хуульд болон бусад хууль тогтоомжид заасан ялтны эрхийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ юм.

Өнөөгийн хорих ангиудад хүний эрх, эрх чөлөөг хангах үүднээс ялтан этгээдийн ахуй нөхцлийн талаарх асуудлыг хөндөж тавьдаг боловч тухайн ялтны ахуйн хүрээн дэх тэр дундаа хүрээлэн буй орчин, ногоон бүс, ногоон байгууламжийн талаар авч үзээгүй нь хорих байгууллагын хэмжээнд тулгамдаж буй асуудал гэж үзэхэд болохоор байна.

Дүгнэлт

Экологийн асуудал нь хорих ангид тулгамдсан асуудал болсноор түүнийг нэн даруй шийдвэрлэх шаардлагыг бий болгож байна.

Экологийн асуудалд:

1. Ялтны болон алба хаагчийн эрүүл мэнд
2. Амьдрах тав тух
3. Хориотой бүсийн аюулгүй байдлыг хангах тал дээр хэрхэн холбогдох зэрэг асуудлуудыг шийдвэрлэх арга замыг олох юм.

Хорих ангид сэтгэл заслын өрөө гэж байдаг. Энэ нь нэг талаас л ялтны сэтгэл санааг засах, амраах, тогтворжуулах гэсэн зорилготой байдаг.Ийм орчинд сэтгэл заслын үйл ажиллагаа явуулахаас гадна хорих ангид амьд орчин бүрдүүлж /өвс ногоо, цэцэг, усны урсгал буюу бяцхан булаг горхи бүрдүүлэх/ ялтны сэтгэл заслын орчинг өөр өнцгөөс бий болгох нь ач холбогдолтойг гадны орны туршлагаас харж болохоор байна. Энэ нь мөн тухайн хорих ангийн алба хаагчдад ч эергээр нөлөөлөх юм. Алба хаагчид нь ажлын байр дээрээ ихэвчлэн стрессийн байдалд

орсон байдаг гэсэн судалгаа бий. Усны чимээ нь хүний уур бухимдлыг тайлж ядаргааг арилгадаг.Мөн ялтан болон алба хаагчийн уух усны хатуулаг, агаарын чийгшилт, нарны гэрэл зэрэг ахуй нөхцлийн асуудлууд бий.







Хорих ангийн ялтны амьдрах орчин нөхцөл дээрх зургийн дагуу байх ёстой боловч гадна орчин мөн энэ мэт тор, цементээр битүү хучигдсан байх нь учир дутагдалтай. Тиймээс ялтнуудын амьдралын бүс болон үйлдвэрлэлийн бүс нь ногоон байгууламж бүхий байх нь тал талаасаа ач холбогдолтой боловч харуул хамгаалалтын хэвийн ажиллагааг алдагдуулахуйц байж болохгүй.

Аливаа улсын Нийслэлийн 90 хувь нь ногоон байгууламж байна гэсэн олон улсын стандарт байдаг. Гэтэл манай улсын Нийслэл Улаанбаатар хотын ердөө 5 хувь нь ногоон байгууламж байдаг гэсэн харамсалтай тоо байна.

Ногоон байгууламж нь хүчилтөрөгч ялгаруулж, нүүрсхүчлийн хийг өөртөө шингээн агаар цэвэршүүлж, агаарын бохирдлыг бууруулдаг сайн талтай.

Ногоон байгууламжийг макро түвшин байгуулж чадахгүй байгаа ч микро түвшинд буюу хорих анги дотор бий болгох бүрэн боломжтой юм. Ингэснээр улс орны нийт хүн амын эрүүл мэндийг хамгаалах боломжгүй ч хэсэг бүлгийн буюу ялтан болон алба хаагчдын эрүүл мэндэд анхаарал хандуулах алхам болох юм.

Санал

1. Ялтанд экологийн боловсрол олгох.

Хорих ангийн дотоод журам 14.2: “Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтан ялынхаа хоёрны нэгээс доошгүйг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежид эчнээгээр суралцах хүсэлт гаргасныг хорих ангийн дарга дэмжсэн бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга ийнхүү суралцахыг зөвшөөрсөн тушаал гаргана.” гэх заалтыг 14.2-оор дэлгэрүүлж

“Эчнээгээр суралцах мэргэжил нь байгаль хамгаалах, экологийн чиглэлтэй байж, хорих ангийн бүс дахь экологийн асуудалд хувь нэмэр оруулахуйц суралцаж байгаа ялтныг хорих ангийн дарга эрхийн хүрээнд дэмжин урамшуулах” гэж нэмэх.

2. Ялтны сэтгэл заслын орчинг амьдралын бүсэд бодитоор бүрдүүлэх.

Ялтан зөвхөн хорих ангийн сэтгэл зүйчийн өрөөнд бус хорих ангийн хашаан дотроос сэтгэл заслыг авч чадвал ялтны дундаас үүсэх гэмт хэрэг, зөрчлийн тоо багасах төдийгүй сэтгэл гутралаас үүсэх өвчлөл, хямрал багасах ач холбогдолтой.

3. Ялтанд хөдөлмөрийн дадал, чадвар олгох ажлын хүрээнд мэргэжлийн цэцэрлэгч, үрсэлгээчин бэлтгэх

4. “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төсөл”-д хорих ангийн байгаль орчин гэсэн ойлголт байхгүй байгаа нь уг асуудлыг шийдвэрлэхэд энэ талаар хууль болон дүрэм журамд тусгаж өгөх шаардлагыг агуулж байна. Тиймээс “Хорих анги ба экологи” гэх ойлголтыг гаргаж ирснээр дараах асуудлыг эергээр бий болгох боломжтой./Эрүүл аюулгүй амьдрах орчин, эрүүл мэнд, хүний эрх эрх чөлөө, сэтгэл зүйн тогтвортой байдал, хандлага/... гэх мэт.

Эх сурвалжийн жагсаалт

Хууль тогтоомж:

1. Монгол улсын үндсэн хууль. 1992 он
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995 он
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. 2012 он
5. Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийх төсөл

Ном зохиол, сурах бичиг:

1. Л.Түвдэн “Хүний эрх” УБ хот., 2010 он
2. А.Элдэв-Очир “Хүний эрхийн хөндөгдөж буй асуудлууд” УБ., 2002 он
3. Б.Батболд “Экологи ба ахуй орчин” УБ хот., 1999 он
4. Ж.Нямхүрэл “Экологи” УБ хот., 2005 он
5. А.Лхагва “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” УБ хот., 2011 он
6. Э.Батбаяр “Экологийн эрх зүй” УБ хот. 1998 он
7. А.Лхагваа “Гяндан салаанаас ШШГЕГ болж өргөжсөн түүхэн замнал” УБ хот. 2011 он.



Б.АЛТАНГЭРЭЛ
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Шийдвэр
гүйцэтгэлийн
тэнхимийн эрхлэгч,
хууль зүйн ухааны
доктор /Ph.D/,
хурандаа

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ТУСГАГДСАН ИРГЭН, ЗАХИРГАА, ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд иргэнд учирсан эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг бүрэн нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нь гэмт этгээдийг олж илрүүлэн шийтгэхээс дутуугүй ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх,...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, журмыг тогтоосон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлан, мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

2002 оноос хойших хугацаанд иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон гүйцэтгэх баримт бичиг дунджаар нийт гүйцэтгэх баримт бичгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн бодит гүйцэтгэл оноос он дамжин 50 орчим хувьтай байсаар байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан зорилтын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна.

Дээр дурдсан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан 2017 оны 7 сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг шинээр тодорхойлж, шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих ажиллагааг журамлах шаардлагыг бий болгож байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагааг хамааруулахаар тусгажээ.Үүнд:

1.Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

1.Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаархи шүүхийн шийдвэр;

2.Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж[1];

3.Гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр;

4.Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр[2];

---

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74[1] 5.Иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүгч нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсний дагуу талууд эвлэрсэн бол шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулах захирамж гаргана.

74[1] 6.Иргэний хэрэг үүсгэснээс хойш шүүгч нэхэмжлэлийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлсний дагуу зохигчид эвлэрсэн бол шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснийг сэргээж, эвлэрлийн гэрээг баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргана.

74[1] 7.Шүүгч эвлэрлийн гэрээг хүлээн авснаас хойш долоо хоногийн дотор хянаж баталгаажуулна. Талуудын байгуулсан эвлэрлийн гэрээ ойлгомжгүй, тодорхой бус болсон, эсхүл энэ хуулийн 74[1].4-т заасныг зөрчсөн бол шүүгч эвлэрлийн гэрээг баталгаажуулахаас татгалзсан захирамж гаргана.

74[1] .8.Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ.

[2] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1.Эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр шийдвэрлэсэн, талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн болон цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг албадан гүйцэтгүүлэхээр бол уг цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт шүүхээр баталгаажсан байна.

184.2.Шийдвэрийг гүйцэтгүүлэхийг сонирхож байгаа тал цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа /оршин байгаа/ харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

184.3. Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, Арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, захиргааны шийтгэвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг биелүүлэх боломжийг нь

5.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар эрх шилжүүлсэн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр[3];

6.Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр;

7.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж.

2.Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1-д[4] заасан захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэр;

2.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж;

3.Хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

4.Шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамж;

3.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

1.Торгох шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэх хуудас;

2.Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураан авах тухай шийдвэр;

3.Хохирол, нөхөн төлбөр гаргуулах тухай шийдвэр;

4.Албадан эмчилгээнд хамруулах тухай шүүхийн шийдвэр;

5.Нийтэд тустай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр;

6.Шүүхээс гүйцэтгэх хуудас олгосон зөрчлийн хэргийн талаар гаргасан бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр.

4.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулна. Шүүгч нийтүү захирамж гаргасан даруй гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

[3] *Монгол Улсын Дээд шүүхийн* 2003 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн “шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 11 дугаар тогтоолд"Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар эрх шилжүүлсэн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр" гэдэгт албадан дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч этгээдээс уг албадан дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсэн тухай энэ хуулийн 48.9-д заасан асуудлуудыг тусгасан, түүний гарын үсэгтэй, бичгээр үйлдсэн баримтыг ойлговол зохино.

[4] 12.1.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр дараахь хэлбэртэй байна:
12.1.1.анхан шатны шүүхийн шийдвэр;
12.1.2.магадлал;
12.1.3.тогтоол;
12.1.4.шүүгчийн захирамж;
12.1.5.шийтгэвэр.

1.Хорих болон хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол;

2.Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр;

3.Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамж.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг шаардлагыг хуулийн төсөлд тусгасан нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тохиолдолд үндэслэлийг тухайн иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх, уг ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг нь тайлбарлах, хэнтэй боловч хүндэтгэлтэй харьцах, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх **үүрэгтэй.**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч бусдад эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцыг хууль бусаар ашиглах, зохих зовшөөрөлгүйгээр бусдад дамжуулахыг хориглоно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараахь үйлдэл, эс үйлдэхүйг хориглохоор тусгажээ.Үүнд:

1.хуульд заасан бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл хувийн ашиг сонирхлоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах;

2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаас зайлсхийх;

3.дур мэдэн, эсхүл хууль бусаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх;

4.хууль тогтоомжид зааснаас бусад үндэслэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах.

5.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусдад хувийн ашиг сонирхлын үүднээс дарамт шахалт үзүүлэх;

6.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа бусдад ялгавартай хандах, хууль бусаар давуу эрх олгох зэрэг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг иргэн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй. **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын**

алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлнэ. Хуульд заасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хуулиар эрх олгогдсон, эсхүл тухайн шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтан гүйцэтгэнэ.

Хуулийн төсөлд тусгагдсан шинэлэг заалт бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр, эсхүл хувийн өмчит мэргэжлийн хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох ба тухайн хуулийн этгээдэд тавигдах шаардлага, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, санхүүжүүлэх журмыг Монгол Улсын Засгийн газар батлахаар тусгагджээ.

Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник, тоног төхөөрөмжийг ашиглаж болно.

Цагдаагийн байгууллага, алба хаагч хуульд тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчаас хэрэгжүүлж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн этгээд, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн албаны үйл ажиллагаатай нь холбогдуулан түүний амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн тохиолдолд туслалцаа үзүүлж, харилцан мэдээлэл солилцохоор тусгагдсан байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой шинэлэг зохицуулалт хуулийн төсөлд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хориглох үйлдэл, эс үйлдэхүй
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа тоолох
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа хэтрүүлсний үр дагавар
5. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа
6. Шийдвэр гүйцэтгэгчийн даалгавар хүргүүлэх
7. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцгой харьяалал

8. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэх, ажлын хэсгээр гүйцэтгүүлэх

9. Гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэхийг хойшлуулах

10. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх

11. Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх

12. Үнэт цаас битүүмжлэх

13. Төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах

14. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлэх

15. Төлбөр төлөгч өөрийн хөрөнгөө худалдан борлуулах

16. Тэтгэлгийн зөрүүг нөхөн гаргуулах, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага зэрэг болно.

Үүнээс тоймлон авч үзвэл:

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяалалын талаар төслийн 24.1-т Шүүхийн шийдвэр, түүнийг үндэслэн олгосон гүйцэтгэх баримт бичиг нь энэ хуулийн 252.3-т заасан нэгжийн чиг үүрэгт хамаарах бол иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг уг нэгжийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ гэсэн зохицуулалт нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хурдан шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэн өгч байгаа юм.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэх, ажлын хэсгээр гүйцэтгэлүүлэх шинэлэг зохицуулалт нь төслийн 25.1-т Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цар хүрээ, хамрах нутаг дэвсгэрийг харгалзан гүйцэтгэх баримт бичгийн шаардлагытогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх зорилгоор хоёр, түүнээс дээш шийдвэр гүйцэтгэгчид иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахыг даалгаж болно. Шийдвэрийг улсын хэмжээнд ерөнхий шийдвэр гүйцэтгэгч, орон нутгийн хэмжээнд ахлах шийдвэр гүйцэтгэгч тус тус гаргах бөгөөд ажлын хэсгийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгч ахлана. Төслийн 25.3-т Нэг төлбөр төлөгчид холбогдуулан хөрөнгийн шинжтэй хэд хэдэн шаардлагыг гүйцэтгэх зорилгоор хэд хэдэн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн бол энэ хуулийн 25.2-т заасан шийдвэр гаргах журмын дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн нэг шийдвэр гүйцэтгэгчид даалгаж болно.

-Төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэлээр орсон томоохон зохицуулалтын нэг бол төлбөр төлөгч иргэний төлбөрийн хэмжээнээс хамааруулан хилийн хориг, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхдээ 50 сая төгрөгнөөс дээш төлбөртэй этгээдийн эрхийг түдгэлзүүлэхээр зохицуулсан байна. Энэ нь төлбөр төлөгч эрхийг хангах чиглэлээр орсон заалт юм. Шийдвэр

гүйцэтгэгч төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, эд хөрөнгийн эрэн сурвалжлах алба хаагчтай нэгж байхаар зохицуулж өгсөн нь олон талын ач холбогдолтой болж өгсөн байна. Энэ зохицуулалтаар төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлахдаа төслийн 57.1-т Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор шаардлагатай ажиллагааг гүйцэтгэнэ. 57.2.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч, түүний хөрөнгийг олж тогтоох бүхий л ажиллагааг явуулсан боловч төлбөр төлөгч, түүний хөрөнгийн байгаа газар тодорхойгүй хэвээр байгаа тохиолдолд тэдгээрийг эрэн сурвалжилж, олж тогтоох үүргийг энэ хуулийн 257.7-д заасан нэгжид даалгана, 57.3.Төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлахаар зарласан нь тэдгээрийг улсын хэмжээнд болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт эрэн сурвалжлах үндэслэл болно. 57.7.1-т төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжилж байгаа тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлах, 57.9.Шаардлагатай тохиолдолд төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэх, гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж энэ хуулийн 44.2-т заасан арга хэмжээг гүйцэтгэж болно зэргээр тусгагдсан байна.

-Хуулийн этгээдийн үнэт цаас, клирингийн дансыг битүүмжлэх /хуулийн этгээдийн валютын данс/, төлбөрийн үүргийг түдгэлзүүлэх зэрэг шинэ зохицуулалтыг оруулж өгсөн нь хуулийн этгээдтэй холбоотой ажиллагаа бүрэн биелэгдэх боломжийг нээж өгч байгаа юм.Төслийн 53.1.Төлбөр төлөгчийн өгсөн даалгаврын дагуу төлбөр төлөгчийн заасан этгээдэд бэлэн бусаар төлбөр төлөх, бусад гүйлгээг гүйцэтгэх үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд нь дансан дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх тухай шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авсан даруйд уг дансны зарлагын гүйлгээг хааж, дансны болон битүүмжлэгдсэн хөрөнгийн талаархи мэдээллийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлэх үүрэгтэй.53.2.Энэ хуулийн 53.1-д заасан дансны гүйлгээнд хязгаарлалт тогтоосон, дансыг битүүмжилсэн нь уг шийдвэрийг хүлээн авахаас өмнө төлбөр төлөгчөөс ирүүлсэн даалгаврын дагуу бусад этгээдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах зорилгоор төлбөр гүйцэтгэхэд саад болохгүй. 53.3.Энэ хуулийн 53.1-д заасан төлбөрийг гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд хөрөнгө

битүүмжлэх тухай шийдвэр хүлээн авсан хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд даруй мэдэгдэх үүрэгтэй зэргээр тусгагдсан байна.

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:

Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэргийн оролцогч, түүний эрх залгамжлагч биелүүлэх үүрэгтэй.Захиргааны байгууллагын шийдвэрийг энэ хууль болон Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

Захиргааны хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төрөл:

- Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон шийдвэр

- Захиргааны акт гаргахыг даалгасан, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэр

- Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасган тогтоосон шүүхийн шийдвэр

- Захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг гаргуулах хохирлын хэмжээг өөрчилж тогтоосон шүүхийн шийдвэр

- Захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага захиргааны хэргийн талаархи энэ хуулийн 6.3-т заасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй:

1. энэ хуулийн 6.3.1, 6.3.3, 6.3.4-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсоноос хойш 3 жил;

2. энэ хуулийн 6.3.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан.

Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 125.1-д заасан хугацааг хэтрүүлсэн нь тогтоогдвол хэтрүүлсэн хугацааг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.6-д заасан журмын дагуу сэргээх бөгөөд энэ тухай шийдвэр гарснаас хойш 3 сарын дотор гүйцэтгэх баримт бичиг олгуулахаар шүүхэд хандана.

Хариуцагч шүүхийн шийдвэр, түүнд үндэслэн олгосон гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхээс зайлсхийсэн хугацааг тооцохгүй. Гүйцэтгэх баримт

бичгийг нэхэмжлэгчид буцаасан, эсхүл захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд хугацааг энэ хуулийн 18.7-д заасны дагуу тоолно.

- Шүүгч шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх баримт бичгийн үндэслэл болох шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан бол түүнийг хянан шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарах хүртэл захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болно.

- Ахлах шийдвэр гүйцэтгэгч захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараахь үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлнэ:

- Нэхэмжлэгч-иргэн нас барсан, эсхүл нас барсан гэж зарлагдсан, сураггүй алга болсонд тооцогдсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, хариуцагч-хуулийн этгээд, нэхэмжлэгч-хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эрх залгамжлагч, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл

- Тухайн захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа тохиолдолд түүнийг шийдвэрлэх хүртэл

- Хариуцагч-хуулийн этгээдийг татан буулгах ажиллагааг эхлүүлсэн;

- Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шүүхэд эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргасан гомдлыг шүүх, эсхүл дээд шатны албан тушаалтан үндэслэлтэй гэж үзэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн бол гомдлыг хянан шийдвэрлэх хүртэл.

- Бусад үндэслэлээр захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно.

Дараахь тохиолдолд шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудсыг шууд олгоно.

- Урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай

- Ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн, шилжүүлсний нөхөн олговор олгуулах тухай

- Захиргааны актыг түдгэлзүүлэх тухай

- Шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч иргэн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учрахаар бол түүний хүсэлтээр

- Хуульд заасан бусад тохиолдол

Захиргааны хэргийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага

- Захиргааны байгууллага, түүнийг удирдах албан тушаалтан хууль тогтоомжийн дагуу олгогдсон бүрэн эрх, чиг үүрэгт нь хамаарах асуудлаар шүүхийн шийдвэрт заасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актыг гаргах, эсхүл шүүхийн шийдвэр, мэдэгдэлд заасан үүргийг тогтоосон хугацаанд, зохих ёсоор биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйг шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэнд тооцно.

- Шүүхийн шийдвэрт заасан үүргийг биелүүлэх, шүүхийн шийдвэрт заасан захиргааны актыг гаргах бүрэн эрх, чиг үүрэгт нь хамаарах албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх тухай үүрэг, даалгавар өгсөн, эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий албан тушаалтны шүүхийн шийдвэр тогтоосон хугацаанд, бүрэн гүйцэт, зохих ёсоор биелэгдэх боломжгүй, эсхүл шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг санаатайгаар удаашруулах нөхцөл байдал үүсгэсэн үйлдэл, эс үйлдэхүйг шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд саад учруулсанд тооцно.

- Захиргааны байгууллага, албан тушаалтан захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлэх үйлдэл гүйцэтгэсэн боловч захиргааны хэргийн шүүхээс хууль бус болохыг тогтоосон захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актыг дахин гаргах зорилгоор өөрийн бүрэн эрхэд хамаарах эрх зүйн акт, албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг өөрчлөх замаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт харшилсан шийдвэр гаргаж нэхэмжлэгчийн эрх ашгийг дахин зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг шүүхийн шийдвэрийг дүр эсгэн биелүүлсэнд тооцно.

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох

- Гүйцэтгэх баримт бичиг, эсхүл түүний үндэслэл болсон шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шүүх, бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан;

- Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсан бөгөөд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасан;

- Хариуцагч гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг бүрэн биелүүлсэн;

-Хариуцагч-хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан үед түүний эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй

- Хариуцагч-хуулийн этгээдэд, хариуцагч-албан тушаалтан гүйцэтгэх хуудаст заасан шаардлагыг биелүүлэх боломжгүй болсон нь шүүхээр тогтоогдсон

- Нэхэмжлэгч-иргэн нас барсан, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон;

- Нэхэмжлэгч-хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан үед түүний эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжээгүй зэрэг тохиолдлыг тусгасан байна.

Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа:

Гэмт хэрэг, зөрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог өнөөгийн байдлаар авч үзвэл эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэж ерөнхийд нь ангилж гэмт хэрэгт ял оногдуулж, зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэж байна.

Одоо бидний хэрэглэж байгаа онолын болон хуулийн тодорхойлолт, салбарын эрдэмтэн судлаачдын байр суурийг үзвэл гэмт хэрэг, зөрчлийг өөр өөр салбарт хамааруулан авч үзэж, түүнд хүлээлгэх хариуцлагыг “захиргааны”, “эрүүгийн” гэсэн нэр томъёогоор ялган заагласан. Гэтэл ингэж ялгаж заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь хоорондоо ямар ч уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн хэт ач холбогдол өгөн үнэлж, ял шийтгэх нэг бол захиргааны хариуцлага хэмээн үл ойшоон үзэж багахан хэмжээгээр торгон, аль нэг хуулиар хориглоод өнгөрдөг байснаас үүдэн Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг хамгаалах бодлого орхигдсон. Иймээс хууль тогтоогчид Зөрчлийн хуулийг батлан гаргасан ба уг хуульд зөрчил гэх үйлдлийг тодорхойлохдоо хуулийн 2 дугаар бүлгийн 2.1 дүгээр зүйлд

1.Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн ба энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.

2.Хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой ч түүнийг хангах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэн гэж үзнэ.

3.Хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан шийтгэл оногдуулна гэж хуульчилсан байна.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн үйлдэлд оногдуулах шийтгэлийн үндэслэлийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээг харгалзан зөрчлийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулахаар хуульчилсан.

Зөрчлийн тухай хуульд зөрчлийн шийтгэлийг тусгахдаа:

1. торгох шийтгэл[5];

---

[5] Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйл.Торгох шийтгэл

1.Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.

2.Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

2.эрх хасах шийтгэл[6].

Эрх хасах шийтгэлийг торгох шийтгэлд нэмэгдэл чанартай оногдуулна гэж заасан байна.

Уг хуульд торгох, эрх хасах шийтгэлийг оногдуулах эрх зүйн зохицуулалтыг шинээр оруулж ирж дараах байдлаар хуульчилсан байна.

Зөрчлийн тухай хуулийн нэг бүлэг заалт нь албадлагын арга хэмжээ бөгөөд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулхаас гадна хуульд заасан зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч хуульд тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэж, хөрөнгө орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Зөрчлийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хэмээн хуулчилагдаж тус Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар бүлэг болон хуульчилагдсан.

Зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээний төрөлд:

1.Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх[7]

2.Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах[8]

3.Хохирол, нөхөн төлбөр гаргуулах[9]

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг нэгж нь хоёр мянган төгрөгтэй тэнцүү байна.

4.Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох шийтгэлийг хоёр жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно.

5.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулна.

6.Хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээнд энэ зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй.

[6] Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйл. Эрх хасах шийтгэл

1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ.

2.Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно.

[7] Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйл. Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх

1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаас гадна зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураана.

2.Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

[8] Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйл. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах

1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хураана.

2.Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулан хураах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

[9] Зөрчлийн тухай хуулийн 4.3 дугаар зүйл. Хохирол, нөхөн төлбөр гаргуулах

4.Албадан эмчлэх[10]

5.Нийтэд тустай ажил хийлгэх[11]

Шийтгүүлсэн этгээд зөрчлийн хэргийн талаархи хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хууль болон шийтгэл, албадлагын арга хэмжээ оногдуулах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй тохиолдолд даруй биелүүлэх үүрэгтэй.Зөрчлийн хэргийн талаархи шийдвэрийг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, хэрэв шүүх гаргасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ. Зөрчлийн хэргийн талаархи шийдвэрт гомдол гаргаагүй, эсхүл гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосон, эсхүл хянан үзээгүй болон хуульд заасан бусад үндэслэлээр анх гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд тухайн шийдвэрийг анх гаргасан байгууллага, албан тушаалтан шийдвэрийг гүйцэтгэнэ. Шийтгүүлсэн этгээдэд холбогдуулан гарсан хэд хэдэн шийдвэрийг тус тусад нь гүйцэтгэнэ.

Зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны дараалал, иргэн хуулийн этгээдээс төлбөр гаргуулах, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай заалтыг зохицуулж өгсөн ба тус ажиллагаа нь ШШГТХ-ийн шинэчилсэн төслийн:

2 дугаар хэсэг: Иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

4 дүгээр бүлэг: Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах

5 дугаар бүлэг: Хөрөнгө албадан худалдан борлуулах,

6 дугаар бүлэг:Төлбөр төлөгчийн хөрөнгөөс суутгал хийх, төлбөрийг төлбөр авагчид шилжүүлэх,

7 дугаар бүлэг:Төлбөр төлөгч-иргэнээс төлбөр гаргуулах.

8 дугаар бүлэг:Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс төлбөр гаргуулах гэж заасаны дагуу хуульд

1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж улсын төсөвт төвлөрүүлнэ.

[10] Зөрчлийн тухай хуулийн 4.4 дүгээр зүйл. Албадан эмчлэх

1.Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх тухайн хүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно.

2.Албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

[11] Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх

1.Торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн нийтэд тустай ажил цалин хөлсгүй хийлгэхээр албадлагын арга хэмжээ хэрэглэж, торгох шийтгэлийг биелүүлэх хугацааг шинэчлэн тогтоож болно.

2.Торгох шийтгэлийг биелүүлсэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээнээс чөлөөлөгдөнө.

3.Нийтэд тустай ажлыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт хориос наян цагаар тогтооно.

4.Жирэмсэн эмэгтэй, ходолмөрнийн чадвараа бүрэн алдсан, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд нийтэд тустай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй.

тогтоосон хуулийн заалт, журмыг нэг мөр удирдлага болгон хэрэгжүүлж ажиллана.Тухайлбал:

Торгох шийтгэлийг гүйцэтгэх

Шийтгүүлсэн этгээд хууль, эсхүл шийдвэрт өөрөөр заагаагүй бол шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор, хэрэв хуульд зааснаар торгуулийг хэсэгчлэн төлж барагдуулахаар тогтоосон бол уг тогтоосон хугацаанд торгуулийг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй. Арван найман насанд хүрээгүй этгээдэд оногдуулсан торгох шийтгэлийг Иргэний хуулийн 503.5, 503.6-д заасны дагуу түүний эцэг, эх, харгалзан дэмжигч төлж барагдуулах үүрэгтэй.

Нийтэд тустай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг гүйцэтгэх

Торгох шийтгэл хүлээсэн этгээд торгуулийг энэ хуулийн 147.1-д заасан хугацаанд биелүүлээгүй бол уг хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор шийтгэл оногдуулсан албан тушаалтан тухайн этгээдэд нийтэд тустай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ авах үндэслэл бүхий саналаа шүүхэд гаргана. Шүүх саналыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нийтэд тусгай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж, гүйцэтгэх баримт бичгийн хамт албадан гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлж байхаар хуулийн төсөлд тусгасан байна.



Б.ЭРДЭНЭ-ОЧИР
ХСИС-ийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Шийдвэр
гүйцэтгэлийн
тэнхимийн ахлах
багш, хошууч

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭЭС ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Түлхүүр үгс: Ялтны хөдөлмөр, гэм хор, хохирол нөхөн төлөлт, эрх зүйн зохицуулалт

Нийгмийн харилцаан дахь хөдөлмөрийн нэгэн өвөрмөц хэлбэр бол ялтны хөдөлмөр юм. Ялтны хөдөлмөр нь Монгол Улсын хөдөлмөрийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар зохицуулагддаг. Тэдний хөдөлмөрийн үндсэн асуудлыг Засгийн газраас тогтоосон үйлдвэрийн чиглэлийн дагуу хорих анги, ялтан нэг бүрийг хөдөлмөрөөр хангах, тэдний хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, тохирсон цалин хөлс олгох, түүнчлэн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга техникийн болон үйлдвэрлэлийн соёл, ариун цэврийн зэрэг олон асуудлыг цогцоор хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж буй ялтнуудын 36 орчим хувь нь бусдад гэм хор учруулсны улмаас төлбөр төлөхөөр шүүхээр шийдвэрлэгдсэн байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь "Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийтгэх тогтоолын хөрөнгө гаргуулах заалт, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх" баримт бичгийг үндэслэн, гэмт хэргийн улмаас хохирсон нь шүүхээр тогтоогдсон иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомжид зааснаар төлбөр гаргуулахаар хуульд заасан ажиллагааг явуулна. Эдгээр ажиллагаанд:

- Төлбөр төлөгч буюу ялтны эд хөрөнгө байгаа талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах; түүний мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах
- Ялтны бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах
- Хуульд заасан бусад үйл ажиллагаа тус тус багтана.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг

барагдуулах, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй гүйцэтгэх үүднээс хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах улмаар хөдөлмөр хөлснөөс хохирогчийн хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд “Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, төлбөр барагдуулалтанд хяналт тавин ажиллах хөтөлбөрийг”-ийг ШШГЕГ-ын даргын 2008 оны А/102 тоот тушаалаар батлан гаргаж, хэрэгжилтийг харьяа нэгжүүд болон ял эдэлж буй ялтнуудад сурталчлах ажлыг тухайн хорих ангиуд дээр зохион байгуулан ажиллаж байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- Төлбөртэй ялтанг хугацааны өмнө тэнсэн суллахгүй байх
- Ялтныг ажлын байраар хангаж, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдэнд мэргэжил олгох
- Ялтны ахуй хангамж, амьдрах орчин сайжирч, тодорхой орлоготой болгох
- Ялтны төлбөрийн мөнгийг хохирогчдод олгох ажиллагааг шуурхай олгох талаар бодит үр дүнг гаргахаар тодорхой асуудлыг дэвшүүлжээ.

Хорих ангид ял эдэлж байгаа ялтны хувьд удаан хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлдэг бөгөөд тэдгээр нь хувьд ногдох хөрөнгө, орлогогүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалттай биелэдэггүй.

Хорих ял эдэлж буй ялтны биелүүлбэл зохих 14,1 тэрбум төгрөгийн 1749 гүйцэтгэх баримт бичгээс 0,7 тэрбум төгрөгийн 477 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 13,4 тэрбум төгрөгийн 1212 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн 28,2 хувийг би?лүүлсэн байна. Энэ нь 2015 оны мөн үеэс 612 гүйцэтгэх баримт бичгээр буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны 10 сарын байдлаар ШШГЕГ-ын харьяа хорих анги, албадын үйлдвэрлэлд 569, туслах аж ахуйд 1800, аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр 356 ялтан тус тус улирлын шинж чанартай болон байнгын ажлын байраар хангагдан хөдөлмөр эрхэлж байна. 2662 ялтанд 290,8 сая /өссөн дүнгээр/ төгрөгийн цалин олгогдож, 50.1 сая төгрөгийг шүүхийн төлбөрт өөрийн цалингаас шилжүүлсэн байна.[1]

[1] ШШГЕГ-ын Мониторинг, статистик мэдээлэл сэтгүүл



Ялтнаас учруулсан хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хохирлын хэмжээ нь хадгаламж зээлийн хоршооны хэргийн хохирлыг оролцуулан тооцоход 52.8 тэрбум төгрөгөөр өсчээ./эх сурвалж/

Нийт ял шийтгүүлсэн ялтнаас учруулсан хохирлын 54.9 тэрбум төгрөгийн хохирол нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирол эзэлж байна. Өөрөөр хэлбэл нийт гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 93 хувийг залилангийн гэмт хэрэг, 7 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь залилангийн гэмт хэрэг сүүлийн үед ихээр үйлдэгдэх болсонтой шууд холбоотой.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд хохирогчийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгоогүйгээс гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа хангалттай хийгддэггүй.

Зөвхөн гэмт хэрэг, түүнд холбогдогчийг илрүүлэх чиглэл рүү түлхүү анхаарснаас гэм буруутай этгээд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх, худалдан борлуулах, улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шатанд төлбөр төлөгчийн хувьд ногдох ямар нэгэн эд хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй болсон байдаг.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүнд ногдох эд хөрөнгөөс төлүүлж, үлдэгдэл төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж

шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлж байх”[2]-аар заасан.

Гэвч практикт гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад ял эдлэгсдийн ихэнх хувь нь төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие байдаг. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ялтныг ял эдлэх хугацаанд нь хөдөлмөрт татан оролцуулж, гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагааг тухайн хорих ангийн онцлогт нь тохируулан зохион байгуулж байгаа боловч ихэвчлэн хохирлын хэмжээ их байдгаас шалтгаалан хангалтгүй байдаг тул энэ төрлийн гүйцэтгэлийн ажиллагаанд төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Тус байгууллага нь уламжлалт үйлдвэрлэлийг сэргээх, шинээр үйлдвэр байгуулах замаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад ял эдэлж байгаа ялтнуудыг барилга, барилгын материалын үйлдвэрлэл, шохой болон боржин чулуу олборлолт, мал аж ахуй, газар тариалан, мод, модон эдлэл, оёдол, уран дархан, бэлэг дурсгалын зүйл урлах гэх мэт ажлуудыг хийлгэх болсноор дээрх чиглэлээр ажлын байраар хангасны улмаас хохирол барагдуулах ажиллагаанд тодорхой ахиц гарсан боловч хохирлын хэмжээ үлэмж их учир даацтай нөлөөлж чадахгүй байна.

Хуульд хорих ангид ял эдэлж буй ялтнаас гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо төлөөгүй тохиолдолд ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах саналыг шүүхэд оруулахгүй байх[3] талаарх эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан нь өмнөх хуулиудад байгаагүй дэвшилттэй зохицуулалт болсон төдийгүй ялтнаас хохирол барагдуулахад онцгой хөшүүрэг болсон юм.

Уг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ялтнаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал өмнөх онуудаас нэмэгдэж байгаа хэдий боловч хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүссэн гэм хорын төлбөр биелэгдэхгүй удааширч, иргэд хохирсоор байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд **“гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн”** тохиолдолд

[2] (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 66.2)

[3] (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002, 126.1)

ялтанд тодорхой хэмжээний шагналын хоног олгох, ялыг хасах, ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах саналыг гаргаж шүүхээр шийдвэрлүүлж байхаар нэмэлт өөрчлөлт оруулах өөрөөр хэлбэл ялтныг аль болох хөдөлмөр хийх хохирлоо төлөх санаа сэдлийг бий болгох хөшүүрэг механизмыг бий болгох ялтнаас ялын хугацааг хүлээж зүгээр сууснаас өөрийн хүч чадлыг дайчлан ажиллаж хөдөлмөрлөснөөр өөрийн гэм бурууг хүч хөдөлмөрөөрөө цайруулах, нөгөө талаас ялтан өөрийн дансанд хуримтлал бий болгох эдийн засгийн сонирхол төрүүлэх түүгээр дамжуулж ялтныг хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Ялтны хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс олголт зэргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 120.1-121 дүгээр зүйл, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-аар зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн (2002) 121 дүгээр зүйлийн 121.1-т “Ялтанд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чанарт тохирсон хөлс олгоно.” гэж заажээ.

121 дүгээр зүйлийн 121.3. дахь хэсэгт хорих анги ялтныг өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуулсны болон энэ хуулийн 121.2.-т заасны дагуу шилжиж ирсэн цалин хөлснөөс бүх төрлийн төлбөр суутгал хийж үлдэх хэсгийг ялтны нэрийн дансанд төвлөрүүлнэ гэж заасан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-ын 3.1-д зааснаар ялтныг дотоодын үйлдвэр болон иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулахдаа хүчин төгөлдөр буй хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан ажиллуулж байна. Ялтнууд илүү цагаар ажилласан бол цалин хөлснөөс тооцож нэмэгдэл хөлс олгохоор тусгажээ.

Ялтныг дотоодын үйлдвэр болон иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажиллуулахдаа хүчин төгөлдөр хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан цалин хөлс олгон ажиллуулж байгаа нь ялтныг албадан хөдөлмөр эрхлүүлж буй ойлголтод хамааруулж үзэхгүй байх боломжтой юм.

Гэсэн ч бодит байдал дээр ялтнуудын 36-59 хувь нь тухайн гүйцэтгэсэн ажилдаа ямар нэгэн хөлс аваагүй гэсэн судалгааны дүн гарсан байна. (сайн дурын үндсэн дээр болон заавал хийлгэх ажил аль аль нь багтсан) Хөлс авсан ялтнуудын

хувьд цахилгаан, ус, дулааны төлбөр, цэвэрлэгээ, замын зардал болон сургалт, түүнчлэн шүүхээс ногдуулсан хохирлын нөхөн төлбөр зэргийг суутгуулах нь түгээмэл байна. Нэмж тэмдэглэхэд, судалгаанд оролцогчдын хэн нь ч илүү цагийн хөлс аваагүй байна.[4]

Цаашид хорих ял эдлэгсдийн нийгэм, иргэдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэхэд дараах асуудлуудыг дэвшүүлж байна.

1. Гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлын тодорхой хэсгийг буюу бүрэн төрөөс эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

2. Хохирогчдын хохирлыг нэн даруй цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс төрийн зүгээс “Хохирол барагдуулах төрийн сан” байгуулах, тухайн сангийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /Гэмт хэрэг зөрчилд оногдуулсан торгууль, шийтгэвэр, улсын орлогод оруулахаар хураагдсан эд хөрөнгийг борлуулсны үнэ зэргийг хохирол барагдуулах төрийн санд төвлөрүүлж, гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн хохирлыг барагдуулахад зарцуулах/;

3. Ялтны ажлын байр шинээр бий болгох, тэднийг байнгын ажилтай байлгаж, түүний ажлын хөлснөөс хохирлыг барагдуулах санд шилжүүлэх ялтны нэрийн дансанд хуримтлал бий болгох, ялтныг мэргэшүүлж суллагдахад нь бэлтгэж нийгэмшүүлэх ажлыг зөв зохион байгуулах;

4. Гэмт хэргийн улмаас учрах хохирлын эрсдлийн даатгалын тухай ойлголт, үүргийн эрх зүйн тухай ойлголтыг эрүүгийн эрх зүйд авч хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлах;

5. Ялтны хөдөлмөрийг зохион байгуулж байсан уламжлалыг харгалзан,орчин үеийн менежментээр дараах салбаруудад ЗГ-н оролцоотой ажлын байрыг бий болгох.

[4] Хүний эрхийн үндэсний комисс, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага. (2016). Монгол Улс дахь ялтны хөдөлмөр эрхлэлтийн байдал: практик судалгаа.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн ахлах дэслэгч

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хураангуй: Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг төрөл болох үл хөдлөх хөрөнгөөс төлбөр гаргуулах түүний дундаас газартай холбоотойгоор эзэмших, ашиглах харилцааны талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрх зүйн актад хэрхэн тусгагдсан талаар харьцуулан судалсан болно.

Түлхүүр үг: Газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалтын талаар

Аливаа баялагийн анхны эх булаг болох газар нь байгалийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүн төрөлхтний хөгжил дэвшилд чухал үүрэгтэй юм. Зах зээлийн харилцаанд шилжсэн өнөө үед газрын асуудал улам ч их анхаарал татах болов. Газрын мөн чанар, төлөв байдал, үндсэн үүрэг, ач холбогдлыг шинжлэх ухааны үүднээс танин мэдэх нь нийгэм эдийн засаг, оюун санааны амьдрал эрх зүйн хувьд төдийгүй хүрээлэн буй орчныг хамгаалах экологийн тэнцлийг хангахад үлэмж ач холбогдолтой юм. Хүн газартай зөв харьцах нь түүний ашиглалт, хамгаалалтыг сайжруулах ингэснээр нийгмийн хөгжил дэвшилд ихээхэн нөлөө үзүүлдэг. Газрын асуудал үүгээр хязгаарлагдахгүй. Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй салшгүй холбоотой. Иргэдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах нь хүн байгаль хоёрыг ойртуулж байгалаа гэсэн өөриймсөг сэтгэлийг төлөвшүүлэх хүний экологийн эрхийг хангах чухал нөхцөл болно. Газрын эрх зүйн зохицуулах зүйл нь газрын харилцаа болно. Энэ харилцаа нь газар өмчлөх, эзэмших, ашиглах хамгааалах талаар төр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүснэ. Газрын харилцаа нь экологийн харилцааны үндсэн төрөл бөгөөд мөн нийгмийн харилцааны шинжтэй байна. Газрын харилцаа агуулга, шинж чанараасаа хамаарч тодорхой төрлүүдэд хуваагдана.

Үүнд: Газар өмчлөлийн харилцаа нь төрөөс газар өмчлөх талаар мөн тус улсын иргэн газар өмчлөхөд үүснэ.

1. Газар эзэмшлийн харилцаа энэ нь төр төдийгүй бусад байгууллага, иргэдээс газар эзэмших явцад үүснэ.

2. Газар ашиглалтын

харилцаа нь эдгээр субьектээс газар эдлэх явцад үүснэ.

3. Газрыг хамгаалах талаарх харилцаа нь газрын бүрэн байдлыг хангаж эвдрэл гэмтэлгүй байлгах явцад үүснэ.

4. Газрыг эрхлэн удирдах талаарх харилцаа нь газрын талаар төрөөс нэгдмэл бодлогын үндсэн дээр түүний зохистой байдлыг хангах тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах явцад үүснэ. Эдгээр нь газрын харилцааны үндсэн төрөл бөгөөд түүнээс салбарласан бусад тодорхой төрлийн харилцаа үүсч болно.[1]

Газар өмчлөх эрх тодорхой нөхцөлд тогтоосон журмаар үүсч, дуусгавар болно. Энэ нь түүхэн нөхцөл байдалтай холбоотой бөгөөд хууль зүйн зохих заалтын дагуу хэрэгжиж үндэсний ба олон улсын эрх зүйн зохицуулалтыг шаарддаг. Тухайн улс өөрийн нутаг дэвсгэр хүн амтай албан ёсны төр засгийн байгууллагатай байж олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөнөөр нутаг дэвсгэрийн доторх газраа өмчлөх, гадаад нөхцөл бүрдэнэ. Харин иргэдэдээ газар өмчлүүлэх нь тухайн улсын бүрэн эрхийн асуудал бөгөөд ямар нэг гадаааад нөхцөл шууд шаардахгүй. Аль ч тохиолдолд төрийн болон иргэний газар өмчлөх эрх нь хууль зүйн практикийн үндсэн дээр үүсч бий болно. Энэ нь Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд газар өмчлөх эрхийг төр буюу иргэнд олгосноор хэрэгжих үндэслэлтэй болно. Улс орны дотоодод төр засаг солигдоход газар өмчлөх эрх залгамжлагдах чанартай байна. Харин газар өмчлөх эрхээ хэрхэн яаж хэрэгжүүлэх нь тухайн төр засгийн эрх мэдлийн асуудал юм. Газар өмчлөх эрхэд төрийн бодол, эрх зүйн зохицуулалтаар өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Энэ нь өмчлөх эрхийг хэрэгжүүлэх хүрээ хязгаар, хэмжээ арга хэлбэрийг хамруулбал зүйтэй. Төр иргэдийн газар өмчлөх эрхийг тогтоон хэрэгжүүлэх онцлоготой. Тэгэхдээ тухайн улсын хөгжил нийгэм эдийн засгийн байдал үндэсний онцлог ашиг сонирхол зэргийг харгалзан үздэг. Газар өмчлөх нь төр иргэний хүсэл эрмэлзлээр эрх зүйн зохицуулах журмаар хэрэгждэг. Тухайн улс оршин тогтнож буй нөхцөлд төрийн газар өмчлөх эрх бүрэн мөсөн дуусгавар болгохгүй. Харин тодорхой хүчин зүйлсийн улмаас түр зогсох, өөрчлөлт орох явдал гарч болно. Газар өмчлөх эрхийг хууль ёсны ба хууль ёсны бус гэж ангилдаг. Улсуудын практикт эзлэн түрэмгийлэх бодлогоо хэрэгжүүснээр аль нэг улсын төрийн газар өмчлөх эрхийг дуусгавар болгож хүчирхийлэл явуулсан улсын төрийн газар өмчлөх эрхийг тогтоож

[1] Газрын эрх зүй, Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул УБ., 2015 он 384 дэх тал,

буй явдал ч гардаг. Энэ нь хууль ёсны бус газар өмчлөх эрх юм. Тэгвэл тухайн улсын өөрийн нь төрөөс эрх зүйнхээ дагуу газар өмчлөх нь хууль ёсных байна. Аливаа улсын төр өөрийнхөө газар өмчлөх эрхийг шууд дуусгавар болгодоггүй. Харин иргэний газар өмчлөх эрхийг зохих журмаар дуусгавар болгож болдог. Нийгмийн хувьсгалаар өмнөх төрийг халснаар түүний тухайд газар өмчлөх эрхийг нь дуусгавар болгож дараах шинэ төрийн газар өмчлөх эрх залгамж чанартайгаар бий болно. Монгол улсын төрийн байгууламжийн хувьд холбооны биш улс учраас өмчлөх эрх үүсгэх дуусгавар болох нь нилээд тогтвортой шинжтэй нарийн процедур ажиллагаа багатай юм.

Иргэний газар өмчлөх эрх, дуусгавар болох үндэслэл нь:

1. Өмчийн газраа бусад иргэний өмчлөлд шилжүүлснээр
2. Газар өмчлөх эрхээсээ татгалзсанаар
3. Газар өмчлөгч иргэн Монгол улсын харьяатаас гарснаар
4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр

Газар эзэмших эрхийн нэг гол субьект төр юм. Төр нь энэ эрхээ өмчлөх эрхээсээ уламжлан хэрэгжүүлдэг.

Газар эзэмших эрхгүйгээр төрийн газар емчлөх эрх бүрэн хэрэгжих нь учир дутагдалтай. Төр газар эзэмших эрхээ өөрийн байгууллагуудаар дамжуулж тэдэнд газар эзэмшүүлэх байдлаар хэрэгжүүлдэг. Ийнхүү төр түүний байгууллагууд газар эзэмших нь түүний чиг үүргээ биелүүлэх үндсэн нөхцөл болно. Эдгээр байгууллагад газар нь оршин тогтнох, үйл ажиллагаагаа явуулах түүний экологийн эрхийг хангах, төрийн сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд зайлшгүй ач холбогдолтой төр түүний байгууллагуудын газрын талаарх бүрэн эрх, Монгол улсын үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн болон хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад тусгалаа олсон байна. Мөн газрын тухай хуульд байгууллага бүрээр нь тодорхой заажээ. Төр түүний байгууллагуудын газрын талаарх эрх зүйн байдал янз бүр байна. Жишээ нь: төрийн бүх байгууллага газрыг өөрийн оршин тогтнох үйл ажиллагаагаа явуулах бааз суурь болон эзэмшихийн зэрэгцээ Улсын их хурал нь тус улсын газрын нэгдсэн бодлогыг тодорхойлох, Засгийн газар түүнийг хэрэгжүүлэх, Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг дарга нутаг дэвсгэртээ газрын харилцааг зохицуулах бүрэн эрхтэй. Төр өөрөө газар эзэмшихээс гадна эрх бүхий байгууллагууд нь бусдад газар эзэмшүүлэх эрхтэй байна. Төр газар эзэмших субьектийнхээ эрхийг

өөрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн эдлүүлэх замаар хэрэгжүүлнэ. Газар эзэмших эрхийн нэг чухал субьект нь иргэн мөн. Иргэн гэдэг нь нэгдмэл ойлголт бөгөөд тус улсын иргэн, гадаад улсын иргэн гэсэн тусгай ойлголтуудаас бүрдэнэ. Юуны өмнө Монгол улсын иргэн нь газрын хуульд зааснаар тус улсын газрыг эзэмших эрхтэй. Тэгэхдээ газар эзэмших эрхийн чадамжтай байх ёстой. /Газрын тухай хуульд 2002/ он зааснаар Газрыг энэ хуулийн дагуу тодорхой зориулалт, хугацаа болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ. Эрхийн гэрчилгээ нь иргэний, гэр бүлийн хамтын хэрэгцээний төрийн байгууллагын, аж ахуйн нэгж байгууллагуудын гэсэн үндсэн гурван төрөлтэй байна.

Иргэн газрыг дангаар гэр бүлээр болон хамтран ашиглаж болно. Иргэн өөрөө газар эзэмшихээс гадна энэ эрхээ бусдад ашиглуулж болно. Гагцхүү энэ тохиолдлод эрх бүхий төрийн байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Иргэн газрыг өөрийн амьдрах аж төрөх ахуйн нөхцөлөө сайжруулах зорилгоор эзэмшинэ. Үүний тулд гэр, орон сууц барих, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тарих зэрэг тодорхой зориулалтаар эзэмшинэ. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар газар ашиглаж болно. Тэгэхдээ энэ нь Монгол улсад байнга оршин суугаа /183 хоногоос дээш хугацаагаар /хүнд хамаарна. Аж ахуйн нэгж байгууллага газар эзэмших эрхийн субьект болно. Эдгээр нь үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагаа явуулах зорилгоор газар эзэмшинэ. Үүний тулд дүрэмдээ заасан үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааныхаа чиглэлээс хамаарч тодорхой зориулалтаар эзэмшинэ. Аж ахуйн нэгж, байгууллага бүхэлдээ газар эзэмших эрхийг субьект болох бөгөөд түүний бүтцийн нэгжүүд тус бүрдээ субьектийн эрх эдлэхгүй. Гадаад улсын болон Олон улсын байгууллага, хуулийн этгээд газар эзэмших эрхийн субьект болно. Эдгээр нь үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлд нийцүүлэн Монгол улсын Үндсэн хууль, газрын хуульд заасан нөхцөл журам, болзлын дагуу газар эзэмшинэ.

Тусгай хэрэгцээний газрын хэрэгцээний агуулга нь уг газрын талаар субьектын эдлэх эрх, биелүүлэх үүргээр илэрнэ. Энэ төрлийн газрын эрх зүйн харилцаанд оролцогчид эрх зүйн байдлаас хамаарч эрх, үүрэг нь харилцаа адилгүй байна. Тусгай хэрэгцээний харилцааны газрын эрх, эрх зүйн харилцаа агуулга, шинж чанарын хувьд тодорхой төрөлд хуваагдана. Тухайлбал түүнийг дотор нь өмчлөл, эзэмшил, ашиглалт, нөхөн сэргээлт,

хамгаалалтын талаарх харилцаа гэж авч үзэж болно. Тусгай хэрэгцээний газрын өмчлөх эрхийг зөвхөн төр эдэлнэ. Улсын Их Хурал, Засгийн газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тусгай хэрэгцээнд газар авах асуудлыг шийдвэрлэж байгаа нь түүнийг захиран зарцуулж буй хэрэг мөн. Тусгай хэрэгцээний газрыг эзэмших, ашиглах эрхийг улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа, хилийн болон аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах байгууллагууд тусгай хэрэгцээний газрыг эзэмших, ашиглах эрхтэй. Мөн аймаг дундын оторын бэлчээр, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, ШУ, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин , цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалт болон зориулалтаар энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, газрын тосны гэрээт талбайт хайгуулын ажил явуулж буй компани, чөлөөт бүсийн захирагч, тусгай хэрэгцээний газрыг эзэмших, ашиглах эрхтэй. Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь ямар ч байгууллага байлаа ч гэсэн тусгай хэрэгцээний газрыг нөхөн сэргээх хамгаалах арга хэмжээ авч түүний бүрэн байдлыг хангах үүрэгтэй. Тусгай хэрэгцээний газрын эрх зүйн гол агуулга нь уг газрыг гагцхүү зориулалтын дагуу эзэмшин ашиглах явдал юм. Зориулалтыг өөрчлөх, талбай, хэмжээ тогтоох, өөр субьектэд шилжүүлэх, буцааж авах зэргийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь тусгай хэрэгцээний талаар газрын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Иргэн аж ахуйн нэгж байгууллага нь аймгуудын дунд мал оторлох, улсын сангийг хадлан хадах зориулалтаар зохион байгуулалттай гэрээ хийсний үндсэн дээр тусгай хэрэгцээний газрыг тодорхой хугацаанд ашиглаж болно. Харин энэ нь ямар нэг өөр зориулалттай байж болохгүй. Гэрээнд нэмэлт эрх үүргийг зааж болох боловч энэ нь тусгай хэрэгцээний газрыг өөрчлөхөд хүргэх ёстой. Хэрэв тэгвэл тусгай хэрэгцээний газрын эрх зүйн агуулга алдагдахад хүргэнэ. Иймд гагцхүү зориулалтын нөхцөлд тусгай хэрэгцээний газрын эрх зүйн агуулга зохистой хэрэгжиж чадна. Тэгэхдээ эрхээ зөрчихгүйгээр зохистой эдэлж байж үүргээ биелүүлэх боломжтой болно. Тусгай хэрэгцээний газрын эрх зүйн агуулга нь уг газрыг тодорхой нэг чиглэлийн бус янз бүрийн байгууллага болон дотоод гадаадын болон Олон улсын байгууллага эзэмшин ашиглаж байдгаас эрх үүрэг нь харилцан адилгүй хэрэгжиж байдагт орших бөгөөд тэгэхдээ хуульд заасан тусгай хэрэгцээ гэдэг ерөнхий ангиллын хүрээнээс хальж болохгүй юм.

Иргэний болон газрын хууль тогтоомж зөрчиснөөс газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрх хууль ёсны ашиг сонирхолыг хөндөж газарт хохирол учруулбал түүнийг нөхөн төлүүлэхэд иргэний эрх зүйн хариуцлага чиглэгдэнэ. Газрын харилцааг Иргэний эрх зүйгээр хамгаалах нь газрыг төрийн болон иргэний өмчлөл, эзэмшлийн зүйл гэж үзэж субьектийн өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бататгах түүнийг хууль бус үйлдлээс хамгаалах зорилготой. Үүний тулд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг зөрчиж байгуулсан аливаа гэрээ, хэлцлийг хүчингүй болгох эрхээ хэрэгжүүлэхэд саад болж буй ажилллагааг зогсоох, зөрчлийг арилгах үүргийг буруутай талд оногдуулах, хугацаа зааж урьдчилан сануулга өгөх, зөрчилөө арилгаагүй бол газрыг хурааж авах, зориулалтын дагуу ашиглаагүй бол газрыг эргүүлж болох боломжгой бол газарт учируулсан материалын хохирлыг бодит байдлаар төлүүлэх, тийм боломжгүй бол зохих журмын дагуу мөнгөөр үнэлж арилгуулах, торгууль хүлээлгэх зэрэг арга хэрэгслийг шүүх болон талууд хууль гэрээнд заасан үндэслэлээр эрх хэмжээнийхээ дагуу хэрэглэнэ. Ингэхдээ Иргэний болон Газрын хууль тогтоомжын холбогдох заалтыг үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн журмын дагуу хэрэгжүүлнэ. Субьектын эд хөрөнгөнд учруулсан хохирлыг төлүүлж болох боловч газарт учруулсан экологийн хохирлыг бүрэн хэмжээгээр арилгаж тэр бүр чаддаггүй тул иргэний эрх зүйн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлж шүүхийн практикийг боловсронгуй болгох шаардлагатай. Иргэний шинэ хуульд өмчийн төрөл, хэлбэр, өмчлөл, өмчлөлийн эрхийг хязгаарлах, өмчлөх эрхийг олж авах, үл хөпдлөх эд хөрөнгө өмчлөх, эрх дуусгавар болох тухай заасан. Энэ заасан нь газар өмчлөл, Газрын эрх зүйд нийтлэг байдлаар хамаарна. Түүнчлэн Иргэний шинэ хуульд газар өмчлөх гэсэн тусгай зүйл орсон юм. Түүнд газар өмчлүүлэгч эрхээ хэрэгжүүлэхдээ хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй гэж заажээ.

ДҮГНЭЛТ

Газрын өмчлөх эрхийн харилцаа нь нийгэм хөгжихийн хирээр хууль дүрэм нь боловсронгуй болж, түүнийг зохицуулах эрх зүйн харилцаа ч мөн адил хувьсан өөрчлөгдөж, ардчилал хөгжсөн өнөө цагт өмчлөх эрхийн асуудал дотороо газар өмчлөх эрхийн харилцааны асуудал нь ихээхэн асуудлыг эзэлдэг.

Монгол улсын Үндсэн хууль болон Иргэний хуулин дээр монгол улсын иргэн бүр газар өмчлөх, эзэмших, ашиглах, захиран

зарцуулах эрхийн талаар хуульчилан оруулсан хэдий ч өнөөдөр шүүхээр шийдүүлж газрын маргаан таслан шийдвэрлэх явц нь амьдрал дээр маш их зөрчилдөөнтэй байсаар байна. Тухайлбал: Эрх бүхий захиргааны албан тушаалтан нь хууль бус шийдвэр гарган нэг газар дээр хэд хэдэн хүнд давхардуулан зөвшөөрөл гарах тохиолдолд амьдрал дээр байдаг, мөн эрх бүхий албан тушаалтан нь зөвшөөрөл олгосон байхад Мэргэжлийн хяналтын газраас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах асуудал яригдсаар байхад нь эрх нь олгогдсон болон олгогдоогүй газар дээр тухайн иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь барилга, байшингаа барин эцэст нь шүүхээр тухайн газрыг чөлөөлөхөөр шийдвэр гардаг.

Энэ тохиолдолд уг газрыг шүүхийн шийдвэрийн дагуу албадан чөлөөлөх ажиллагаа явагддаг. Ингэж хууль бус шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаас болж жирийн ард иргэд маш их хөрөнгөө зарж үрэгдүүлэх нь амьдрал дээр нилээдгүй гарч байна. Цаашид газар өмчлүүлэх харилцааны асуудлыг боловсронгуй болгох тал дээр ялангуяа эрх олгох тал дээр нарийвчлан авч үзвэл зохистой болов уу гэж дүгнэлээ.

Хуульд нийслэлийн хэмжээнд газрын зөвшөөрөл олгох асуудлыг нэг газарт хамааруулаагүйгээс болж, дүүргийн засаг дарга нь газар олгох асуудлыг шийддэг мөн нийслэлийн засаг дарга гээд тус тус нэг газар дээр зөвшөөрөл олгохдоо хоёр хүн дээр зөвшөөрөл олгосон байдаг. Иймэрхүү маргаантай асуудал байсаар байна. Иймд эрх бүхий албан тушаалтанд олгох тал дээр анхаарвал зүйтэй болов уу.



Ж.УУГАНЧИМЭГ
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн дэд профессор, дэслэгч

НОТАРИАТЧ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНД ӨМЧЛӨГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ НЬ

Нотариатч гэдэг нь латинаар бичигч, тэмдэглэгч, нарийн бичгийн дарга гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд эрх зүйн баримт бичгийг албан ёсоор хууль зүйн талаар гэрчилж, бусад зарим үйлдэл хийж эрх зүйн талаар хангах үйл ажиллагаа эрхэлдэг хуульч юм.[1]

Нотариатч дор дурдсан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлнэ:[2]

- нотариатчаар гэрчлүүлснээр хүчин төгөлдөр, үл маргах шинжтэй болох үйлдэл, баримт бичгийг гэрчлэх;

- үйлчлүүлэгч хүсвэл нотариатчаар гэрчлүүлэхээр хуульд зааснаас бусад үйлдэл, баримт бичгийг үл маргах шинжтэй болгох зорилгоор гэрчлэх;

- гарын үсгийн үнэн зөвийг гэрчлэх;

- хууль зүйн агуулга бүхий үйлдэл, баримт бичгийг хуульд заасан тохиолдолд болон шүүх, төрийн бусад байгууллагын хүсэлтээр гэрчлэх;

- хуульд заасан бусад.

Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой баримт бичгийг гэрчлэх, баталгаажуулах, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой харилцаанд оролцох нь түүний гүйцэтгэх үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл юм.

Монгол улсад өмчийн олон хэлбэр үүсэн хөгжиж буй бөгөөд Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3-т зааснаар иргэн …үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхийг баталгаатай эдлэхийг Үндсэн хуулиар баталгаажуулж, үл хөдлөх эд хөрөнгийг эрх зүйн дагуу зохицуулах анхны үндэс бүрэлдсэн.

Хуульд зааснаар өмчлөгч нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөхтэй холбоотой гэрээг нотариатчаар гэрчлүүлэн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авснаар түүний өмчлөх эрх баталгааждаг.

Улсын бүртгэл үнэн зөв байх, өмчлөх эрх хууль ёсны байх үндэс нь өмчийг олж авч байгаа хэлбэр, өөрөөр хэлбэл гэрээ, гэрээслэл, өв залгамжлал нь талуудын хүсэл зоригийг үнэн зөв илтгэсэн байх,

[1] Т.Сэнгэдорж “Хуульч мэргэжил” УБ.,2003 он 37-р тал

[2] Нотариатын тухай хууль 4-р зүйл

хуульд нийцсэн байх, хөндлөнгийн гэрчтэй байх явдал юм.

Тиймээс Монгол улсын Иргэний хууль болон Нотариатын үйл ажиллагаатай холбогдох 75 хуулийн 173 заалтад нотариатаар заавал гэрчлүүлэх үүргийг иргэдэд хүлээлгэсэн бөгөөд нотариатч нь хуульд нотариатчаар гэрчлүүлэхээр заасан болон хуульд заагаагүй боловч иргэдийн хүссэн үйлдлийг гэрчлэх эрх зүйн үйлчилгээг үзүүлж байна.

Нотариатч нь нотариатын үйлдэл хийх явцад гэрээ, хэлцлийн утга агуулга түүний улмаас үүсэх үр дагавар тэдгээр нь хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг тайлбарлан таниулж, иргэдийн хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хуулийг хэрэгжүүлж хэвшүүлэх дадал заншлыг өөрөөр хэлбэл эрх зүйн ухамсар, соёлыг хөгжүүлж байдаг.

Хуульчдын дотроос иргэний харилцаанд оролцогчидтой хамгийн ихээр харилцдаг нь нотариатчид байдаг. Учир нь маргаангүй харилцаа маргаантайгаасаа ямагт олон дахин илүү байдаг. Энэ утгаараа нотариатчид хуулийн ололттой, дутагдалтай талууд, хэрэгжилтийг олж харж буцах холбоо болж чадах боломжтой юм.

Өнөөдөр үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой харилцааг боловсронгуй болгох асуудлаар ярилцаж байгаа болохоор, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөл өөрчлөгддөг гэрээнүүдийн талаар санал бодлоо илэрхийлэхээр бэлтгэсэн юм.

Үл хөдлөх хөрөнгийн эрхийг шилжүүлэх гэрээнд бэлэглэлийн гэрээ 50 орчим хувийг эзлэдэг байна.

Монголчууд төрөл сахандаа төдийгүй огт танихгүй хүнд ч байгаа ганц орон сууцаа бэлэглэдэг үү? гэвэл үгүй.

Ихэнх бэлэглэлийн гэрээний ард худалдах худалдан авах гэрээ явж байдаг. Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д зааснаар өөр хэлцэлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцэл хүчингүй гэж заасны дагуу бэлэглэлийн гэрээ хүчингүй болох эрсдэлтэй. Үл хөдлөх хөрөнгийн үнэ асар хурдтай өсөж байхад хэн нэгэн нь бэлэглэлийн гэрээгээ хүчингүй болгохыг хүсэх магадлал бий.

Тэгвэл яагаад иргэд ийм эрсдэлтэй гэрээ хийдэг вэ?

Худалдах худалдан авах гэрээний худалдагч тал гэрээний үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх татварыг төлөхөөр хуульд заасан учир худалдагч энэ татвараас зайлсхийхийн тулд л худалдан авагчийг ийм эрсдэлтэй байдалд оруулж бэлэглэйн гэрээ хийхийг хүсдэг.

Худалдан авагч маань удаан хугацаанд хүч хөдөлмөрөө шавхан цуглуулсан их хэмжээний мөнгөө эрсдэлд оруулж байгаагаа сайтар ухамсарлалгүй худалдагчийн

саналыг хүлээн авч заримдаа ч эргэлзэн эргэлзэн бэлэглэлийн гэрээ хийхээр орж ирдэг. Зарим хүмүүс бэлэглэлээр авсан байрныхаа талаар нилээд удаан хугацаанд ч сэтгэл зовсоор байдаг. Зарим банкууд бэлэглэлийн гэрээгээр авсан байрыг барьцаалж зээл олгохгүй ч гэдэг.

Сэтгэл зовоох бодит шалтгаан бий юу? гэвэл бий.

Тодорхой жишээ хэлье. 2008.6.13-ны өдрийн Сүхбаатар дүүргийн шүүхийн 155 дугаартай шийдвэрээр нэгэн бэлэглэлийн гэрээг хүчингүй болгосон. Бэлэглэлийн гэрээ хүчингүй болсоны улмаас бэлэглэлийн гэрээний үндсэн дээр өмчлөгч болсон өмчлөгчөөс уг байрыг худалдан авагч хохирол хүлээсэн.

Орон сууц бэлэглэх болсон шалтгаан нь гадаадад аялах виз мэдүүлэхэд үл хөдлөх хөрөнгийн баталгаа шаардагдсан. Хадам эгч нь бэлэглэлийн гэрээ хийж шилжүүлсэн. Эрх шилжүүлэн авагч маань өмчлөгч болсоноор захиран зарцуулах эрхтэй болж уг байрыг худалдсан. Гэтэл бэлэглэлийн гэрээг хийхийн өмнө хадам эгч уг байрыг худалдаж, барьцаанд тавьж болохгүй гэсэн сануулгыг бичгээр өгч хүргэн зөвшөөрсний үндсэн дээр энэхүү гэрээг хийсэн байдаг.

Иймээс шүүх Иргэний хуулийн 276 дугаар зүйлийн 276.1, 280.1.1-ийг зөрчсөн байх тул 2001.11.23-ны өдрийн бэлэглэлийн гэрээг 2008.01.18-ны өдөр хүчингүй болгосон.

Учир нь уг бэлэглэлийн гэрээ жинхэнэ бэлэглэлийн хүсэл зоригийг илэрхийлсэн буюу хариу төлбөргүй өгсөн бэлэг биш байсан, өөрөөр хэлбэл дүр үзүүлсэн гэрээ байсан байна. Эндээс гэрээ хүчинтэй байхад хүсэл зоригийн илэрхийлэл чухал юм гэж ойлгогдож байна.

Нотариатч гэрээ хийхээр орж ирж байгаа иргэдийн бодит хүсэл зориг нь юу болох, үүнээс ямар үр дагавар, маргаан, хохирол үүсэж болохыг тайлбарлан ойлгуулахад ихээхэн цаг, эв дүй зарцуулдаг, бодит жишээн дээр шүүхийн практикаас иш татан тайлбарладаг.

Гэхдээ манай иргэдийн хөнгөмсөгөөр хандах хандлага, найдах, болгоомжгүй байх, эргэцүүлж бодохгүй байх зэргээс шалтгаалан ийм алдаа гардаг. Зарим тохиолдолд манай нотариатчдын мэргэжлийн ур дүй дутагдах тохиолдол ч байдгийг үгүйсгэхгүй.

Мөн дээр хэлсэнчлэн татвараас зайлсхийхийн тулд худалдах худалдан авах гэрээг бэлэглэлийн гэрээгээр халхавчлан хийж байна.

Иймээс иргэдийг бодит хүсэл зориг дээр үндэслэсэн гэрээ хийж хэвшүүлэх, хуулийг мордүүлэх, иргэдийг эрсдэлээс хамгаалах арга зам бий юу? гэвэл бий.

1992 оны Татварын Ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт бэлэглэл, өв залгамжлалаас

татвар авах, хувь хэмжээг хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтооно” гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлээгүй өдий хүрсэн.

Татварын Ерөнхий хууль /2008 оны/ шинэчлэгдсэн ч гэсэн өөрчлөлт ороогүй, өнөөг хүртэл бэлэглэлийн татварын хувь хэмжээг тогтоогоогүй, тухайн заалтыг хэрэгжүүлээгүй байгаа нь Татварын хууль зөрчигдөхөд хүрч байна.

Татварын Ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.16 дахь хэсэгт өв залгамжлал, бэлэглэлээс татвар авахаар заасан ба хувь хэмжээг хуулийн 8.2 дахь хэсэгт зааснаар Улсын Их хурал тогтоохоор зохицуулжээ.

Гэтэл энэ хувийг тогтоогоогүйгээс л дээрх асуудал үүсч байна. Бэлэглэлийн гэрээний бэлэг хүлээн авагч тал татвараа төлдөг байхад л гэрээ бодитой үнэн хийгдсэнээр гэрээ хүчинтэй байх, сэтгэл тайван амьдрах боломжтой.

Сүүлийн үед худалдах худалдан авах гэрээ нэмэгдэх хандлагатай байгаа нь амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээтэй тэнцэх орлогыг хүн амын орлогын албан татвараас чөлөөлнө гэсэн хөнгөлөлттэй холбоотой.

Чөлөөлөгдөхийн тулд 2 хувийн татвар төлсөн баримтаа татварын байгууллагад өгөх ёстой учраас л худалдах худалдан авах гэрээ тодорхой хэмжээгээр өсч байгаа. Гэхдээ иргэний орлогын татвар төлдөггүй хүмүүсийн хувьд бас л худалдах худалдан авах гэрээ хийх сонирхол бага байдаг.

Худалдах худалдан авах гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг банкнаас зээл авч төлөх нь нилээд элбэг байгаа. Банкууд ч гэсэн худалдах худалдан авах гэрээний үнийн дүнгээр татвар төлсөн баримтыг шаарддаг байсан бол иргэд бэлэглэлийн гэрээ, худалдах худалдан авах гэрээг давхар хийхгүй байсан.

Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д зааснаар Эд Хөрөнгийн Эрхийн Улсын Бүртгэлд бүртгүүлсэн гэрээгээр өмчлөх эрх шилждэг учир бүртгэлд бүртгүүлсэн гэрээ л хүчин төгөлдөр байдаг. Банкинд худалдах худалдан авах гэрээний хувийг авчирч зээл аваад үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэхдээ бэлэглэлийн гэрээгээр шилжүүлсэн бол бэлэглэлийн гэрээ хүчингүй болсон тохиолдолд Банкны хувьд барьцааны гэрээ нь хүчингүй болж зээл эргэн төлөгдөх нь эрсдэлтэй, улсын төсвийн хувьд татварын орох ёстой байсан орлого орохгүй хохиролтой болох үр дагавар гардаг.

Үл хөдлөх хөрөнгийн борлуулалтаас улсын төсөвт нилээд хэмжээний татварын орлого орох боломжтой. Энэ боломжийг ашиглахын тулд бэлэглэлийн гэрээ, өв залгамжлалаас авах татварын хэмжээг худалдах, худалдан авах гэрээний орлогын татварын хэмжээтэй адил тогтоох, зах зээлийн дундаж үнээс доош үнэ бүхий гэрээнүүд нь бодитой үнэн зөв биш гэрээ учир эдгээр үйлдлүүдийг зогсоох механизмыг олох тухайлбал гэрээнд үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн жишиг үнийг баримтлах, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр үнийг тавьдаг болох зэрэг арга хэмжээнүүд хэрэгтэй байна.

Мөн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээн дээр өмчлөгчдийн хувийг тэмдэглэх нь өмчийг хуваах үед маргаан гарахаас сэргийлэх арга болж өгнө.

Жишээ нь: хэн нэгнийхээ аав ээжтэй хамтран орон сууц өмчилдөг гэр бүлийн хувьд хэн нэгнийх нь өв нээгдсэн бол өв залгамжлагчийн тухайн орон сууцанд эзлэх хэмжээ нь өв залгамжлалаар нэмэгддэг. Үүний дараа ямар нэгэн шалтгаанаар уг өмчийг худалдан хувиа хуваах үед өмчлөгч бүрт ноогдох хувиар хуваах нь шударга. Гэтэл гэрчилгээн дээр хувийг тэмдэглэсэн тэмдэглэл байдаггүйгээс тэнцүү хуваах тохиолдолд хүрч өв залгамжлагч хохирч болно.

Үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэхийг Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-т “Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж, нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана.” гэж, Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2-т “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана.” гэж зааснаар зохицуулж өгсөн бөгөөд энэ 2 заалтын “нотариатаар гэрчлүүлэх” гэсэн үгийг хассанаар нотариатчдаар гүйцэтгүүлж байсан иргэдийн өмчлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалах төрийн чиг үүрэг алдагдаж эзэнгүйдэхэд хүрч байна.

Энэ нь нотариатын чиг үүргийг сайтар ойлгоогүй, дутуу үнэлсэнтэй холбоотой байж болох юм. Нотариатчийн чиг үүргийг энгийнээр жишиж ойлгоё гэвэл хөндлөнгийн аудит, даатгалын байгууллагуудын болон бусад сэргийлэх, эрсдэлээс

хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэгтэй адилтган ойлгож болно.

Жишээ нь: нотариатч гэрээний талууд, хамааралтай бусад этгээдийн алиных нь ч талд үйлчлэхгүй хөндлөнгийн хяналт, гэрч болж байдаг нь хувьцаат компанийн удирдлагууд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хэрхэн хангаж байгааг хянахын тулд хөндлөнгийн санхүүгийн хяналт болох аудитын дүгнэлтийг заавал гаргуулдагтай адил.

Ирээдүйд маргаан гарах үед хуулийн хүчин төгөлдөр нотлох баримтаар өөрсдийн эрх ашгийг хамгаалахын тулд гэрээг нотариатаар гэрчлүүлдэг нь эрсдэл тулгарах үед нөхөн төлбөр авахын тулд холбогдох даатгалд даатгуулдагтай нэгэн адил.

Шүүх нь эрхийн хамгаалалтын шүүхийн хэлбэр бол нотариат нь эрхийн хамгаалалтын шүүхийн бус хэлбэр юм.

Нэгэнт зөрчигдсөн эрхийг сэргээх нь эрх зөрчигдөхөөс сэргийлэхээс илүү ажиллагаа шаарддагддаг учир маргаанаас урьдчилан сэргийлэхэд их ач холбогдол өгдөг. Урьдчилан сэргийлэх нь засан залруулахаас ямагт хялбар байдгийг хамгийн энгийн жишээгээр амьдралын олон тохиолдолд бид нэрлэж чадах билээ.

Жишээ нь: Замын хөдөлгөөнд оролцохдоо замын хөдөлгөөний дүрмийг ягштал биелүүлдэг бол аваар осол, хохирол үзэхгүй гэдгийг заалгаж шалгалт өгдөг боловч амьдралд мөрддөггүй учраас багаар хэлэхэд гацаанд орж ажлаа алддаг, ихээр бол осолд орж эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирдог. Иргэдээ хамгаалах, аваар ослосс урьдчилан сэргийлэхийн тулд Замын цагдаа ажиллаж байдаг бол нотариатч Иргэний хууль болон холбогдох хуулийг дагаж мөрдүүлэх, эрх зүйн харилцааг аюулгүй байлгах, иргэдийг хохирохоос урьдчилан сэргийлж байдгаараа Замын цагдаатай тун адил чиг үүргийг гүйцэтгэж байдаг гэж ойлгож болно.

80 гаруй жилийн түүхтэй Монголын нотариатын байгууллага шинэчлэгдэн 1997 онд Нотариатын тухай хууль батлагдан гарсаны дагуу чиг үүргээ гүйцэтгэж буй нотариатын байгууллага, нотариатч 10 жилийн өмнөхтэй харьцуулбал өсөн хөгжиж, эрх зүйн туслалцаа үзүүлдэг хамгийн дөт байгууллага, иргэдийн дотны зөвлөгчид болон төлөвшиж байна.

Гэвч бидэнд төрийн үйлчилгээг улам чанартай, өндөр түвшинд гүйцэтгэх, орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхах, мэдээллийн технолгийг нэвтрүүлэх, үйлчилгээний орчинг орчин үеийн, үйлчлүүлэгчдийнхээ шаардлагад нийцүүлэх шаардлага тавигдсаар байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн гүйлгээнд нотариатаар заавал

гэрчлүүлэх шаардлагыг тавьснаар иргэн, хуулийн этгээдийн амин чухал өмчлөх эрхийг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх үүний тулд зөвхөн хууль ёсны өмчлөгчийн хүсэл зоригийн үндсэн дээр шилждэг эрхийг нотариатч гэрчилсний үндсэн дээр шилжүүлэх, зөрчигдсөн тохиолдолд шүүхээр учирсан хохирлоо арилгуулах үед зөвхөн нотариатаар гэрчлүүлсэн гэрээ нь хууль ёсны нотлох баримтын хэмжээнд үнэлэгддэг байх хуулийн шаардлагыг хангуулж байх ач холбогдолтой.

Нотариатчийн чиг үүрэг өнөөгийн нөхцөлд бие даасан шинжтэй болсон нь түүний оролцоотойгоор бүрдүүлсэн баримт бичиг хүлээн зөвшөөрөгдөж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дугаар зүйлд зааснаар нотлох баримтын болон түүнийг гүйцэтгүүлэх хууль зүйн хүчин чадлыг бүрэн агуулж, нийтийн итгэл хүлээх болсонтой холбоотой юм.

Нотариатын үйлдлийн чанар зохих түвшинд байхын тулд нотлох баримт гарцаагүй үнэн байхын тулд бид мэдээллийн санд холбогдох шаардлагатай байдаг.

2007 оны 6-р сарын 27-28 ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг сэдэвт олон улсын бага хуралд Ази Европ Австрали тивийн 20 гаруй улс орон оролцож илтгэл тавихад Гүрж улсын бүртгэлийн газрын дарга хатагтай Лиа Чантура-гийн тавьсан илтгэлд “Гүржийн Улсын бүртгэлийн газар нь тусгай боловсруулсан веб хэрэглээний тусгай программын тусламжтайгаар банк, санхүүгийн байгууллагууд, нотариатч нар, төрийн болон холбоотой ажилладаг хувийн хэвшлийн байгууллагууд бүртгэлийн газартай шууд холбогдох боломжтой байдаг” гэсэн нь бидний хүрч болох чухал зорилтуудын нэг болоод байна.



С.ОЮУНЧИМЭГ
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, ахлах дэслэгч

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ, ШИНЭЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсын Үндсэн хуульд “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, хүн бүрийн амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй байхыг тунхаглаж, төр нь хүний эрхийг баталгаатай хангах үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. Гэсэн хэдий ч нийгэм дэх гэр бүлүүдийн дунд хүчирхийлэл буурахгүй байна

Гэр бүлийн хүрээн дэх эрхийг хамгаалах, нийгэмд тогтсон сөрөг үзэлтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох талаар эрх зүйн асуудалтай холбогдох харилцааг хуулиар хэрхэн зохицуулж байсан талаар авч үзье.

1999 онд баталсан Гэр бүлийн тухай хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл” гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн бөгөөд гэрлэгсэд бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх[1], гэрлэгсдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан эсхүл, учирч болзошгүй бол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйлгээр гэрлэлтийг цуцалж болохоор заасан. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлийн “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ” гэсэн хэсэгт “гэрлэгсдийг тусдаа амьдрахыг даалгах” гэсэн заалт шинээр орсон нь хүчирхийлэгчийг тусгаарлах асуудлыг шийдвэрлэх зохицуулалт болж байсан юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчил, маргааныг ИХШХШ, Эрүүгийн, ЭБШ, Захиргааны хариуцлагын тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулийг удирдлага болгон шийдвэрлэж буй нь хүчирхийллийг шийтгэх, гэр бүл цуцлах зэрэг үр дүн муутай арга хэмжээ болж, хүчирхийлэл улам даамжирсаар л байна.

Ийм энэ харилцааг зохицуулахын тулд 2004 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг баталж, 2005.01.01-

нээс мөрдөж эхэлсэн. Энэ хуулиар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний оролцоог тодорхойлох, хохирогчийн эрхийг хамгаалах, болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өмнөх хуулиудаар тодорхойлоогүй байгаа хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэгчид хүлээлгэх хариуцлагын шинэ хэлбэрийг буй болгох, зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн албадлагын арга хэмжээ хэрэглэх зэрэг шинэлэг зохицуулалтууд хуульчлагдсан байгаа хэдий ч:

❖ Уг хуулийн 3 дугаар зүйлд хуулийн зохицуулалтад хамаарах этгээдийн хувьд хэтэрхий ерөнхий дурьдсан

❖ 4 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаандаа баримтлах зарчмын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн II бүлэг, 16 дугаар зүйлд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдсэн зарим зарчмыг орхигдуулсан

❖ 5 дугаар зүйлд хуульд орсон нэр томъёоны тодорхойлолтыг оновчгүй тайлбарласан. Тухайлбал:

- "Гэр бүлийн хүчирхийлэл" гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг;

- Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас гэр бүлийн гишүүн амь насаа алдсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж, "Эрүүгийн хууль"-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхой/

- "Болзошгүй хүчирхийлэл" гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгааг;

- Тодорхойлж буй зүйл нэр томъёо нь тайлбартайгаа нийцэхгүй байна,

- /Болзошгүй хүчирхийлэл гэдгийг **"хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдал"**хэмээн солин найруулах/ гэх мэт.

❖ 6 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг задлан тайлбарлаж тодорхой болгоогүй

❖ Хоёрдугаар бүлэгт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүргийг дурьдахдаа хэрэгжүүлэх чиг үүргийн зарим нь аль байгууллагад хамаарахыг тодорхой болгоогүй. Тухайлбал: Цагдаагийн байгууллага гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох үүднээс хохирогчийг хамгаалах

[1] "Гэр бүлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйл 3 дах хэсэг

байранд хүргэх, улмаар төрөл садангын хүмүүсийг түр хамгаалалтанд шилжүүлэх үүрэгтэй гэж заасан бөгөөд энэ чиг үүрэг нь Засаг даргын бүрэн эрхтэй агуулгын хувьд ижил байна. Хохирогчийг хамгаалах байранд хүргэх, төрөл садангын хүмүүсийг түр хамгаалалтанд үлдээх чиг үүрэг ямар тохиолдолд, аль байгууллагад хамаарах нь тодорхой бус байна[2]

❖ 19 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага хэтэрхий ерөнхий, нарийвчлан тусгагдаагүй зэрэг алдаа дутагдал байгаа нь судалгааны явцад тогтоогдсон.

2004 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль нь уг асуудалд холбогдох нийгмийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа төдийгүй хүчирхийлэлтэй холбогдолтой гэмт хэргийн гаралт төдийлөн буурахгүй байсан. Иймээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг шинэчилэн найруулах болсон нийгмийн хэрэгцээ шаардлага бий болсон. Тухайлбал:

➢ 2004 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль дангаараа батлагдсан, өөр хуулиудтай уялдаагүй учраас бодит амьдралд бууж хэрэгжих нь муу байсан. Тухайлбал: Хохирогч хуулийн хамгаалалт авъя гэхээр иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаад 60 хоногийн дотор шийдэгдэх гэсээр байтал амиа алдах,гэмтэж бэртэх, гарсан шийдвэр нь шийдвэр гүйцэтгэл дээр очоод биелэгддэггүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулинд “тусдаа амьдрах” гэсэн шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх, хохирогчтой харилцаа тогтоохоор оролдсон бол яаж хянах заалт байгаагүй зэргийг дурдаэ болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх 2004 оны хуулийг шинэчлэн найруулах ажил 2011 оноос эхэлсэн. 2011 онд хамгийн анх Засгийн газрын ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхэлсэн бөгөөд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2016.12.22-ны өдөр батлагдаж, 2017.02.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээр хуульчлагдсан. Шинээр батлагдан гарсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийг шинэчилсэн найруулгын давуу талыг дурдвал :

✓ Уг хуулийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэлд хамаарах этгээдүүдийг тодорхой дурьдсан бөгөөд илүү өргөн хүрээнд авч үзэх болсон. Тухайлбал: Өмнө нь салсан эхнэр, нөхөр гэх мэт хүмүүс энэ

[2]ХСИС, “Эрх зүйн процесс: онол, практик” /эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл/”, УБ хот, 2015 он, 161 дэх тал

хуулийн хамгаалалтад ордоггүй байсан. Хамтран амьдарч байгаад больсон хосууд, дундаасаа хүүхэдтэй, гэр бүлийн баталгаагүй хүмүүсийн хооронд хүчирхийлэл үйлдэгдвэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль үйлчилдэггүй байсан.

✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиилагаанд баримтлах зарчмыг улам боловсронгуй болгосон. Тухайлбал:

- хохирогчийн нэр төрийг хүндэтгэх
- салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх
- нууцлалыг хамгаалах гэх мэт.

✓ 6 дугаар зүйлд Гэр бүлийн хүчирхийллийн төрлүүдийг нэлээд дэлгэрүүлж тайлбарласан.

✓ Хоёр дугаар бүлэгт “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо”-г боловсронгуй болгож оруулсан бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, хохирогчийг хамгаалах зэрэг үйл ажиллагаанд заавал оролцох субьектүүдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчилсан нь хууль хэрэгжих баталгаа болж байна. Үүнд: Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, албан тушаалтан хамрагдахаас гадна шинээр боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын эрх, үүргийг дурьдаж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой

✓ Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг мөн адил нарийн хуульчилж өгснөөс **иргэнд үүрэг болгосон зохицуулалт** орж ирсэн. Мөн гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нууцыг чандлан сахиж, болзошгүй эрсдлээс хамгаалах зэрэг зохицуулалт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэхэд чухал байр суурийг эзэлнэ. Харин мэдсээр байж мэдээлэл өгөөгүй, иргэнийхээ үүргийг биелүүлээгүй тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хуулинд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох шийтгэлийг хуульд оруулсан.

✓ Гэр бүлийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалах зохицуулалт шинээр орж ирсэн /2004 оны “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулинд энэхүү заалт байгаагүй/ нь ихээхэн ач холбогдолтой. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл, түүний нөлөөнд бий болж байгаа гэр бүл салалт нийгэмд ихээсээр байна. Үүний гол хохирогч нь хүүхэд болж үлддэг. Тэдний эрх ашгийг хамгаалах механизм нийгэмд зайлшгүй шаардлагатай байна.

✓ Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ. Энэ нь тухайн нөхцөл байдал дахь

хүчирхийллийн хэлбэр, амьдрах орчин дахь эрсдэл, хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох ач холбогдолтой

✓ Хохирогчид үзүүлэх үйлчилгээний шинэ механизм бий болсон. Хүчирхийлэгч тэжээгч гэдэг үндэслэлээр хариуцлагаас мултрахгүй. Хохирогчийн амьдралын баталгааг хангах зорилгоор хуульд заасан үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэх үүрэгтэй. Тухайлбал: /Уг хуулийн 5 дугаар бүлэг/

- эмнэлгийн тусламж, үйлчилгээ
- нийгмийн халамжийн үйлчилгээ
- холбон зуучлах үйлчилгээ гэх мэт

✓ Гэр бүлийн зөрчлийн асуудлаа хүчирхийллийн бус аргаар шийдэхэд суралцуулах, өөрийнхөө бурууг ойлгож засах үүний дараагаар гэр бүлдээ очих боломжийг олгох зорилгоор зан үйлд нь нөлөөлөх сургалтыг зохион байгуулахаар хуулинд тусгагджээ. Өөрөөр хэлбэл: Энэхүү хууль нь хүчирхийлэл үйлдлээ гээд нэг бол гэрлэлтийг нь шууд цуцлах эсвэл хүнд ял эдлүүлэхээс аль болох татгалзах, эргээд хүчирхийлэлтэй харилцаанаас салах боломжийг гэр бүлд олгох зорилготой хууль юм.

Сайн дурын болон албадан сургалт гэсэн хоёр хэлбэртэй байх юм. Сайн дурын сургалт ял шийтгэлийн журмаар биш албадан нь ял шийтгэлийн журмаар. Өнөөдөр сайн дурын сургалтад сууя гэсэн хүмүүс зөндөө ирдэг. Би асуудлаа шийдэхээсээ өмнө түрүүлээд эхнэр рүүгээ гар далайчихаад болдоггүй ээ. Үүнийгээ яаж засах вэ гээд өөрийгөө мэдрээд байгаа хүмүүс бий.

✓ Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо өөрчлөгдсөн. Тухайлбал: Өмнө нь гэр бүлийн хүчирхийллийг иргэд хоорондын маргаантай адилхан шийдвэрлэдэг байсан. Эдийн засгийн, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдсон бол шүүхээр асуудлаа шийдүүлдэг байсан. Одоо бол **гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн ноцтой зөрчил** гэж үзэж гэмт хэрэгт тооцох болсон. Гэмт хэрэгт тооцогдохоргүй үйлдлүүдийг “захиргааны зөрчил” гэж үзнэ. Ялгамжтай ял, шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг дагалдаад, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд орсон өөрчлөлтөөр энэ зохицуулалтуудыг хийсэн. Захиргааны хариуцлагын тухай хуулинд зөрчил ба гэмт хэргийг заагласан. Зөрчилд зодох, хүсэл зоригийнх нь эсрэг албадах, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох, эд хөрөнгө эзэмших, ашиглах захиран зарцуулах эрхэд халдах гэх мэт 7 үйлдэл Захиргааны

зөрчил болсон. Хэрэв энэ үйлдлүүдээ давтан хийсэн тохиолдолдэрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэдгийг хуульчилсан. Захиргааны зөрчилд 7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулна, гэмт хэрэг үйлдсэн бол эхний удаа, хөнгөрүүлэх нөхцөлтэй бол 1-6 сар хүртэл баривчлах, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй, жирэмсэн эмэгтэйг зодох, хүүхдийг байнга зодсон тохиолдолд хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялтай.

Хэрэг шалгах явцад хохирогчийг заналхийлдэг, өргөдөл гомдлоо буцаагаад авахыг дарамталдаг. Үүнийг зогсоох зорилгоор Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулсан. Хохирогчид тодорхой зайд ойртох, ажлын байран дээр нь очих дарамтлахыг хориглосон. Хэрэв тогтоосон хязгаарлалтыг зөрчвөл цагдан хорих гэх мэтээр дараагийн арга хэмжээг авна гэсэн шинэлэг зохицуулалтуудыг тусгаж өгсөн нилээд шинэлэг зохицуулалт болсон байна.



П.ЭРДЭНЭБААТАР
ХСИС-ийн
Цагдаагийн
сургуулийн мөрдөх
албаны тэнхимийн
багш, цагдаагийн
дэд хурандаа

ХЭРЭГ МӨРДӨХ АЖИЛЛАГААГ ТҮҮВЭР ТӨЛӨВЛӨГӨӨ АШИГЛАЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Товч утга: Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад түүвэр төлөвлөгөөг ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлох, байцаалтын зорилтыг тодорхойлох, хэргийг богино хугацаанд шийдвэрлэх арга замыг тодорхойлох, үйл ажиллагааг оновчтой болгох, талаар авч үзсэн болно

Abstract:.In this abstract, I have written about how to prove a suspect guilty, determine investigation purpose, and identify a shortcut to finding a solution to the crime, and to make investigation process run smoothly by using selection planning technique properly in the investigation period.

Түлхүүр үг: Төлөвлөгөө, түүвэр, товчлол, нотлох баримт, тактик, сэжиг, таамаглал, байцаалт, баримт бичиг,

Keywords: planning, selection, shortcuts, evidence, tactics, suspicion, hypothesis, questioning, documents,

Төлөвлөгөө нь үйл явцыг удирдан зохион байгуулж буй субъектын гаргасан шийдвэрийг тусгасан албан ёсны баримт бичиг юм[1].

Хүн ямар нэгэн ажлыг хийж бүтээхийн тулд хийх зүйлийнхээ талаар тодорхой мэдлэгтэй, эмх цэгцтэй, дэс дараалал, төлөвлөгөөтэй ажилллавал ажил шуурхай явагдаж бүтээл гардаг.

Мөрдөн байцаалтын ажиллагааны явцад эмх цэгц, эрэмбэ дараалал, тактикийн тодорхой төлөвлөгөөгүйгээр ерөнхий хандвал бүтээл гардаггүй.

Төлөвлөгөөний агуулга нь өргөн утгатай ойлголт бөгөөд мөрдөн байцаалтыг эхнээс нь эхэлж дуустал үргэлжүүлэх бүтээлч зохион байгуулалттай үйл ажиллагааний нийлбэр цогц[2] гэж үздэг.

Мөрдөн байцаалтын төлөвлөгөө нь мөрдөн байцаалт болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тодорхой үе шат бүрт шийдвэрлэвэл зохих зорилт, түүнийг шийдвэрлэх ажиллагааны арга, тактикийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга замыг сонгон явуулах ажиллагаа юм.

Мөрдөн байцаалтын төлөвлөгөө нь ажлын ачаалалыг тэнцвэржүүлж

[1] Менежмент. УБ., 2000. 102 дах тал
[2] Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх аргачлал. УБ., 2010. 182 дахь тал

тухайн хэрэгт хяналт тавих боломжийг хангаж өгөх, үйл ажиллагааг оновчтой болгох, хууль ёсыг зөрчихгүй байх үндсэн нөхцөл болдог.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь хуулиар тогтоогдсон үндэслэл, журмын дагуу явагддаг учраас хариуцлагагүй, анхааралгүй хандвал хуулийг завхруулж, иргэний хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж хохирол учруулах аюулд хүргэдэг.

Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд мөрдөн байцаалтын тактикийг сайн бодож боловсруулах, гэмт хэргийн сэжиг, таамаглалыг нэг бүрчлэн нарийг шалган тогтоох хэрэгтэй болдог. Мөрдөн байцаалтын арга, тактик нь мөрдөн байцаалтын ерөнхий болон байцаалтын төлөвлөгөөнд бүрэн тусгагдсан байхыг шаарддаг.

Хэргийн түүвэр төлөвлөгөөг мөрдөн байцаагч хэргийн материалыг эмхэтгэж ангилан цэгцэлсэний дараа ангиллалыг эхнээс нь уншиж товч түүвэр хийнэ.

Хэргийн материалыг нэг бүрчлэн тодорхой судалж ойлгохгүйгээр, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн дүүрэн шуурхай хийх боломжгүй, ялангуяа хүнд, онц хүнд гэмт хэргийн материалыг ганц уншаад цээжээр мэднэ гэж байхгүй юм.

Мөрдөн байцаалтыг эрхлэн явуулж буй субъект нь олон төрлийн гэмт хэрэг дээр ажилладаг учир мартах, самуурах байдалд орж болох бөгөөд хэргийн материал нэг бүрийг хэд дахин уншиж судлах, түүвэр, товчлол заавал хийх шаардлага тулгарна.

Практик амьдрал дээр хэргийн түүвэр төлөвлөгөө хийх олон арга хэлбэр байдаг, гэвч дараах зүйлд анхаарал хандуулах нь зүйтэй юм. Үүнд:

1. Нуугдмал үйлдэлтэй, хүнд, онц хүнд, онц их хэмжээний хохиролтой олны анхаарал татсан гэмт хэрэгт он тус бүрээр нь ялган түүвэр хийх

2. Хэд хэдэн этгээд нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсвэл нэг этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн [3] яллагдагчтай хэрэгт холбогдогч бүрт чиглэгдэж цугларсан нотлох баримтуудыг тус тус ялган түүвэр хийх

3. Хэргийн талаар онцлог нотлох баримт, гэрчийн мэдүүлэг, яллагдагчийн мэдүүлэг зэргийг он, сар, өдрөөр нь тавьж түүвэр хийх

Хэргийн түүвэр төлөвлөгөө гэдэг нь товчлол хийхийг хэлэх бөгөөд хэргийн нотлох баримт, материалыг хэд дахин судалж ерөнхий болон байцаалтын төлөвлөгөө хийхэд ач холбогдолтой байдаг.

Хавтаст хэргийн дотор байгаа нотлох баримт бүрийг харьцуулан, шинжлэн судлаж, цугларсан материалаар батлагдсан нотлох баримтууд, шалган тогтоох сэжиг, таамаглал бүрийг товчилж түүвэр хийнэ. Харин хэргийн материалын

нотлох баримт, нэг бүрийг сайн судалж товчлол хийчихээд түүндээ найдаж хавтаст хэргийг нотлох баримтыг дахин нягтлан үзэлгүй зөвхөн түүвэр төлөвлөгөөндөө найдан төлөвлөсөн зүйлийхээ биелэлтийг шалгахгүй ажиллавал алдаа дутагдал гарах магадлалтай юм.

Иймээс түүвэр төлөвлөгөө нь мөрдөн байцаагчийн ойлголтыг тодорхой дэс дараалалтай эмх цэгтэй хийх хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн бодитой тогтооход ач холбогдолтой юм. Мөрдөн байцаалтын ажиллагаа нь цаг хугацааг өрсөж тасралтгүй давшингуй явагддаг тул ямар ч асуудал шинээр тавигдах, үгүйсгэгдэж, батлагдаж байдаг тул тэр бүрийг төлөглөгөөнд тусгагдсан байхыг шаарддаг онцлогтой.

Мөрдөн байцаалтын хэргийн процессын ажиллагааг хөтлөх тэмдэглэлийг хэрэг бүрт хөтөлнө[4]. Үүнд:

1. Мөрдөн байцаалтын хэрэгт сэжигтэн, яллагдагч, хохирогч, гэрч зэрэг хичнээн хүнээс мэдүүлэг авсан байх

2. Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авалгүй ямар цаг хугацаа өнгөрч байгаа эсэх

3. Хэзээ эрүүгийн хэрэг үүсгэсэн, хэзээ ямар зүйл ангиар яллагдагчаар татаж ял сонсгосон, сонсгосон ялыг өөрчилсөн эсэх

4. Сэжигтэн, яллагдагчийг батлан даалтанд өгсөн, хорьсон, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, хүчингүй болгосон хугацаа

5. Хэргийн хугацаа болон хорьж мөрдөх хугацаа хэтэрсэн эсэх

6. Хэрэгт хяналт тавьж байгаа албан тушаалтан

7. Хэргийг шүүхээр шийдвэрлэхээр гаргасан санал

8. Хэрэг ач холбогдол бүхий оролцогч нарын нэр, хаяг, утасны дугаар гэх мэт.

Мөрдөн байцаалтын ерөнхий төлөвлөгөөг дор дурдсаны дагуу хийнэ. Үүнд:

1. Хэргийн түүвэр товчлолыг уншиж шалгах, сэжиг, таамаглалыг тодруулах онцлогууд болон мэдүүлэг нэг бүрийн зөрүүг нэг бүрчилэн шалгаж тэмдэглэж хэзээ яаж шалгахыг төлөвлөгөөнд бичих

2. Хэргийн материалд байгаагүй боловч уг хэргийн талаар хууль ёсоор хийгдвэл зохих зүйлийг төлөвлөгөөнд бичих. Жишээ нь: Тогтоол, ял шийтгэл шалгуулах, шинжилгээ томилох зэрэг

3. Шинээр болон дахин байцаах гэрч, шинжээч, хохирогч, сэжигтэн, яллагдагч

4. Шинээр буюу дахин хийх үзлэг, нэгжлэг, нүүрэлдүүлэн байцаалт, мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагаа, хөрөнгө битүүмжлэх ажиллагаа

[3] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

[4] Улсын мөрдөн байцаахгазрын даргын 2009 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 17 тоот тушаалын долдугаар хавсралт.

5. Албан байгууллага хүнээс шаардан гаргуулж авах хэргийн холбогдолтой эд зүйлс

6. Хөдөө, орон нутаг, аймаг, хотод байгаа гэрч, хохирогч, яллагдагчийг дуудан ирүүлэх буюу мөрдөн байцаалтын даалгавар бичих

7. Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн талаар нэмж тогтоовол зохих байдлууд

8. Шинжилгээ заавал хийлгэх[5]

9. Гэмтлийн зэрэг тогтоох

10. Байцаалтанд орчуулагч, хэлмэрч, оролцуулах

11. Гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг бусад олдоогүй байгаа нотлох баримтыг цуглуулах, эрэн сурвалжилж олох ажиллагаа

12. Гэмт хэргийн эд мөрийн болон схем, дуу, дүрс бичлэг, гэрэл зургийг авах ажиллагаа

13. Цагаатгах болон яллах нотлох баримтыг шалган үзэх

14. Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээллийг шалгуулах, даалгавар, захилга өгөх

15. Шинжлэх техникийн арга ажиллагаа хийх, ул мөр, гарын үсэг, тамга, тэмдэг хуурамч бичиг баримтыг шалгуулах

16. Нягтлан бодох, бусад шинжилгээ томилох тухай зэрэг зайлшгүй хийгдэх асуудлыг төлөвлөгөөнд тусгана.

Байцаалтын төлөвлөгөө нь яллагдагч, гэрч хохирогч, шинжээч болон бусад оролцогчдоос мэдүүлэг авах арга тактикийн асуудлыг дэс дараалалтай боловруулж байгаа хэрэг юм. Ийм учраас байцаалт явуулахын тулд заавал төлөвлөгөө хийнэ.

Мөрдөн байцаагч нь зөвхөн хэргийн материалаар хязгаарлахгүй уг хэргийг юунаас эхлэн яаж шалгах, эхлэж хэнээс мэдүүлэг авах ямар асуултыг ямар дэс дараалалаар асуух, дараагийн мэдүүлэгт ямар асуулт тавих, мэдүүлэг өгч буй хүний хувийн онцлог байдал, хэрхэн хандаж асуулт тавих зэргийг урьдаас бодож боловсруулна.

Ялангуяа нүүрэлдүүлэн байцаахад хэнээр эхлэн яриулах, ямар асуудлыг тодруулах дэлгэрэнгүй буюу зарим зүйлийн талаар нүүрэлдүүлэх тухай урьдаас боловсруулан төлөвлөнө.

Хэргийн болон байцаалтын төлөвлөгөө нь мөрдөн байцаалтын арга, тактикийг боловсруулж байгаа зүйл учраас олон талаар сайн бодож хийх шаардлага тулгардаг байна. Жишээ нь: Цаг хугацаа нь болоогүй асуудлыг эхлээд ил гаргаж тавих юм уу? Цаг хугацаа алдах юм бол асуудлыг хүндрүүлдэг тохиолдол их гардаг байна.

Төрөл садан болон дотны хүмүүс нүүрэлдүүлэн байцаалт өгөх сонирхолгүй, нүүрэлдүүлэн байцаалт өгсөн боловч урьдах мэдүүлэгээсээ буцаж магадгүй, бас зарим хүн өш

[5] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ.,2002

хонзон санахаас айж нүүрэлдэн байцаалтанд оролцохыг хүсэхгүй байдаг, ийм тохиолдолд мэдүүлгийг дүрс бичлэг, дуу хураагуурийн техник хэрэгслийг ашиглан авах хэрэгтэй юм.

Мөрдөн байцаагч нарын дунд хэргийн түүвэр төлөвлөгөөг хөтлөхөд практик амьдралд дор дурдсан хүндрэлүүд тохиолдож байна[6]. Үүнд:

1. Мөрдөн байцаагч нарын хэргийн түүвэр төлөвлөгөөг 60% нь хүндрэлгүй үйлдэж сурсан байдаг боловч 40% нь хүндрэлтэй байдаг талаар дурдсан байна.

2. Хэргийн түүвэр төлөвлөгөөг ажлын үзүүлэлт төдий байдлаар хэрэгжүүлдэг гэж 70% үзэж байхад 30% нь тийш биш гэж үзэж байна.

3. Шалгах болон түүвэр төлөвлөгөөг 50% агуулгын хувьд ялгаатай гэж үзэж байхад 50% нь адил төсөөтэй гэж үздэг.

4. Түүвэр төлөвлөгөө хийснээр мөрдөн байцаагч нарын ажлын үзүүлэлтэнд 20% нь нөлөөлөл байдаггүй, 30% нь ажил дүгнэх үзүүлэлт болдог, 50% нь түүвэр төлөвлөгөө нь дарга нарт үзүүлэх хэлбэрийн төдий зүйл гэж үзсэн байна.

5. Эрүүгийн хэрэгт 50% нь түүвэр төлөвлөгөөг хийснээр хэрэг шалгах ажиллагаа шуурхай бодитой явагддаг гэж үзэж байхад, 10% нь үгүй, 40% нь зарим талаараа гэж үздэг байна.

[6] Мөрдөн байцаах газрын тайлан мэдээ. 2015-2016 оны тайлан.

ДҮГНЭЛТ

1. Практик амьдралд мөрдөн байцаагч хэргийн түүвэр төлөвлөгөөнд төлөвлөсөн зүйлийхээ биелэлтийг бүрэн дүүрэн биелүүлж чадахгүй болсон шалтгаан нөхцөл түүнийхээ үндэслэлийг бичдэггүй, эсвэл биелэгдсэн тохиолдолд яаж биелэгдсэн талаар дэлгэрэнгүй хөтөлдөггүй, төлөвлөгөөний биелэлтийг "биелэсэн", "биелээгүй", он, сар, өдөр, хугацааг тодорхой бус хөтөлдөг явдал нилээдгүй түгээмэл дутагдал байдаг тул зөвлөмж боловсруулж ашиглах

2. Түүвэр төлөвлөгөөг сургалт, үйлдвэрлэл, практикт байнга боловсронгуй болгож байх ямар нэгэн бүтээл, санал шүүмж байхгүй байгаад анхаарал хандуулах.

3. Хэргийн түүвэр төлөвлөгөө хийх загварыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх.

САНАЛ

1. ЦЕГ-ын Мөрдөн байцаах газрын даргын 2009 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 17 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Эрүүгийн хэргийн түүвэр болон шалгах төлөвлөгөөний загвар нь 2 загвар байх бөгөөд онол, шинжлэх ухааны үндэслэл муутай, амьдралд хөтлөхөд зарим талаараа учир дутагдалтай зүйл ажиглагдаж байгааг анхаарч боловсронгуй болгох

2. Хэргийн түүвэр төлөвлөгөө болон шалгах төлөвлөгөө учир холбогдлыг тайлбарласан загварчлал, стандартыг боловсруулах шаардлага тулгарч байна.